

Шинжлэх ухаан танин мэдэхүйн
“ДОРНО ДАХИНЫ УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААН”
СЭТГҮҮЛ

Улаанбаатар хот
2015 он

**ШИНЖЛЭХ УХААН ТАНИН МЭДЭХҮЙН “ДОРНО ДАХИНЫ УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААН” СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ**

Тэргүүлэгчид:

Д. Цэрэндагва	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, АУ-ны доктор, профессор, академич
Ч. Чимэдрагчаа	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, АУ-ны доктор, профессор
Д. Цэнд-Аюуш	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, АУ-ны доктор, дэд профессор
Б. Цэрэнцоо	Хариуцлагатай нарийн бичиг, АУ-ны доктор

Гишүүд:

С. Олдох	Ерөнхий эрхлэгч, АУ-ны доктор, профессор
Б. Дагвацэрэн	Академич АШУ-ны доктор, профессор
Н. Сүмбэрзул	АУ-ны доктор, профессор, академич
Б. Дагданбазар	АШУ-ны доктор, профессор, академич
Б. Саранцэцэг	АШУ-ны доктор, профессор
С. Сээсрэгдорж	АУ-ны доктор, профессор
Н. Бира	АУ-ны доктор, профессор
С. Цогтсайхан	АУ-ны доктор, профессор
С. Хишигжаргал	АУ-ны доктор, дэд профессор
П. Молор-Эрдэнэ	АУ-ны доктор

Дугаарыг эрхлэн гаргасан:

Б.Баярмаа	АУ-ны магистр
-----------	---------------

Өмнөтгөл үг

Өнөөдөр би “Дорно дахины анагаах ухаан” сэтгүүлийн тусгай дугаарын өмнөтгөл үгийг бичиж сууна. Сэтгүүлийн энэ дугаарыг бид бүхэнтэй хамтарч ажиллаж гялалзаж явсан хэдий ч бидний дунд үгүйлэгдэж, хүндлэгдэхийн их дурсамжийг үлдээгээд явсан Я.Ганбаяр агсаны 50 насны ойд зориулж байгаа юм. Миний бие энэхүү ойн үйл ажиллагааг зохион байгуулах хэсгийн ахлагчаар ажиллаж байгаа учраас өмнөтгөл бичих нь үүрэг гэж ухамсарлаж байна.

Монгол Анагаах Ухааны Институтийн хамт олон тус сургуульд олон жил үр бүтэлтэй ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа багш, судлаачдын насны тэгш ойг тэмдэглэн тэднийхээ хийж бүтээсэн бүтээл, туурвилыг сурталчилах, хамт ажиллаж байсан эрдэмтэд, багш, эмч нарын дурсамж дуртатгал сэтгэгдлийг хойч үедээ өвлүүлж үлдээх зорилго тавьж ажиллаж байна. Өнгөрсөн 5 сарын 16- д уламжлалт анагаах ухааны дэг сургуулийг үндэслэн байгуулагч МАУА-ийн гишүүн, академич Монгол Улсын хүний гавъяат эмч, доктор, профессор Н.Төмөрбаатар багшийн нэрэмжит эрдэм шинжилгээний хурлыг анагаах ухааны сургуулийн оюутнуудын дунд зохион байгууллаа.

Одоо анагаах ухааны доктор Я.Ганбаярын 50 насны ойг тэмдэглэж өнгөрүүлэхээр ажиллаж байна. Өнөөдөр эргээд бодоход Я.Ганбаяр асан бидний энэ хорвоод тун цөөхөн жил амьдраад буцах хугацаандаа хүн байхын, бүтээж туурвихын, үлгэр дууриаллын, мэдлэг, ур чадварын сайхан дурсамжуудыг тэгш дүүрэн үлдээсэн нь нэг талаас бахархууштай ч нөгөө талаар гунигийн харуусал үргэлжилсээр байгааг илтгэж байна.

Я.Ганбаяр агсаныг миний бие мэдлэг, ур, чадварынхаа үндэс суурийг удам судрынхаа сайхан хүмүүжил дээр тулгуурлаж өөрийнхөө хичээл зүтгэлээрээ тэгш сайхан тавьж түүнийгээ өдөр тутам баяжуулан хөгжүүлсэн хамтарч ажиллахад түшигтэй, шавь нартаа үлгэр дуурайл бахархал болсон нэгэн байсан гэж боддог.

Тэрээр уламжлалт анагаах ухааны үндэс суурийг “Язгуур үндэс”, “Уламжлалт анагаах ухааны онол” дээр гүн бат суурилж хөгжүүлсэн хэзээч ямарч асуудалд барьц алдаад байхааргүй мэдлэг оюуны хийгээд ур чадварыг бий болгож чадсаны зэрэгцээ уламжлалт анагаах ухааны эмчийн мэргэжлийн ёсзүйн гүн нарийн иш онол бүхий цэгц сургаалыг амьдралынхаа учир утга болгож чадсан нэгэн байлаа.

Я.Ганбаяр агсан багш хүний эрхэм сайхан чанарыг багш, шавийн барилдлагын сургаал ёсоор дагаж мөрддөгийн зэрэгцээ олон талын өргөн их мэдлэгтэй, мэргэжлийн өндөр зэрэглэлийн ур чадвартай өсч хөгжиж явсан сайхан эрдэмтэн байсан нь уламжлалт анагаах ухааны сургууль нэгэн ховор сайхан багшаар түүнчлэн энэ салбар цаашид ихийг хийж бүтээх нэгэн сайхан мэргэжилтнээр дутагдаж томоохон гарз хохирол учирсан юм.

Өөрөөр хэлбэл ийм сайхан тэгш дүүрэн хүний нөөцийг ахин бэлдэж гаргахад лавтай 20 жилийн цаг хугацаа шаардах бизээ. Гэхдээ талийгаачийн энэ сайхан үйл хэргийг үргэлжүүлэн

цаашид улам илүү ихийг бүтээж чадах залуу үеийг өнөөдрийн Монгол анагаах ухаан бүрдүүлж чадсан нь ойлгомжтой.

Анагаах Ухааны доктор багш, эмч Я.Ганбаяр агсаны тухай түүний авъяас чадвар, билэг, эрдэм чадлыг нь өөрийх нь бичсэн ном, сурах бичиг, эрдмийн зэрэг хамгаалсан, эрдэм шиншилгээний талаар бичсэн илтгэл өгүүлэл зэрэг зүйлээс уншигч та тунгаан цэгнэнэ бизээ. Сэтгүүлийн энэ дугаарт судлаачдын эрдэм судлалын бүтээлүүдээс гадна Я.Ганбаярын сурагч, оюутан, эмч, багш, эрдэмтэн гээд туулсан амьралынх нь замналд хамт явсан нөхдийх нь дурсамж, дуртатгал бодлоос нийтлэлээ. Манай сургуулийн хамт олноос санаачлан хэрэгжүүлж байгаа энэ арга хэмжээ хойшид баяжин дэлгэрч байх болно гэдэгт итгэлтэй байна.

Талийгаачийн 50 насны ойг тэмдэглэн өнгөрүүлэхээр МАУИ-ийн удирдлагын гаргасан санаачилгыг бүх талаар дэмжиж ажилласан ар гэрийнхэн, багш нар, УАТХ, уламжлалт анагаах ухааны төв эмнэлэгийн хамт олон, талийгаачийн багш нар, найз нөхөд, хамт оюутан байсан мэргэжил нэг нөхөд, түүний олон арван шавь нарт зохион байгуулах комиссын нэрийн өмнөөс гүн талархал илэрхийлж байгааг хүлээн авна уу.

Бид бүхний сэтгэл зүрхэнд инээвхийлсэн, шар царайтай, онигордуу нүдтэй, эр хонгор дуутай, гялалзсан, шөрмөслөг шар залуу амьдарсаар байна.

Олноороо амгалан байх болтугай.

АУ-ны доктор, профессор С.Сээсрэгдорж

Ядамсүрэнгийн Ганбаяр багшийг эргэн дурсахын учир ину

Я. Ганбаяр багштай 1990-ээд оны дунд үед танилцаж билээ. Я.Ганбаяр багш 1992 онд, миний бие 1993 онд АУДЭС-д шил шилээ даран багш болсон түүхтэй. Намайг бодвол сургуулиа төгсөөд хөдөө орон нутагт салбарын эрхлэгчээр ажиллаад ирсэн, дүрс оношилгоо хэмээх нарийн мэргэжлийн багш болчихсон туршлагатай нэгэн. Хаана уламжлалтын хурал зөвлөгөөн, эрдэм шинжилгээний хурал болно түүнд ирээд л оролцож, сонирхолтой олон асуулт өрнүүлэж, судлаачидтай ном хаялцана, ингэж мэргэжлээрээ ээнэгшин дасаж байгаад 1994 онд манай тэнхимд онолын багшаар ирсэн. Бид нэг тэнхимд 2001 он хүртэл 7 жил хамтран ажилласан. Тэр үеийн уламжлалтын багш нар өглөө 7.00 орой 22.00 цаг хүртэл ажиллана, хагас бүтэн сайнд амрахыг мэдэхгүй, Н.Төмөрбаатар багшийн өрөөний хаалга онгорхой бол ажлаасаа гарч явах зориг, зүрхтэй багш байдаггүй байлаа. Ингэж хөдөлмөрсөний үрээр багш нарынх 88.5% нь эрдмийн зэрэг цолтой болсон биз. Миний бие Я.Ганбаяр багшийн 3 номыг редакторлаж, түүнийг бурхан болсоны дараа аавынх нь захиасаар өдөржин шөнөжин сууж анагаах ухааны докторыг зэрэг горилсон бүтээлийг нь “Эмийн Дөрвөн Үндэсний гарах ёс” хэмээх ном болгон эмхэтгэсэн хүний хувьд Я.Ганбаяр багшийн талаар дурсамж, дурдатгалаа бичиж оруулах саналаа зохион байгуулах комисст гаргасан юм.

Ядамсүрэнгийн Ганбаяр нь:

- ✓ Я.Ганбаяр нь Монгол улсад уламжлалт анагаах ухааны олон мянган шавь нарыг бэлтгэхэд өөрийн хүч хөдөлмөрөө зориулсан авьяаслаг сурган хүмүүжүүлэгч багш юм.
- ✓ Я.Ганбаяр нь Монголын анагаах ухааны түүхэн хөгжил, үндэсний оточ маарамбуудын туурвисан оюутны үнэт сан хөмрөг, түүхийн эдрээтэй олон асуудлыг нарийвчлан судлаж, шинжлэх ухааны үндэслэлтэй тодруулан гаргаж судалгааны эргэлтэнд оруулсан нэрт судлаач
- ✓ Я.Ганбаяр нь өвөг дээдсээс уламжлан ирсэн нууц, ховор нандин жорыг эмнэлзүйн эргэлтэнд оруулсан, судас барих, эм өгөх, засал хийх туршлагаар олонд алдаршсан ховорхон авьяастай удам залгасан эмч
- ✓ Я. Ганбаяр нь хүн чанарын дээд, хүний хайлан байсан юм. Хүнд тусархуу, хүнлэг зөөлөн сэтгэлтэй, хүний ач тусыг мартдаггүй, тусалсан хүнээсээ хариу нэхдэггүй, эгэл даруу, эрдэм номто иргэн байлаа.
- ✓ Я.Ганбаяр мэргэжлийн номыг орос, англи, түвэд, санскрит, пали хэлээр ашигладаг орчуулагч, соён гэгээрээрүүлэгч байсан.

Хүндэт багш Я.Ганбаяр таны анагаах ухааны шинжлэх ухаанд оруулсан үнэтэй хувь нэмэр, сайн үйлс бүхнийг үргэлжлүүлж яваа олон мянган шавь нар, хамтран зүтгэгчид, номын олон садангийн нэрийн өмнөөс сэтгэлийн зул, номын цагаан суварга босгосныг хүлээж авна уу. Таны хийж бүтээсэн зүйл өнө мөнхөд үргэлжлэн хөгжих болно.

Монгол Анагаах Ухааны Институтийн захирал
МАУА-ийн гишүүн, доктор, профессор Д.Цэрэндагва

Баярлаж баяссаар явдагийн учир

Миний хүү Анагаах ухааны доктор, багш асан Я.Ганбаярын 50 насны ойг тэмдэглэж, ажил үйлсийг нь нэхэн дурсах арга хэмжээг зохион байгуулсан Сургуулийн Захиргаа, хамтран зүтгэж явсан журмын нөхөд та нарт хувиасаа болон үр хүүхэд, төрөл төрөгсөд, анд нөхдийнх нь нэрийн өмнөөс чин сэтгэлийн баяр хүргэж, гүн их талархал илэрхийлж байна.

Хүү минь Замбуулингаас халиад долоон жил болсон ч өнөөдөр хамт олон та нөхөд эргэн дурсаж байгаа нь хийсэн ажилтай, хүн төрхтэй, үлдэх мөртэй явсны баталгаа байх аа. Эцэг эх, эр биеийг төрүүлсэн бол, эрдэм ухааныг Анагаах Ухааны Их Сургууль, Уламжлалын Анагаахын Сургууль, Анагаах Ухааны Хүрээлэн, эрдэмтэн багш нар, хамт олон та нар төрүүлсэн гэдгийг би цохон тэмдэглэхийг хүсэж байна

Миний хүүд, Сургуулиа дүүргээд амьдралын замд нь орсноос хойш оюун ухаанаа тэлэх, сэтгэн бодох, туурвин бүтээх, ухааралын хишгийг эрдэмтэн багш нар хүртээж, даль жигүүр ургуулсан их гавьяатай гэж би бодож явдаг. Тухайлж зарим нөхдийн нэр дурьдваас Академич Б.Дагвацэрэн, Н.Төмөрбаатар, Ц.Лхавгасүрэн, Л.Хүрэлбаатар, эрдэмтэн М.Амбага, С.Сүхбаатар, Д.Амгаланбаатар, Ц.Эрдэнэсамбуу, Д.Цэрэндорж, Д.Цэрэндагва, Б.Хүрэлчулуун, С.Сэдэддулам, С.Сээсрэгдорж, С.Олдох, Д.Цэнд-Аюуш, Ч.Чимэдрагчаа, Б.Цэрэнцоо нар болон хүүг энэ зэрэгт хүргэхэд туслан дэмжиж, зааж зөвлөж явсан багш нар ,найз нөхөд, хамт олонд талархаж явдгаа илэрхийлье .

Хүү Ганбаяр минь миний үг зааврыг дагаж Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн дүрс оношилгооны багшийн ажлаа дорно дахины анагаах ухаанд нэгэн үзүүрт сэтгэлээр зүтгэхээр санаа шулуудаж энэ чиглэлээр мэргэжил дээшлүүлж Уламжлалт Анагаахын сургуульд багшлах болж дорно дахины анагаах ухааны онол, дотор өвчин судлал, эм судлал, зүү эмчилгээ, анагаахын зурхай, төвөд хэл зэрэг олон хичээлийг зааж байжээ.

Хүүг багшлах эрдмийн ээдрээт, бартаат замд хөтөлж, ухааныг нь тэлж, зүг чигийг зааж, зөвлөж явсан ачит хүн академич, анагаах ухааны доктор, хүний гавьяат эмч, профессор Н.Төмөрбаатарын ач тусыг онцлон тэмдэглэж ,гүн хүндэтгэлтэй санан дурсаж байна. Энэ эрхэм хүн Амар амгалангийн орноос шавийхан хамт та биднийгээ таалан болгоож байгаа буй заа. Тэрбээр хүүг минь Энэтхэгт мэргэжил дээшлүүлж байхад **“Та Ганбаярыг Энэтхэгийн эртний анагаах ухааны түүхийн холбогдол бүхий ховор ном олж ирэхийг хичээгээрэй гэж дамжуулаарай”** хэмээн надад захисныг интернэтээр хүүтэй харилцахдаа Төмөө багш чинь ингэж захиж байна шүү гэж хэлснийг тэр биелүүлж чөмөдэн ном авчирч багшийнхаа захиасыг хэрэгжүүлж ”хүний газраас эрдмийг өвөрлөж” ирж эрдмийн зэрэг хамгаалсан нь үүний нэгэн нотолгоо биз ээ.

Сургуулийн захиралаар ажиллаж байхдаа хүүг декан болгох, Орос улс болон Өвөрмонголд багшаар илгээх саналыг надад удаа дараа хэлэхэд нь хүүд албан тушаал хэрэггүйээ, эрдмийн зэрэг дэвтэй болсны дараа л гадагшаа явах асуудлыг ярьж болох юм биш үү гэдэг байв.

Хүү Ганбаяр багш Н.Төмөрбаатартайгаа хамтарч “Монголын Уламжлалт Анагаах Ухааны Онолын үндэс” номоо хоёр мянган оны эхээр бичсэн бөгөөд Сургуулийн сурах бичиг яаж бичих, ямар шаардлага хангах арга дүйг Төмөө багш минь надад зааж сургасан юм. Үүндээ л урамшиж дараачийн хэдэн сурах бичгийг бичихээр зориглосон, багш маань байнгын хараа хяналтандаа байлгаж, зөвлөж чиглүүлж зүгширүүлсэн гэж хүү минь багшийхаа ачийг дурсан ярьдаг байж билээ

Хүү Ганбаяр “Анагаах Ухааны дөрвөн үндэсний язгуурын болон номлохуйн үндэс, тэдгээрт холбогдох мод, тайлбар сэлт” номоо 2001 онд Анагаах ухааны доктор Н.Төмөрбаатар, Д.Цэрэндагва, С.Сэдэдулам, магистр Д.Цэнд-аюуш нарын хянан тохиолдуулснаар “Төвөд хэл, бичигт суралцах дэвтэр” номоо 2002 онд гавьж доктор Ш.Сонинбаярын ариутган шүүснээр, “Монгол эм найрлагын жорын түүвэр” номоо 2001 онд доктор, профессор Н.Төмөрбаатар, Д.Цэрэндагва, магистр Б.Цэрэнцоо нарын хянан тохиолдуулснаар хэвлүүлсэн нь шавь нарынх нь анхны сурах бичгүүд болж системтэй мэдлэг эзэмшихэд алхам болсон ажээ.

Анхных нь ном бүтээлийг нь хэвлэн нийтлэхэд Төвөдийн сангийн С.Агьзул болон Г.Шаравдэмбэрэл, Н.Цагаанхүү, Д.Тэрбишдагва, Н.Баасанхүү, Г.Даш, Ц.Чанцал, Д.Алтангэрэл, П.Эрдэнэсайхан, оюутан Одгэрэл, Нансалмаа нарын сайхан сэтгэлтэй, өглөгийн эзэд эвээн тэтгэж хүүд минь урам, эрч хүч өгч, бүтээж туурвих, мэдэж сурснаа түгээн дэлгэрүүлэхэд нь даль жигүүр ургуулсан гэдэгт би итгэлтэй байна

Хүү минь бүтээж туурвих насандаа Амар амгалангийн орноо одож судалж мэдэх, бүтээж туурвих боломжгүй болов. Өвөг дээдсийн үйлсийг сэргээх гэсэн санаа бодлыг минь хэрэгжүүлэхээр Ганбаяр минь багахан хугацаанд зүтгэж намайг



Академик доктор Н.Төмөрбаяртай Т.Ядамсүхтэй 2010 онд...

баярлуулсан ачийг нь санаж “Анагаах ухааны дөрвөн үндэсний язгуурын болон номлохуйн үндэс, эдгээрт холбогдох мод, тайлбар” (2010), “Монгол эмийн жорын хувилбар, нэрийн түүвэр” (2010), “Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс” эрдмийн зэрэг хамгаалсан бүтээлийг доктор, профессор Д.Цэрэндагвын хянан тохиолдуулснаар (2010), “Монгол засал” (2010), доктор, профессор Д.Цэрэндагвын хянан тохиолдуулснаар, “Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэл” Академич, доктор, профессор Ц.Лхагвасүрэн, Б.Дагвацэрэн нарын хянан толилуулснаар 2012 онд тус тус цөөн тоогоор хэвлүүлж номын суврага босгохыг оролдож явлаа.

Хүү Ганбаярын бүтээлүүд нь гагцхүү хүүгийн бүтээл төдийгүй эрдмийн мөрд хөтөлсөн эрдэмтэн багш нар, зорилго үйлс нэгтэй сайн нөхөд, олон шавь нарынх нь оюун санаа, хүч хөдөлмөр бүрнээ шингэсэн “хамтын бүтээл” гэдэгт би эргэлзэхгүй байна

Хүүг минь бурханы оронд заларсны дараахан Н.Төмөрбаатар надтай өрөөндөө уулзаж надад ингэж хэлж билээ. ”Намайг Сургуулийн захиралаар ажиллаж байхад мэргэжлийн багш хүрэлцэхгүй хэцүү үед Ганбаяр минь тав зургаан төрлийн хичээл зааж, хэд хэдэн сурах бичиг энэ сургуулийг өсөж өндийхөд маш их тус болж, оюутан, багш нартаа хүндлэгдсэн сайн багш байлаа. Эрдмийн зэрэг хамгаалах ажлыг нь удирдсаны хувьд хэлэхэд тэр уншиж мэдсэнээрээ, хөдөлмөрч, бүтээлч, няхуур байдлаараа бусдаасаа ялгарахаар миний сайн шавь, ихийг бүтээх чадвартай эрдэмтэн байсан даа” хэмээн миний харамсал харуулаас хуваалцан сэтгэлийнхээ үгийг хэлж хүүгийн тухай бичсэн дурсамжаа өгч байж билээ

Академич, доктор профессор Н.Төмөрбаатар гарын шавь Ганбаярын тухай дурсамжиндаа “Ганбаяр маань монгол эмнэлгийн олон талын гүн мэдлэгтэй,ямарч сэдвээр хичээл зааж чаддаг,энэ сэдвээр хичээл орохгүй бол болохгүй нь гэхэд цэрэг хүн шиг хэзээд бэлэн байдагсан,түүнд оюутан эмч нарт заагаагүй хичээл бараг байхгүй гэхэд болно. Монгол эмнэлгийн тал бүрийн өндөр мэдлэг, боловсрол, дадлага туршлагатай ийм багш л энэ олон төрлийн хичээлийг зааж чадна.” гэж үнэлэн дүгнэж бичсэн байдаг.

Хүүг таалал төгссөний дөчин есдэх хоногийн өмнөхөн 2009 оны төгсөх ангийн хэсэг оюутнууд намайг лекцийн танхимдаа урьж эмгэнэл харуулаа илэрхийлээд багшийнхаа тухай ингэж ярьж билээ. ”Ганбаяр багш шиг багш дахиад олон заяахгүй ээ. Яагаад гэвэл ихэнх багш өөрийнхээ уншсан лекцийн хэмжээнд эргэлддэг бол Ганбаяр багш өргөн хүрээнд хичээлээ заадгаас гадна бидэнд юм сургая гэж санаа тавьж үнэн сэтгэлээсээ чармайдаг байсан. Жишээ нь Улсын номын санд тийм хэл дээр бичсэн, ийм ном бий, Гандангийн номын санд тийм тийм ном, Дашчойлон хийдийн номын санд тийм ном байгаа түүнийг унш, канондож аваад ир, орчуулцгаая гэх буюу заримдаа биднийг дагуулж хийдүүдэд очиж бурхадын намтар цадиг болон түүх ярьж өгдөг.

Орос, англи, төвөд, санскрит, пали хэл мэддэгээрээ үнэхээр давуутай, Англи, Төвөд хэлээр бичсэн зүйлийг орчуулахаар бидний оролдсон алдааг хэлээд зогсохгүй аргачилсан зөвлөгөөг сайн өгдөг байсан,төгсөх шалгалтын одоо үед багш минь үнэхээр үгүүлэгдэж байна даа... Энэ индрийн дэргэдээс намуухан дуугаар хичээлээ заадаг байв” гэхчлэн ярьцгааж миний нулимсыг цийлэгнүүлж байсан юм. Тиймээс ч Ганбаяр ”Оюутанд хайртай багш”, ”Тэргүүний лектор багш”-аар сургуульдаа олон жил шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнуулж байжээ.

Хүү Ганбаяр минь хичээл заах, судалгаа хийх, ном бичихээс гадна сургуулийнхаа хамт олноос даалгасан Багш нарын ахлагч, Оюутны Зөвлөлийн ахлагч, Урлаг уран сайхны үзлэг Спортын уралдаан тэмцээн зохион байгуулах ажлыг хариуцан олон ажил давхар үүрэг хүлээж түүнд санаа тавьж ихээхэн хөдөлмөр, цаг зарцуулж хамт олноороо сайшаал шагнал хүртэж байсныг илтгэх ажлын төлөвлөгөө, хурал цуглааны тэмдэглэл, тайлан, илтгэл мэдээлэл, тодорхойлолт зэрэг нотолгоо материалууд хадгалагдан үлджээ. Хүү минь ийм л төрхтэй багш байж дээ.

Хүү минь харь орны болон монгол эрдэмтэн мэргэдийн олон зууны бүтээн туурвисан түүх шастир, судар номыг боломжийн хирээр болгоож, эрдэмтэн багш нар

болон хүрээ хийдэд шавилан сууж ухаан тэлсэн хөгшид, итгэлтэй нөхдийнхөө тус дэмээр судлан бичсэн бүтээлүүдээ Сургуулийнхаа Эрдмийн Зөвлөлөөс авахуулан Олон улсын Эрдэм Шинжилгээний хурлуудад илтгэж шүүн хэлэлцүүлж тунгаан цэгцрүүлж, дотоод гадаадын сэтгүүлд толилуулж явжээ. Энэ тухай Эрдэм шинжилгээний бүтээлийн эмхэтгэлээс тодруулж үзнэ буй заа.

Цөвүүн цагийн шуурганд бүтээл туурвил нь бүдгэрсэн нэрт оточ Дүнрэг Дандарын Дорнын Анагаах ухааны түүхэнд оруулсан их хувь нэмрийг чармайн судалж эрдэмтэн мэргэдийн зөвлөмж зөвлөлгөөг болгоож “Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс” бүтээлээрээ Анагаах ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан байна. Энэ бүтээл нь хүү Ганбаяраас Дорно дахины Анагаах Ухааны түүх судлалд оруулсан хувь нэмэр нь мөн. Хүүгийн багш эрхэм нөхөр Н.Төмөрбаатарын хүн чанарын тухайд өөрт төрсөн сэтгэгдлээ энд дурсахгүй орхих аргагүй юм. 2010 оны өвөл уулзаад “Ачтан” эмнэлэгт хэд хоног эмчилгээ хийлгэх гэж явна хэмээн намайг хэлэхэд та өндөр төлбөртэй эмнэлэгт төлөх мөнгөөрөө шаардлагатай эм тариагаа аваад манай “Улаанбаатар сувилалд” тавтай сувилуулаач, манайхан хүүг чинь бодоод таныг цаашаа гэхгүй наашаа гээд сайн сувилж өгч чадна шүү гэж билээ.

Би нөхрийнхөө зөвлөснөөр энэ сувилалд хүүгээ байгаа юм шиг үнэхээр тавтай сайхан сувилуулсаан. Хаяа өрөөнд нь орж сайхан хуучилж өөрийнх нь өвчний талаар бодлоо ярьж, зургаа хамт авахуулж байлаа. Хэдэн сарын дараа Н.Төмөрбаатар маань шавийнхаа араас Амар амгалангийн оронд заларсан байв. Хорвоогийн жам ийм хатуу хойно яах ч билээ дээ. Багш шавь хоёр амар амгалангийн орноо учран золгосон буй заа. Хүүг минь эрдмийн мөрд хөтөлж, ном сурах зохион бичих, багшлах ,эрдмийн зэрэг хамгаалах гэгээн үйлс бүхэнд нь удирдсан ачит хүн академич Н.Төмөрбаатарын ач тусыг яав ч мартажгүйээ. Хүүгээ дурсвал Н.Төмөрбаатар багшийгаа дурсаж ачийг нь санаж л явах болно.

Дурьдахгүй өнгөрч боломгүй.нэг сонин учралыг хэлье. 1990 оны Ардчилсан



Академич доктор Б.Дагвацэцэн, Т.Ядамсүрэн 2010 он

Сонгуулиар Цэцэрлэг хотын ард иргэд хорин дөрвөн нэр дэвшигчээс надад итгэл хүлээлгэн Ардын Их Хурлын депутатаар сонгосон юм. Ардын уламжлалт эмнэлэгийг сэргээн хөгжүүлэхийнтөлөө би ажиллана гэж сонгогчдоодоо амалсан юм. Намар нь Ардын Их Хурлын анхны чуулганд Ардын уламжлалт эмнэлгийг сэргээн хөгжүүлэх асуудлыг төрийн бодлого болгох саналыг дэвшүүлснийг “Ардын эрх” сонин, Монголын радио, телевизээр мэдээлж байв. Чуулганы дараа Эм тангийн материал бэлтгэх,гадаад валютын дэмжлэг

олгох, орон нутгийн эмийн ургамал ашиглах, залуу эмч эм зүйчдийг бэлтгэх мэт асуудлыг төр засгаас онцгойлон авч үзэхийг хүссэн хүсэлтээ БНМАУ-ын дэд Ерөнхийлөгч Р.Гончигдорж, Ерөнхий сайд Д.Бямбасүрэн нарт 1990 оны 10 сарын 10-ны өдөр явуулав.

Нэн удалгүй 11 сарын дундуур Р.Гончигдорж, Д.Бямбасүрэн дарга нартай уулзаж бичсэн саналын мөрөөр ямар арга хэмжээ авах гэж байгааг сонирхоход тэд саналыг нааштай хүлээн авч Улсын Бага Хурлын Байнгын Хорооны дарга Т.Очирхүү, Эрүүлийг Хамгаалах Яамны сайд П.Нямдаваа болон холбогдох Яам газруудад үүрэг өгч бүрэн дүүрэн дэмжиж байгаагаа хэлж байв. Тэндээсээ Ардын Эмнэлгийн Хүрээлэнгийн захирал Б.Дагвацэрэнг сураглан очиж асуудлаа танилцуулж хамтран ажиллахыг хүсэхэд дуртай хүлээн авч байв. Санаа зорилгоо төрийн томчуулд ойлгуулах, дэмжлэг авах, миний саналыг дэмжүүлэхээр бид хоёр Төрийн ордноор үг хэлээ нэгтгэн чармайж явснаа эргэн дурсахад сайхан санагдана. Депутатын тавьсан санал Ардын Эмнэлгийн Хүрээлэнгийн хүсэлтийг Улсын Бага Хурлын Байнгын Хороогоор хэлэлцүүлж, Яам газруудад үүрэг оногдуулж, улс орны хэмжээнд хөрөнгө мөнгө, валют хомс хэцүү байсанч хоосон орхиогүй, төр засгаас боломжийн хирээр дэмжлэг өгч тусалсан.

Энэ нь бид бие биеэ дэмжсэн хамтын чармайлтын үр дүн байв. Хүрээлэнгийн захирал Б. Дагвацэрэн миний хүсэлтээр Аймгийн дарга Л.Баасанхүүд Ардын эмийн үйлдвэр аймагтаа байгуулахыг дэмжиж байгаагаа илэрхийлээд онцлон анхаарч туслахыг хүссэн бичиг явуулав. Аймгийн Захиргааны Хурлаар Эрүүлийг Хамгаалах хэлтсийн харьяанд ийм цех байгуулах шийдвэр гаргасан юм. Үүнийг их эмч Л.Халтархүү хариуцаж дараа нь “Тунгалаг тамир” эмнэлэг болгон хөгжүүлсэн түүхтэй. Уламжлалт Анагаах Ухааныг төрийн бодлогоор тэтгэхэд сэтгэл гаргаж хувь нэмэр оруулахаар зүтгэж явснаа хүү Ганбаяртаа залгамжлуулах бодолтой явсан гэдгээ тодруулахаар энэ дурсамжийг хэллээ. Ийм л хувь тавлангаар та нартай холбогдсон юм гэдгээ эцэст нь хэлье.

Хүүд минь өв их соёлтой сэтгэл харамгүй танилцуулж, учир бүхнийг ойлгуулсан номын гэвш О.Баатар, Жамбалдорж, Сэр-од, Агваанлодой, Чойдор, Ням, Дорждан, гавьж Довдонням, Сонинбаяр, оточ Ананд, Дүгэр, Пүрэвдорж, Магсар, академич Ц.Хайдав, төвдөч И.Дэмбэрэл нарын олон сайхан буянтнуудын хүүд хайрласан ухаан, ухаарлын их өглөгийг хэрхэвч мартах учиргүй билээ. Энэ олон эрдэм чадалтай ухаантнуудын өглөг л хүүд минь рашаан болон шингэж жигүүр ургуулсан даа гэж өтөл өвгөн баярлаж, баясаж явдаг юм даа.

Монголын эрдэмтэн мэргэдийн зуунаас зуун, мянганаас мянган дамжин өртөөлсөн өв их түүх, соёл, оюуны охийг судалж түүхнээ мөнхлөх үйлсэд залгамж үеийнхэн минь улам ихий бүтээх болтугай.

Т.Ядамсүрэн. Цэцэрлэг-Улаанбаатар.2015 оны 10 сар

Гарчиг

Эрдэм шинжилгээний өгүүлэл		
1.	Я.Ганбаярын туурвисан зарим бүтээлүүдийн талаар хийсэн тойм судалгаа <i>С.Сээсрэгдорж</i>	12
2.	Туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд уламжлалт Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөө <i>З.Сүхээ, С.Хишигжаргал, П.Молор-Эрдэнэ, Б.Ууганбаяр</i>	17
3.	Харханд адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварт уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судласан дүн <i>А.Гүйцэд, Г.Зулаа, Улаан, Б.Ууганбаяр</i>	24
4.	Системийн анагаах ухаан ба эм найруулгын онцлог <i>Д.Амарзаяа, Б.Дагвацэрэн, Ч.Чимэдрагчаа, Л.Пүрэвжав, Д.Цэнд-Аюуш</i>	31
5.	Уламжлалт “жонлон-5” тангийн фармакологийн судалгааны зарим үр дүн <i>П.Даваадулам, Б.Ууганбаяр, С.Олдох, Г.Мөнхзул</i>	36
6.	Антацид кальци-6 биологийн идэвхит бэлдмэлийн ходоод улаан хоолойн сөөргөөнд үзүүлэх үр дүнг багажийн шинжилгээгээр тогтоосон нь <i>У.Алимаа, Ц.Баярхүү, Х.Оюунцэцэг, Н.Баярмаа, С.Сээсрэгдорж</i>	46
7.	Тойн жамбалдоржийн намтрыг хөөж тодруулсан нь <i>Д.Алтанчулуу, Д.Амарсайхан, Т.Содгэрэл, С.Сээсрэгдорж</i>	51
8.	Ерөнхий унтуулгатай эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын үеийн пнеумоперитонеум ба Трендленбургийн байрлал нь амьсгалын үйл ажиллагаанд нөлөөлөх нь <i>Ц.Уугангэрэл, Н.Баярцогт, С.Дүүрэнбаяр, Б.Сайнзаяа</i>	55
9	Цэвэршилтийн дараах анхдагч ясны сийрэгжилттэй эмэгтэйчүүдэд остеокальци-5 бэлдмэлийн үзүүлэх нөлөөг уламжлалт анагаах ухааны биеийн өвөрчлөлттэй харьцуулан судласан нь <i>Д.Бямбадалай, М.Мөнхзол, С.Сээсрэгдорж</i>	56
10	Хүний биеийн мөчдөд байрлах бэрх оньсны талаар сурвалж болон тайлбар зохиолуудын харьцуулсан судалгаа <i>Д. Дашзэвэг, О.Одмаа, С. Сээсрэгдорж.</i>	61
11	Өвдөгний үений остеоартроз өвчний үед түрэм заслын үзүүлэх нөлөө <i>Э.Жаргалхүү, Д.Баярмаа, С.Сээсрэгдорж</i>	66
12	Туршилтын амьтанд үүсгэсэн элэгний хурц үрэвслийн эмгэг загварт “Антомен” бэлдмэлийн үзүүлэх нөлөө <i>Н.Уранбайгаль, З.Ариунаа, Ч.Чимэдрагчаа</i>	71
13	Өтгөн хаталтыг дасгал хөдөлгөөнөөр эмчилэх нь <i>Б.Нямжав, Ч.Батнайрамдал</i>	75
14	Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч”-д харшлах идээний талаар өгүүснийг тодруулсан нь <i>Б.Нансалмаа, Т.Лхамжав, Г.Эрдэнэбулган, С.Сээсрэгдорж</i>	80

Я.Ганбаярын туурвисан зарим бүтээлүүдийн талаар хийсэн тойм судалгаа

С.Сээсрэгдорж
УАУИ. АУС. АШУУИС

Үндэслэл: Би Я.Ганбаяр агсаны дахин хэвлэгдсэн нэгэн бүтээлийн өмнөтгөлд бид бүхний багш мөн талийгаачийн эрдэм судлалын багш МАУА-ийн гишүүн, доктор, профессор Н.Төмөрбаатар “Сод ухаантан тэнгэрт халивч үйл нь газарт мөнхөрнө” гэж бичсэн үгийн утгыг эргэцүүлэн бодож үзлээ. Хэдийгээр Я.Ганбаяр сод ухаантан биш байлаач тэрээр амьдралдаа бүтээж туурвиж болох насныхаа богинохон хугацаанд цөөнгүй чансаатайхан бүтээлүүдийг туурвиж үйл хэргээ газарт мөнхлөн үлдээжээ. Багшийн минь үг үнэхээр амны бэлгэтэй тос даасан сайхан монгол үг ажээ.

Тэрээр уламжлалт анагаах ухаанд Сурхарваа Лодойжалбын хэлснээр “хэрээн тоншилтын” биш жам ёсны дагуу суралцах нь анагаах ухаан бүгдийн шимийг алгортим байдлаар хураангуйлж томъёолсон “Язгуур үндэс”-ийн гүн далд утгыг задалж ойлгох ёстойг эхнээс нь ухаарч түүнчлэн түүний утгыг цаашид дэлгэрүүлсэн “Номлохуйн үндэс”-г суралцаж ёстой өөрөө аяндаа эрэмбэлэгдэн цэгцрэхийн амтыг мэдэрч түүнийгээ бусдад түгээн дэлгэрүүлэхээр өөрийнх нь хэлснээр “Өвөг дээдсийн сэтгэшгүй оюунаар бүтсэн уламжлалт анагаах ухааны мэдлэгийн их сангаас суралцахыг хүсэгч танд нэмэр болохын үүднээс” энэхүү номоо толилуулж буян үйлджээ.

Энэ нь нэг талаас аль эрт 1860-иад оны үед Ламын гэгээн Лувсанданзанжанцаны 1. Өөрөөсөө анагаах ухааны талаар хувь буурай нөхөлдөө туслахын тулд 2. Өөрийнхөө авъяас оюунаа удам судартаа үе дамжуулан өвлүүлэхийн тулд зохиосон гэж тэмдэглэснийг батлах мэт байгаа юмаа. Хэдийгээр түүний эцэг Т.Ядамсүрэн гуайн санаачлага, их зүтгэл хайр, харууслын их шуурган дундуур бүтээлүүд нь ахин хэвлэгдэж түмний хүртээл болж байгаач түүний 50 насных нь энэ ойн үйл ажиллагааны индэр дээрээс зарим бүтээлд эрдэмтэн хүний хувьд судалгааны шинжтэй үүтгэл эхлүүлж ахин бага боловч нэг анхаарал татах нь зүйн ёсны байх үндэстэй хэмээн үзэж энэхүү багахан тойм судалгааг оруулж байна.

Зорилго: Я.Ганбаярын туурвисан зарим бүтээлүүдийн ач холбогдлын талаар судлаач, уншигчдын анхаарлыг нэмэгдүүлэх

Зорилт: 1. Сурах бичгийн хүрээнд бичигдсэн ““Анагаах ухааны дөрвөн үндэсний язгуурын болон номлохуйн үндэс, тэдгээрт холбогдох мод тайлбар сэлт” бүтээлийн талаар тодруулах

2. Эрдэм судлалын чиглэлээр туурвисан “Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс” бүтээлийн талаар тодруулах

Эх хэрэглэгдэхүүн, Арга зүй.:

1.Я.Ганбаяр “анагаах ухааны дөрвөн үндэсний язгуурын болон номлохуйн үндэс, тэдгээрт холбогдох мод тайлбар сэлт” сурах бичиг. УБ 2001.

2. Я.Ганбаяр “Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс” судалгааны бүтээл УБ 2010

1. Түүхэн хүн судлалын арга. (William A.haviland, 2005). Энэхүү арга нь түүхийг эзэнгүйдүүлэхээс хамгаалж түүхийг илүү бодит үнэмшилтэй болгодог.

2. Түүхийн төрөлжүүлэлтийн арга: Үзэгдэл хийгээд объектүүдийн бүрдлийг тэдгээрийн нийтлэг гол шинжүүдэд нь үндэслэн тодорхой төрөл (анги) болгон цэгцлэх зорилготой шинжлэх ухааны танин мэдэхүйн аргыг төрөлжүүлэлт гэдэг. Тухайлбал: Ерөнхийд нь тулгуурлан онцгойг олох буюу нэгтгэн дүгнэх, өөрчлөн нотлоход түүхийн төрөлжүүлэлтийн аргын мөн чанар оршино.

Судалгааны үр дүн:

Түүний “Анагаах ухааны дөрвөн үндэсний язгуурын болон Номлохуйн үндэс, тэдгээрт холбогдох мод тайлбар” бүтээлийн гол цөм нь “Язгуур үндэс” хэмээх 15*85 см урттай 6-н мөрөөр бичсэн 6-н хуудас зохиол байгаа юм. Энэ үндэс хэдийгээр 6-н хуудас боловч түүнд гүн далд утга, агуулга томъёолол байдлаар хадаглагдаж байдаг учраас утгыг нь дэлгэрүүлэн тайлбарласан томоохон бүтээлүүдээс судлаач Дарма маарамба Лувсанчойрог, Дэсрид Санжаажамц, Төвөдийн эмч Жамбапэрэнлэй, Чинравноров, Шадүжамц нарийн зохиосон “Анагаах ухааны дөрвөн үндэсийн мод тавих ёс” зэрэг бүтээлүүдэд тулгуурлан холбогдох тайлбаруудыг оруулж өгсөн нь эхлэн суралцагч нарт дөхөмтэй болсны зэрэгцээ номд дурлах хорхойг сэргээж өгөхөөр байдаг.

Я.Ганбаяр Монголын алдарт оточ Лүнриг Дандарын “Анагаах ухааны ер хийгээд ялгавартай дээдийн ном цог төгөлдөр эмийн дөрвөн үндэсний гарсан ёс хиргүй биндерьяан толь” хэмээх анагаах ухааны түүхийн холбогдолтой Барын хайрцагны хэмжээ нь 6*46 см 151 хуудастай. 6100 орчим шатаас тогтсон төвөд хэлээр бичигдсэн судрыг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож сонгож авчээ. Тэрээр судалгааны ажлын 1-р бүлэгт Энэтхэг, Төвөд, Монголын анагаах ухааны түүх бичлэгийн уламжлалыг олон талаас нотолгоо бүхий гаргаж өгсөн нь судар бичгийн тойм мэт өргөн хүрээтэй ашиглаж тодруулж болохуйц ач холбогдолтой болсон байдаг. Мөн судалгааны эх хэрэглэгдэхүүнээ Төвөдийн мэргэдийн 6 томоохон бүтээлтэй харьцуулан нягталж бичжээ. Тухайлбал:

Дэсрид Санжаажамцын “Анагаах ухааны төлөв” хэмээх анагаах ухааны түүхийн сэдэвт, Хятад улсад 1982 онд Төвөд хэлээр хэвлэгдсэн 1/16 хэмжээтэй, 573 хуудастай зохиол.

Төвдийн судлаач Жамба-Пэрэнлэйн (2000) “Цастын орны тэжээхүй ухааныг номлон гийгүүлэгч, дараалан ажрагсдын намтрын эмхэтгэл” хэмээх Хятад улсад 2000 онд төвөд хэлээр хэвлэгдсэн 1/16 хэмжээтэй, 630 хуудастай зохиол: Төвөдийн Дарам маарамба Лувсанчойдогийн “Шинэ хуучин Ютогийн намтар” хэмээх Хятад улсад 1982 онд Төвөд хэлээр хэвлэгдсэн, 1/16 хэмжээтэй, 349 хуудастай зохиолуудыг дурдахад ямар хэмжээний судалгаа хийгдсний нэг нотолгоо болно.

Мөн Аюурведийн анагаах ухааны эх, зохиол, түүх судлагч 11 судлаачийн 11 зохиол, Энэтхэгийн түүх, шашин санскрит эх зохиолыг судалсан 13 судлаачийн бүтээлтэй харьцуулалт хийж эрдэм судллын бүтээлээ туурвижээ.

Мөн Аюурведийн анагаах ухааны түүхэнд холбогдох мэдээлэл агуулсан монгол 2 оточийн, Монголын түүхийн Төвөд хэлээр зохиогдсон 4 бүтээл, манай мэргэдийн төвөд хэлээр зохиогдсон 8 намтрыг харьцуулалт хийж судалсан. Энэ их хүнд ажлыг Я.Ганбаяр өөрийн оюун ухааны чадавхи, тэвчээр, хэлний их мэдлэгтээ тулгуурлан аливаа зүйлийн цаана гарч харах гэсэн тууштай хөдөлмөрч чанараараа бахдалтай сайхан судалгааны ажлыг хийж үлдээжээ.

Судалгааны ажлын хүрээнд зөвхөн эх зохиолоо хөөгөөгүй Лүнриг Дандар гэж хэн байв гэдгийг эрэл хайгуул хийж харьцуулалттайгаар нотолгоожуулан намтарыг нь 5 зүйлээр багацлан гаргаж өгсөн. Тухайлбал Лүнриг хэмээх алдрыг 13-р далай лам хайрласан болох, түүний насыг нэлээд олон талын нотолгоо бүхий тооцож 91 насандаа 1923 онд таалал барьсан болохыг тодруулж гаргасан нь шинэ мэдээлэл болж байна

Судалж буй зохиолд гарч байгаа домгийн 2 мэдээнд үндэслэн эмч тэнгэрүүдийн гарвал, номын дамжлага зэргийг санскрит эх, төвөд эх сурвалжуудад тулгуурлан 5 бүлэг арш байсныг бусад судлаачдтай харьцуулан Лүнриг Дандарын бүтээлийн онцлогийг гаргасан төдийгүй арш нарын цаг хугацааны хамаарал, бүтээлүүдийг тодруулан судалсан нь нарийн төвөгтэй, олон зүйлийг уншиж нотолгоожуулах шаардлагатай, цаг зав шаардсан хүнд хэсэг байжээ.

Түүнчлэн Лүнриг Дандарын бүтээлд байгаа Буддагийн үеийн анагаах ухааны түүхийн хэсгийг нарийвчлан судалж аль ямар зохиолоос иш татаж бичсэн болохыг тодруулан Буддатай холбоотой мэдээ баримтуудад 11 зүйлээр дэлгэрүүлэн шинжлэл хийсэн бөгөөд Буддагийн үеийн эмч нарын болон Буддагаас хойшхи үеийн эмч нарыг тодруулан дүн шинжлэл хийж нотолгоожуулж гаргажээ.

Эдгээр шинжлэлийг хийхэд нарийн төвөгтэй байсан тухай ганц жишээ татвал зөвхөн Нагаржунай гэхэд л 10 –иад болж байсан тэдгээрийн аль нь ямар цаг хугацаанд хамаарах болон аль нь эмч, аль нь аг тарнич, аль нь бодьсдва болохыг хөөн тодруулахын зэрэгцээ тэдгээрийн бүтээл туурвилыг нэлээд нотолгоотойгоор тухайлбал “Мөнгөн усны найрлага, эрдэнийн эрхи” зохиолыг алхимич буюу 7-р зууны үед амьдарч байсан 4-р Нагаржунай зохиожээ гэх мэтээр гаргасан нь ихээхэн сууж, уншиж, баталгаажуулсан ажил болох нь тодорхой байдаг. Энэ мэтчилэн Энэтхэг, Төвөдийн болон шашин намын мэргэдийн намтруудыг олон талаас нь шинжлэн судалж гаргасан дээрээ тулгуурлан Төвөд Аюурведийн анагаах ухаан дэлгэрсэн түүхийг судлан тодруулсан байдаг.

Улмаар судалж буй зохиолын мэдээ баримтад үндэслэн монголын эмч мэргэдийн намтарг дүн шинжлэл хийж Монголд Энэтхэг-Төвөдийн анагаах ухаан дэлгэрсэн түүхийг бусад судлаачдынхтай харьцуулан гаргасан.

Судлаач Я.Ганбаяр эрдэм судлалынхаа эдгээр үр дүнгээр дотоодод 30 гаруй илтгэл хэлэлцүүлж өгүүлэл бичсний зэрэгцээ гадаадад 6 илтгэл тавьж, өгүүлэл хэвлүүлж эрдэмтэн мэргэдийн үгийг сонсч, ном хаялцаж, санал бодлоо солилцож баталгаажуулсан нь түүнд шинэ санаа сэдэл өгөхийн ялдамд заримдаа тэрээр өөрийгөө шахан шаардах нэг хөшүүрэг болгож заримдаа баяр бахдал болж байсан нь тодорхой байдаг.

Хэлцэмж дүгнэлт: Энэтхэгийн аюурведээс улбаатай Монголын анагаах ухаанд суралцах нь эн тэргүүнд “Анагаах Ухааны Язгуурын Үндэс”-ээс эх ундаргаа авах ёстой тухай мэргэд ач холбогдол өгсөн байдаг. Энэ талаар Төвөдийн мэргэдийн нэг Сурхарва Лодойжалба(1509-) “Анагаах ухаан бүгдийн агуулга хийгээд сүүлийнхээ гурван үндэсийнхээ утгыг шим мэт хураангуйлсан “Язгуурын үндэс”-ийг оюун билэг төгөлдөр задлан шинжилж чадах суралцагч нарын баярлан таалах орон, мунхаг оюунтан нар суралцахаар эс шамдах бөгөөд суралцсанч утгыг задлан шинжилж онож үл чадна” хэмээн үнэлэн тодорхойлсон.

Мөн Монголын анхны оточ ханчин чойжил ламын гэгээн Лувсанданзанжанцан (1639-1704) “Анагаах ухаан бүгдийн ноён оргил болсон цогт төгөлдөр дөрвөн үндэс-ийн шимийг үндэс мэт хураангуйлсан “Язгуур үндэс”, Лүнриг Дандар “анагаах ухааны утгын оньсыг товчлон хураангуйлж хөрөнгийн үр мэт зохиогдсон “Язгуур үндэс” хэмээн уул сурвалжийн агуулга түүнд суралцахын ач холбогдлыг өндөр үнэлцгээсэн байдаг.

Өөрөөр хэлбэл “Язгуур үндэс”-т эн тэргүүнд суралцах ёстой гэдэг нь шаштирын бүхэл цогцын ерөнхий барилдлагад суралцна гэсэн үг юм. Хэрэв шаштир зохиолын ерөнхий барилдлагад суралцаж чадахгүй бол төөрөгдөлд хүрэх буюу буруу танин мэдэлт болж үлгэрлэвээс үхсэн хүнийг даваажинд хүргэхийн тул олон мал алж тахил өргөх мэт сургалт буруу явагдана шүү гэдгийг сануулсан байдаг. Монгол анагаах ухаанд жам ёсны дагуу суралцах гэдэг нь анагаах ухааны шимийг хөрөнгийн үр үр мэт агуулсан шимийн шим нь болсон “Язгуур үндэс”-ийн гүн далд утга санааг задлан ялгаж дэлгэрэнгүйгээр ухаарч ойлгохоос эхлэх ёстой болж байгаа юм.

Ийм учраас Я.Ганбаяр энэхүү үнэ цэнэтэй бүтээлийг өөрөө ухаарч ойлгож дараа нь бусдад туслахын тухайд ном болгож гаргасан нь хичнээн ач холбогдолтой болох нь ойлгогдно. Тэрээр уламжлалт анагаах ухааны үндэс суурийг “Язгуур үндэс”, “Уламжлалт анагаах ухааны онол” дээр гүн бат суурилж хөгжүүлсэн хэзээч ямарч асуудалд барьц алдаад байхааргүй мэдлэг оюуныг бий болгож чаджээ.

Я.Ганбаярын судалгааны эх хэрэглэгдэхүүнээ болгосон “Анагаах ухааны ер хийгээд ялгавартай дээдийн ном цог төгөлдөр эмийн дөрвөн үндэсний гарьсан ёс хиргүй биндерьяан толь” хэмээх бүтээлийн мөр, шад, үг бүрийн утгыг тодруулан нягталж бусад ном, судлаачдын бүтээлүүдтэй харьцуулан тулгаж ихээхэн тэвчээр гарган ажилласан нь мэдрэгддэг. Тэрээр судалгааны хүрээнд Монголын нэртэй оточ Лүнриг Дандарын анагаах ухаанд оруулсан хувь нэмрийг 6-н зүйлээр тодруулан гаргасан нь Монолчуудын дорнын

анагаах ухаанд оруулсан хувь нэмрийг шинээр баяжуулсны зэрэгцээ Лүнриг Дандар судлалд томоохон хувь нэмэр оруулсан загвар болохуйц судалгаа болсон. Ганц жишээ татахад л Лүнриг Дандар “Гарсан ёс” бүтээлдээ Монголд Энэтхэг, Төвөдийн анагаах ухаан дэлгэрсэн түүхийг Өгөөдэй хааны ач Годан хаанаас эхэлж бичсэн болохыг тодруулж судалсан байдаг.

Дээрх бүтээлүүдийн агуулгаас үзэхэд Я.Ганбаяр Монгол анагаах ухааны эмчийн ёс зүйн бүлэгт заасанчлан 1. Оюун ихтэй болох нь мэдрэгдэж байдаг. Энэ тус бүтээлүүдийг туурвихдаа уншсан бүтээлүүдийн тоо хэмжээ, агуулга, харьцуулалт нь хичнээн өргөн хүрээнд байгаагаар нотолгоождог. 2. Тэрээр бат оюунтай хүн болох нь мэдрэгддэг. Мөн л тус бүтээлийн үг нэр бүрээр задлалт хийж нотолгоожуулсан байдал нь судалгааг баталгаатай итгэл үнэмшилтэй болгож түүнд өөртөө итгэх итгэлийг бий болгож чадсан болох нь мэдрэгдэж байдаг. 3. Я.Ганбаяр бол хурц оюунтай хүн болох нь тодорхой мэдрэгддэг. Энэ нь түүний судалгааны үр дүн, гаргалгаагаар илэрхийллэгддэг. Өөрөөр хэлбэл энэхүү үнэ цэнэтэй судалгааны эцсийн үр дүн болж байгаа түүний оюун санааны шийдвэрүүд үүнийг илтгэж байна.

Номзүй:

1. Я.Ганбаяр “анагаах ухааны дөрвөн үндэсний язгуурын болон номлохуйн үндэс, тэдгээрт холбогдох мод тайлбар сэлт” (оюутан эмч нарт зориулсан сурах бичиг), УБ 2001.
2. Я.Ганбаяр “Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс. УБ 2010
3. “Анагаах ухааны дөрвөн үндэс” Анагаан үйлдэгч эмчийн бүлэг
4. С.Сээсрэгдорж “Анагаах ухааны Дөрвөн үндэс-ийн Язгуурын үндэс- түүний тайлбарууд” УБ. 2012.

Туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд уламжлалт Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөөЗ.Сүхээ¹, С.Хишигжаргал¹, П.Молор-Эрдэнэ¹, Б.Ууганбаяр²¹АШУҮИС, АУС, УАУ-ны институт²Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн**Товч утга:**

Лидэр-5 танг уламжлалт анагаах ухаанд тулай, хэрх болон үе мөчний шар усны өвчинд хэрэглэж ирсэн бөгөөд бид туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд уг тангийн үзүүлэх нөлөөг судласан. Судалгааны үр дүнд уг тан нь туршилтын амьтанд коллаген-II-оор үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн цусны сийвэн болон үеийн эдэд агуулагдах малондиальдегидийн хэмжээг бууруулахаас гадна бие махбодын антиоксидант тогтолцоог нөхцөлдүүлж байдаг глутатион, супероксидисмутаза зэрэг ферментүүдийн хэмжээг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна. Эндээс харахад уламжлалт Лидэр-5 тан нь дээрх эмгэгийн үеийн антиоксидант тогтолцооны алдагдалаас урьдчилан сэргийлэх, эмчлэх нөлөөтэй байгаа бөгөөд уг нөлөө түүний найрлаганд агуулагдаж буй Лидэр, Дэгд зэрэг антиоксидант нөлөөтэй ургамлын гол үйлчлэгч бодисуудтай холбоотой байж болох юм.

Үндэслэл:

Ревматоид артрит нь шалтгаан тодорхойгүй, үеийн уутны сөнөрөлт гэмтлийг үүсгэдэг, сэдэрл намжил бүхий архаг явцтай холбогч эдийн өвчин юм. Уг өвчин нь удаан явцтай, тавилан муутай, дундаж наслалтыг 3-18 жилээр багасгадаг, нийт өвчтөнүүдийн 80% нь 20 жилийн дараа хөдөлмөрийн чадвар алдалтанд ордог аутоиммуны гаралтай эмгэг юм. Сүүлийн үеийн судалгаагаар нийт хүн амын 1% нь ревматоид артритээр өвчилсөн байдаг бөгөөд 40-50 насны эмэгтэйчүүд илүү өвддөг тухай судалгаа гарсан байна.[1]

Өнөө үед судлаачид ревматоид артритын эмгэг жамыг судлах, эмчилгээний шинэ аргыг үнэлэх зорилгоор янз бүрийн амьтан дээр олон төрлийн загварыг туршиж байгаа ч хулгана, харх зэрэг мэрэгчдийн загварыг илүүтэй ашигладаг. Учир нь эдгээр амьтад өртөг бага, генетикийг нь өөрчлөх боломжтой, өөрчилсөн тохиолдолд хурдан үржиж, уг өвчний эрт, ид, хожуу үе шат болгоны эмгэг жам, механизмыг илрүүлэх бололцоотой ажээ.

Нөгөө талаар сүүлийн жилүүдэд Америк, Япон зэрэг өндөр хөгжилтэй орны эрдэмтэн судлаачид ревматоид артритын эмчилгээнд антиоксидант нөлөөтэй эм бэлдмэлүүд хэрэглэх нь үр дүн сайтай болохыг тогтоогоод байна.

Тиймээс бид уламжлалт анагаах ухаанд тулай, хэрх болон үе мөчний шар усны өвчинд хэрэглэж ирсэн, найрлаганд нь Лидэр гэх мэт антиоксидант нөлөөтэй эмийн

түүхий эд орсон Лидэр-5 танг судлахаар сонгон авсан бөгөөд уг жор нь Хэрхийн тан хэмээн тэмдэглэгдэн ирсэн байдаг. Уг тан нь Лидэр (*Tinospora sinensis*), Ванлаг (*Gymnadenia conopsea*), Ар үр (*Terminalia chebula Retz*), Талгадорж (*Cassia tora*), Дэгд (*Gentiana decumbens*) зэрэг таван хөл эмээс бүрддэг. [2-5]

Зорилго:

Туршилтын амьтанд коллаген-II-оор үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд уламжлалт Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөөг судлах

Материал арга зүй:

Судалгааг АШУҮИС-АУС-ийн Уламжлалт анагаах ухааны институт, ӨМӨЗО-ны Хөх хотын Эм Эмнэлгийн Дээд Сургууль, Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн Эрдэм Шинжилгээний Төвийн Эм Судлалын Лабораторийг түшиглэн явуулсан. Туршилт судалгаанд ӨМӨЗО-ны Алаша аймгийн Эзэний Хошууны Монгол эмнэлэгт үйлдвэрлэсэн Лидэр-5 танг хэрэглэсэн.

Туршилтын амьтанд үений үрэвслийн эмгэг загвар 0.5 мг тугалын коллаген II (bovine type II collagen) ба 0.5 мг Фрейндийн хүчлүүр (incomplete Freund's adjuvant) агуулсан 1 мл цийдмэгийг хяналтын болон эмийн бүлгийн хархны нурууны 3 хэсэг газар арьсан дотор тарина. Үүнээс 7 хоногийн дараа цийдмэгийн хагас тунг (0.5 мл) мөн арьсан дотор тарина. Эрүүл бүлэгт физиологийн уусмалыг дээрхийн адилаар тарина. Үений үрэвсэл үүссэнийг хархны шагай орчим улайж хавдсан байдлыг ажиглаж тодорхойлно. Үений үрэвслэл цийдмэгийг тарьснаас хойш 14 хоногийн дараа ажиглагдах ба 28 хоногийн дараа хүнд хэлбэрийн үений үрэвсэл үүснэ. Цийдмэгийг эхэлж тарьснаас хойш 21 дэх хоногоос эхлэн харьцуулах бүлэгт ибуфропен эмийг 40 мг/кг тунгаар, Лидэр-5 тангийн усан хандыг 100 мг/кг ба 200 мг/кг тунгаар хархны биеийн жинд тооцож 21 хоногийн турш амаар өгнө. (А.М. Bendel, 2001) Туршилтын үр дүнг малондиальдегид, глутатион, супероксидисмутаза зэрэг ферментүүдийн хэмжээгээр тодорхойлсон.

Үр дүн:

Үрэвслийн үед бие махбодын өөхний хэт исэлдэлтийн процесс-антиоксидант (ӨХИП-АО) тогтолцооны тэнцвэр алдагдан Малондиальдегид, Диений конъюгат, Диений кетон зэрэг өөхний хэт исэлдэлтийн бүтээгдэхүүнүүд үрэвслийн голомт болон цусны сийвэнд ихэсдэгийг судлаачид тогтоосон байдаг. (Б.С.Утешеев, Ф.Я.Байурин. 1998) Бид дээрх судлаачдын судалгааны үр дүнд үндэслэн туршилтын 56 дахь хоногт туршилтын амьтадын цусны ийлдэс болон үений эдэд малондиальдегид болон глутатион (GSH), Суперокси дисмутаза ферментүүдийн хэмжээг тодорхойлсон.

Хүснэгт 1.

Үений үрэвслийн үеийн малондиальдегидийн хэмжээнд

Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөө

Бүлэг (мг/кг)	Малондиальдегид (nmoli/ml)	
	Ийлдэс	Сарвууны эд
Эрүүл	0.45±0.02	1.38±0.02
Ибупрофен(40)	0.84±0.02	3.25±0.21
Лидэр-5 (100)	0.59±0.01**	2.13±0.19**
Лидэр-5 (200)	0.76±0.05	2.84±0.25*
	0.60±0.03**	2.21±0.11**

*Хяналтын бүлэгтэй харьцуухад $p < 0.05$

** хяналтын бүлэгтэй харьцуулахад $p < 0.01$

Хүснэгтээс харахад хяналтын бүлгийн амьтадын үзүүлэлтүүдийг эрүүл бүлэгтэй харьцуулахад цусны сийвэнд агуулагдах МДА-ийн хэмжээ 1,9 дахин, үений эдэд агуулагдах МДА-ийн хэмжээ 2.4 дахин нэмэгдсэн байна. ($p < 0.001$)

Дээрх судалгааны үр дүнгээс харахад туршилтын амьтанд коллагенаар үүсгэсэн ревматоид артритын үед цусны сийван болон үений эдэд МДА-ийн хэмжээ статистикийн хувьд ач холбогдолтой ялгаатайгаар нэмэгддэг болох нь харагдаж байна.


Харин Лидэр-5 танг хэрэглэсэн бүлгийн амьтадын үзүүлэлтийг хяналтын бүлэг (0.84±0.02)-тэй харьцуулахад 100 мг/кг тун (0.76±0.05)-даа 10.5 хувиар бууруулж байсан бол 200 мг/кг тун (0.60±0.03)-даа 40 хувиар бууруулсан болох нь харагдаж байна. Мөн Лидэр-5 танг 200 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлгийн амьтадын цусны сийвэнд агуулагдах МДА-ийн хэмжээг 100 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлэгтэй харьцуулахад 26.7 хувиар буюу статистикийн хувьд ач холбогдолтойгоор бага байгаа болох нь харагдаж байна.

Мөн Лидэр-5 танг хэрэглэсэн бүлгийн амьтадын үений эдэд агуулагдах МДА-ийн хэмжээг хяналтын бүлэг (3.25±0.21)-тэй харьцуулахад 100 мг/кг тун (2.84±0.25)-даа 14.4 хувиар бууруулж байсан бол 200 мг/кг тун (2.21±0.11)-даа 47.1 хувиар бууруулсан болох нь харагдаж байна. Мөн Лидэр-5 танг 200 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлгийн амьтадын цусны сийвэнд агуулагдах МДА-ийн хэмжээг 100 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлэгтэй харьцуулахад 28.5 хувиар буюу статистикийн хувьд ач холбогдолтойгоор бага байгаа болох нь харагдаж байна.

Антиоксидант бодисууд нь хүчилтөрөгчийн идэвхитэй нэгдлүүдтэй харилцан үйлчлэлцэх ба чөлөөт радикалын урвалыг идэвхжүүлдэг төмөр, зэсийн ионыг зайлуулах, ханаагүй өөхний хүчил исэлдүүдлэгч хоёрын харилцан үйлчлэлийг хязгаарлаж эсийн бүтцийг хэвийн болгох, антиоксидант үйлдэлтэй супероксидисмутаза, каталаз, глутонинпероксидаз зэрэг ферментүүдийг идэвхжүүлдэг. Гиймээс эдгээр антиоксидант үйлдэлтэй ферментүүдийг тодорхойлсноор судлаж буй бэлдмэлийн үйлдлийн механизмыг тайлбарлахад чухал ач холбогдолтой юм.


Бид коллаген-II-оор ревматоид артритын эмгэг загвар үүсгэсэн амьтадын үеийн мөгөөрсөн эдээс гомогенат бэлтгэн түүнд агуулагдах глутатион, супероксидисмутаза ферментийн хэмжээг спектрофотометрийн аргаар тодорхойлсон.

Туршилтын дүнд туршилтын амьтанд үүсгэсэн ревматоид артритын үеийн үзүүлэлтүүдийг эрүүл амьтадын үзүүлэлтүүдтэй харьцуулахад Глутатионы хэмжээ 1,7 дахин, супероксидисмутазагийн хэмжээ 2.1 дахин буурсан байна. ($p < 0.01$)



Зураг 1. Туршилтын амьтанд үүсгэсэн үеийн үрэвслийн эмгэг загварын үеийн глутатионы хэмжээ, түүнд Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөө

Зургаас харахад туршилтын амьтанд үүсгэсэн ревматоид артритын эмгэг загварын үеийн глутатион ферментийн хэмжээ статистикийн хувьд ач холбогдолтойгоор буурдаг болох нь харагдаж байгаа бөгөөд уг эмгэгийн үед Лидэр-5 танг хэрэглэсэн бүлгийн амьтадын үзүүлэлтийг хяналтын бүлэг (2.67 ± 0.27)-тэй харьцуулахад 100 мг/кг тун (3.91 ± 0.28)-даа 26.9 хувиар, 200 мг/кг тун (4.01 ± 0.26)-даа 33.4 хувиар тус тус нэмэгдүүлсэн болох нь харагдаж байна. Мөн Лидэр-5 танг 100 мг/кг болон 200 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлгийн амьтадын глутатионы хэмжээхоорондоо статистикийн хувьд ач холбогдолтой ялгаагүй байна.



Зураг 2. Туршилтын амьтанд үүсгэсэн үений үрэвслийн эмгэг загварын үеийн супероксидсмутазагийн хэмжээ, түүнд Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөө

Зургаас харахад туршилтын амьтанд үүсгэсэн ревматоид артритын эмгэг загварын үеийн супероксидсмутаза ферментийн хэмжээ статистикийн хувьд ач холбогдолтойгоор буурдаг болох нь харагдаж байгаа бөгөөд уг эмгэгийн үед Лидэр-5 танг хэрэглэсэн бүлгийн амьтадын үзүүлэлтийг хяналтын бүлэг (155.8 ± 15.9)-тэй харьцуулахад 100 мг/кг тун (239.5 ± 23.1)-даа 1.5 дахин нэмэгдүүлсэн байсан бол 200 мг/кг тун (276.0 ± 17.2)-даа 1.8 нэмэгдүүлсэн болох нь харагдаж байна. Мөн Лидэр-5 танг 200 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлгийн амьтадын супероксидсмутазагийн хэмжээг 100 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлэгтэй харьцуулахад статистикийн хувьд ач холбогдолтой ялгаатайгаар нэмэгдүүлсэн болох нь харагдаж байна.

Дээрх туршилтын амьтанд үүсгэсэн үений үрэвслийн эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны өөрчлөлт түүнд уламжлалт Лидэр-5 тангийн үзүүлэх нөлөөг судласан судалгааны үр дүнгээс үзэхэд уг тан нь дээрх эмгэгийн үед бие мах бодид үүссэн хэт исэлдэлтийн хортой бүтээгдэхүүнийг буурах нөлөөтэйгээс гадна антиоксиданд үйлдэл үзүүлдэг зарим ферментийн хэмжээг нэмэгдүүлэх замаар антиоксидант идэхи үзүүлдэг болох нь харагдаж байна.

Хэлцэмж:

Монголын уламжлалт анагаах ухаан нь олон зууны турш уламжлагдан баяжигдсаар ирсэн, хүн төрөлхтний түүхэнд соёл иргэншилд оруулсан томоохон өв сан бөгөөд үүний нэгээхэн хэсэг нь ургамал, амьтан, эрдэст бодисын үйлдлийг танин мэдэж, идээ ундаа, эм тан байдлаар хэрэглэж ирсэн уламжлалт арга ухаан юм.

Монгол улсад уламжлалт анагаах ухаан дахин сэргэн хөгжиж эхлээд 50 гаруй жилийн дотор эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт, боловсрол, эмнэлгийн тусламж, эм тангийн үйлдвэрлэлийн бүхий л чиглэлээр багагүй амжилтанд хүрч шинэ мэдлэг, мэдээ баримт, туршлага багагүй хуримтлагдсан байна. Нөгөө талаар дэлхий нийтээрээ дорно

дахины ард түмний уламжлалт анагаах ухааныг сонирхон судлахад анхаарлаа хандуулах болжээ.

Бидний судлахаар сонгон авсан Лидэр-5 тан нь Лидэр (*Tinospora sinensis*), Ванлаг (*Gymnadenia conopsea*), Ар үр (*Terminalia chebula Retz*), Талгадорж (*Cassia tora*), Дэгд (*Gentiana decumbens*) зэрэг таван хөл эмээс бүрдсэн уламжлалт жор бөгөөд судалгааны үр дүнд уг тан нь туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн цусны сийвэнд агуулагдах МДА-ийн хэмжээ хяналтын бүлэг 1,9 дахин, үений эдэд 2,4 дахин нэмэгдсэн байна. Мөн глутатион 1,7 дахин, супероксидисмутазагийн хэмжээ 2,1 дахин буурсан байна. Эндээс харахад туршилтын амьтанд коллаген-II-оор үүсгэсэн артритын эмгэг загварын үед антиоксидант тогтолцоонд ихээхэн өөрчлөлт гарсан байгаа бөгөөд энэ нь бусад судлаачидын судалгааны үр дүнтэй тохирч байна. Тухайлбал Энэтхэгийн эрдэмтэд болох Pallinti Vasanthi, Nalini Ganesan, Chegu Hariprasad, G Rajasekhar, S Meera нар туршилтын амьтанд үүсгэсэн ревматоид артритын үед МДА-ийн хэмжээ нэмэгддэг болохыг тогтоосон⁶ байдаг бол Туркийн эрдэмтэд болох Nurettin Tastekin, Nurettin Aydogdu, Dikmen Dokmeci, Ufuk Usta, Murat Birtane, Hakan Erbas, Mevlut Ture нар туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үед МДА-ийн хэмжээ нэмэгдэхээс гадна глутатион, супероксидисмутаза, каталаза зэрэг ферментүүдийн хэмжээ буурдаг болохыг тогтоосон байна.⁷

Харин Лидэр-5 тан хэрэглэсэн бүлгийн амьтадын үзүүлэлтүүдийг хяналтын бүлэгтэй харьцуулахад 200 мг/кг тундаа цусны сийвэнд агуулагдах МДА-ийн хэмжээг 40 хувиар, үений эдэд агуулагдах МДА-ийн хэмжээг 47,1 хувиар тус тус бууруулж байсан бол глутатионы хэмжээг 26,9-33,4 хувиар, супероксидисмутазагийн хэмжээг 1,5-1,8 дахин нэмэгдүүлсэн байна.

Дээрх үр дүнгээс харахад Лидэр-5 тан нь туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд эерэг нөлөөтэй байгаа бөгөөд уг үйлдэл түүнд агуулагдаж буй эмийн түүхий эдүүдийн гол үйлчлэгч бодисуудтай холбоотой байж болох юм. Тухайлбал Лидэр, Дэгд нь софоридин, цитизин, N-оксиэтилцитизин, софокарпин, неософорамин, баптифолин, изософоридин, софорамины N-исэл алоперин, аллилалоперин, N-метилалоперин, матрин, трикротопилтетрамин, софорин, 3-окси-α-софоридин, 13, 14-дегидрософоридин, түүний N-исэл зэрэг олон төрлийн алкалоидууд агуулдаг [7,8] бөгөөд Энэтхэгийн эрдэмтэд болох Sanjay Jain, Bhumika Sherlekar, Rakesh Barik нар Лидэр (*Tinospora sinensis*)-ийн антиоксидант идэвхитэй болохыг түгтоосон байдаг.¹⁰

Дүгнэлт:

Уламжлалт Лидэр-5 тан нь туршилтын амьтанд үүсгэсэн артритын эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалыг засах нөлөөтэй байна.

Ном зүй:

1. Kong, Y., Feige, U., Sarosi, I. et al. (1999). *Activated T cells regulate bone loss and joint destruction in adjuvant arthritis through osteoprotegerin ligand*. Nature. 1999;402:p304-309
2. Ж.Сүрэнжав. Монгол анагаах ухааны эм найрлагын судлал. ӨМӨЗО. Ардын хэвлэлийн хороо. Хөх хот. 1991 он. х.126-127
3. Дараммаарамба. Бэрх онисны учир зангилааг тайлагч. ӨМӨЗС. Ардын хэвлэлийн хороо, Хөх хот. 1990 он. х.135-143
4. Тован Гомбожав. Монгол ёсны нууц уламжлалт заслын үндэс. ӨМӨЗО. Ардын хэвлэлийн хороо, Хөх хот. х.302
5. Хангайбаатар. Бай чин юны эмчилгээний туршлагат жор. ӨМӨЗО. Ардын хэвлэлийн хороо, Хөх хот. х.115
6. Pallinti Vasanthi, Nalini Ganesan, Chegu Hariprasad, G Rajasekhar, S Meera. Plasma lipophilic antioxidant and pro-oxidant levels in rheumatoid arthritis. J Indian Rheumatol Assoc 2004 : 12 : 40 – 42
7. Nurettin Tastekin, Nurettin Aydogdu, Dikmen Dokmeci, Ufuk Usta, Murat Birtane, Hakan Erbas, Mevlut Ture. Protective effects of l-carnitine and alpha-lipoic acid in rats with adjuvant arthritis. Pharmacological Research 56 (2007) 303–310
8. Хүрэлчулуун Б, Ө.Батчимэг. Монгол эмэнд хэрэглэдэг гадаад ургамлын түүхий эд. Улаанбаатар хот, 2004 он. Эрхэс хэвлэх үйлдвэр. х. 10-12, 88-89
9. Лигaa У нар. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. Улаанбаатар: JKC printing; 2005. х. 153.
10. Sanjay Jain, Bhumika Sherlekar, Rakesh Barik. Evaluation of antioxidant potential of *tinospora cordifolia* and *tinospora sinensis*. International Journal of Pharmaceutical Sciences and Research. 2010; Vol. 1 (11): 122-128.

Abstracts

Traditional drug Lider-5 traditional medicine, rheumatism and arthritis disease which has been used experimental animals we created arthritis disease antioxidant system of the Lider-5 studied the impact of the loss. As a result of the research that you created via a test animal collagen II arthritis pathological articular tissues and blood plasma contained malondialidye gid In addition to reducing the antioxidant Glutathione is provided a system of the body, including supyeroksidismutaza enzymes to increase the amount of influence. As you can see in the traditional drug Lider-5 disorders antioxidant system, loss prevention, and treatment is effective, the effects of its ingredients contained *Tinospora sinensis*, *Gentiana decumbens*, such as antioxidant effect might be associated with key plant attendant substances.

Key words: Traditional drug Lider-5, antioxidant, rheumatism

Харханд адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварт уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судласан дүн

А.Гүйцэд¹, Г.Зулаа¹, Улаан¹, Б.Ууганбаяр²

¹БНХАУ-ын ӨМӨЗО, Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн хороо

²Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн

Үндэслэл:

Бөөр нь бие махбодын шингэнийг шүүж хортой бодисоос цэвэрлэдэг эрхтэн юм. Хүний цусанд дахь хортой бодис, шингэн нь бөөрний түүдгэнцэр гэж нэрлэгддэг хялгасан судасны өвөрмөц системээр дамжин бөөрний бүрхэвчинд очдог.

Бөөрний түүдгэнцрийн үрэвсэл буюу гломерулонефрит нь бодисын солоилцоо болон дархлаа тогтолцооны гажуудлын улмаас бөөрний завсрын эд гэмтэж, улмаар бөөрний шүүх үйл ажиллагаа алдагддаг өвчин юм. Уг өвчнөөр голчлон 5-15 насны хүүхэд болон 30 хүртэлх насны залуучууд өвчлөх хандлагатай байдаг бөгөөд 40-өөс дээш насанд өвчлөх магадлал ердөө 10 хувь байдаг байна. Харин хүйсийн харьцааны хувьд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийг бодвол 2 дахин илүү өвчлөх хандлагатай.¹

Уг эмгэгийн үед цустай шээх, хавагнах, даралт ихсэх, шээсний хэмжээ багасах, ууц нуруу, бөөрөөр хөших, чилэх, халуурах, амьсал давчдах, үе мөчөөр өвдөх, жин нэмэгдэх, хэвлийгээр өвдөх, дотор муухайрах, хоолны дуршил буурах, суулгах, бөөлжих, амьсгалын замын халдвар авах, амны салст үрэвсэж, шархлах зэрэг олон шинж тэмдэг илэрдэг бөгөөд бүрэн гүйцэд эмчлээгүйгээс хүүхэд, идэр залуу насны хүмүүсийг хөдөлмөрийн чадвар алдалт цаашлаад нас баралтын нэг том шалтгаан болж байгаа нь эмч судлаачдын анхаарлыг татаж байна.²

Уламжлалт анагаах ухаанд бөөрний өвчин эмгэгийг эмчлэх олон арга байдаг бөгөөд үүний нэг уламжлалт сармисан туулга юм. Уг засал нь Монголын уламжлалт анагаах ухааны нэг чухал эмчилгээний арга бөгөөд эрт дээр үеэс архаг өвчин болон халуун өвчнүүдийн үед хэрэглэсээр иржээ.³⁻⁴

Зорилго

Бээжин үүлдрийн харханд Адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварт уламжлалт сармисан туулгын үзүүлэх нөлөөг судлах

Зорилт

1. Туршилтын амьтанд үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн шээсний шинжилгээний өөрчлөлтөнд уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судлах
2. Бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн зарим уургийн болон өөх тосны солилцооны алдагдалд уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судлах
3. Дээрх эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдал болон цитокины хөдлөл зүйд уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судлах

4. Уг эмгэгийн үеийн бөөрний бичил бүтэцийн алдагдалд уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судлах

Материал, арга зүй

Туршилт судалгааг ӨМӨЗО-ны Хөх хотын Анагаах ухааны их сургууль, Олон улсын Монгол эмнэлгийн хорооны материаллаг баазыг түшиглэн Бээжин үүлдрийн 60 толгой харх ашиглан хийсэн. Туршилтанд хэрэглэсэн Сармисаны хувилгасан туулгыг Хөх хотын Олон улсын Монгол эмнэлгийн хорооны эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн.

Туршилтын амьтадыг эрүүл, хяналт, харьцуулах, Сармисаны хувилгасан туулгын бага, дунд, өндөр тун гэсэн нийт 6 бүлэгт хувааж эрүүлээс бусад бүлэгт Адриамициныг 7.5мг/кг тунгаар сүүлний хураагуур судсаар нэг удаа тарьж бөөрний үрэвслийн эмгэг загварыг үүсгэсэн.⁵ Үүнээс хойш 3 хоногийн дараанаас сармисан туулгыг 100 мг/кг, 200мг/кг, 300мг/кг тунгуудаар 3 хоног зориулалтын зонд ашиглан амаар өгсөн бөгөөд үр дүнг лабораторийн болон гистологийн шинжилгээгээр үнэлсэн.

Үр дүн:

Бид туршилтын амьтанд адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үед уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг судлахдаа юуны өмнө шээсэнд агуулагдах уургийн хэмжээг туршилтын 4, 5, 6 дэх хонгуудад тодорхойлсон.

Хүснэгт 1.

Адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн шээсний уургийн хэмжээнд сармисан туулгын үзүүлэх нөлөө

Бүлэг Эрүүл	Urine protein (mg/24h)			
	Pre injection	4Day after injection	5 day	6 day
Хяналт	8.57±1.78	7.82±1.14	7.79±2.06	7.94±2.19
Сармисан туулга 100mg/kg	7.67±1.92	49.18±29.03	300.87±163.81	401.54±169.87
Сармисан туулга 200mg/kg	8.85±2.63	45.54±29.53	201.87±126.81*	211.62±112.36* *
Сармисан туулга 300mg/kg	7.57±1.81	48.87±15.51	248.67±150.79	230.76±91.34**
Бүлэг	8.58±2.1	44.91±25.71	181.33±74.01**	102.91±71.25**
Prednisone	7.89±1.99	49.83±29.84	201.63±118.71*	111.95±86.36**

*p<0.05 vs. controls, **p<0.01 vs. controls.

Хүснэгтээс харахад Сармисан туулга хэрэглэсэн бүлгийн амьтадын шээсний уургийн хэмжээг хяналтын бүлэгтэй харьцуулахад 2-3 хоног туулга хэрэглэсний статистикийн хувьд ач холбогдолтой ялгаатайгаар бууруулсан байгаа бөгөөд ялангуяа 300мг/кг тундаа 1.7-3.9 дахин бууруулсан байна. (p<0.05)

Туршилтын амьтанд адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн үед өөх тосныболон уургийн солилцоонд нилээд өөрчлөлт гардаг бөгөөд энэ үед Сармисан

туулгын үзүүлэх нөлөөг судлахдаа 3 хоног туулга хэрэглэсний дараа цусны сийвэнд агуулагдах триглицерид, нийт холестерин, нийт уураг, альбумины хэмжээг тодорхойлсон. их нягтралтай липопротейд, бага нягтралтай липопротейд зэрэг үзүүлэлтүүдээр үнэлсэн.

Хүснэгт 2.

Адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн өөх тос, уургийн солилцооны алдагдалд сармисан туулгын үзүүлэх нөлөө

Бүлэг	TG	TC	TP	Alb
Эрүүл	1.25±0.25	1.09±0.18	73.81±9.02	29.01±5.34
Хяналт	3.74±1.57	3.78±1.25	52.10±10.57	16.12±4.48
Сармисан туулга 100mg/kg	3.31±0.71	2.63±0.78*	50.67±7.50	15.33±4.27
Сармисан туулга 200mg/kg	3.60±1.90	3.23±0.98	55.81±6.72*	16.05±1.46
Сармисан туулга 300mg/kg	1.60±0.26**	1.12±0.33**	57.01±3.48**	17.98±2.93**
Prednisone	2.92±1.28*	3.52±1.35	51.00±7.89	16.60±4.58

*p<0.05 vs. controls, **p<0.01 vs. controls.

Хүснэгтээс харахад туршилтын амьтанд адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн өөх тос, уургийн солилцооны алдагдалд сармисан туулгыг 300 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлэг нь илүү сайн нөлөө үзүүлсэн байгаа бөгөөд триглицеридийн хэмжээг 2.3 дахин, нийт холестерин хэмжээг 3.4 дахин бууруулж, нийт уургийн хэмжээг 9.4%, альбумины хэмжээг 11.5%-иар тус тус нэмэгдүүлсэн байна. (p<0.05)

Бид мөн туршилтын амьтанд үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдал болон зарим цитокины хөдлөл зүйд сармисан туулгын үзүүлэх нөлөөг 3 хоног туулга хэрэглэсний дараа тодорхойлсон.

Хүснэгт 3.

Адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд сармисан туулгын үзүүлэх нөлөө

Бүлэг	SOD (U/ml)	MDA (nmol/ml)	TNF-α	IL-8
Эрүүл	27.95±5.68	3.02±0.74	2.58±0.26	44.77±7.41
Хяналт	11.84±2.08	5.72±0.94	7.82±0.84	147.86±19.71
Сармисан туулга 100mg/kg	19.44±3.71*	3.53±1.22*	5.07±0.26*	81.05±22.03*
Сармисан туулга 200mg/kg	23.35±2.96*	3.45±1.21*	4.56±0.53*	76.22±15.47*
Сармисан туулга 300mg/kg	21.83±4.74*	3.82±1.08*	6.02±0.81*	84.52±17.51*

Prednisone	19.76±3.52*	4.46±1.25*	5.81±0.35*	85.28±23.14*
------------	-------------	------------	------------	--------------

*p<0.05 vs. controls.

Хүснэгтээс харахад туршилтын амьтанд үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн антиоксидант тогтолцооны алдагдалд Сармисан туулга нь аль ч тундаа статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаатайгаар эерэг нөлөө үзүүлсэн байгаа бөгөөд супероксидсмутаза (SOD)-ийн хэмжээг 1.6-2 дахин нэмэгдүүлж, малондиальдегид (MDA)-ийн хэмжээг 1.5-1.7 дахин бууруулсан байна. (p<0.05)

Мөн уг туулга нь туршилтын амьтанд үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үеийн TNF- α -ийн хэмжээг 1.3-1.7 дахин, IL-8-ын хэмжээг 1.8-1.9 дахин бууруулсан байна.

Дээрх лабораторийн шинжилгээний үр дүнгүүдээс харахад уламжлалт Сармисан туулга нь туршилтын амьтанд үүсгэсэн бөөрний хурц үрэвслийн эмгэг загварын үеийн өөх тос, уургийн солилцооны алдагдалаас урьдчилан сэргийлэхээс гадна уг эмгэгийн үеийн антиоксидант тогтолцооны алдагдал, цитокины хөдлөл зүйд эерэг нөлөө үзүүлдэг болох нь харагдаж байна.

Бид мөн дээрх эмгэгийн үеийн бөөрний бичил бүтэцийн алдагдалд уламжлалт Сармисан туулгын үзүүлэх нөлөөг харьцуулан судласан.




Figure. 1. TD prevents the ultrastructural lesions induced by adriamycin on podocyte foot processes.

Зургаас харахад адриаминээр харханд бөөрний хурц үрэвслийн эмгэг загвар үүсгэхэд бөөрний подоцит эсийн мембраны хэвийн бүтэц алдагдсан байгаа бол Сармисан туулга хэрэглэсэн бүлгийн амьтадын хувьд эсийн мембраны гэмтлээс урьдчилан сэргийлж байгаа болох нь харагдаж байна.

Хэлцэмж

Адриаамин нь бөөрний түүдгэнцэрийн нэвчүүлэх үйл ажиллагааг сонгомлоор гэмтээдэг бодис бөгөөд бид уг бодисыг хархны сүүлний хураагуур судсаар 7.5 мг/кг тунгаар тарьж эмгэг загвар үүсгэсэн. Уг эмгэг загварын үед уламжлалт Сармисан туулгыг 100 мг/кг, 200 мг/кг, 300 мг/кг гэсэн 3 ялгаатай тунгаар 3 хоног хэрэглэсний дараа уг туулгын үр дүнд лабораторийн болон гистологийн шинжилгээгээр үнэлсэн. Бидний судалгаагаар адриааминээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үед шээсээр уураг алдах, цусан дахь триглицерид 3 дахин, нийт холестерин 3.5 дахин нэмэгдэж, нийт уургийн хэмжээ 1.4 дахин, альбумин 1.8 дахин буурсан байна. Энэ бусад судлаачдын үр дүнтэй дүйж байгаа бөгөөд Японы эрдэмтэн Eiya Okuda, Yukinori Oh, Hiroshi Tsuruda, Kaoru Onoyama, Satoru Fujimi, Masatoshi Fujishimanар харханд адриааминээр үүсгэсэн бөөрний үрэвслийн үед цусан дахь холестерин хэмжээ нэмэгдэж, альбумины хэмжээ буурдаг болохыг тогтоосон байдаг.⁶

Мөн Хятадын эрдэмтэд болох Zhi-Hui Ding, Li-Min Xu, Shu-Zhi Wang, Jian-Qun Kou, Yin-Li Xu, Cao-Xin Chen, Hong-Pei Yu, Zheng-Hong Qin, Yan Xie болон Америкийн эрдэмтэн R Franco, A Gut, A Ferrari-Spadotto, J Georgette, I Gavras and H Gavras нар дээрх эмгэгийн үед цусан дахь холестерин, триглицерид буурч альбумин буурдаг болохыг судлан тогтоожээ.^{7,8}

Харин бидний хэрэглэсэн сармисан туулга нь 3 хоног хэрэглэхэд 300 мг/кг тундаа шээсний уургийн хэмжээг 1.7-3.9 дахин, цусан дахь триглицеридийн хэмжээг 2.3 дахин, нийт холестерин хэмжээг 3.4 дахин тус тус бууруулж, нийт уургийн хэмжээг 9.4%, альбумины хэмжээг 11.5%-иар тус тус нэмэгдүүлсэн байна. ($p < 0.05$)

Бид мөн дээрх эмгэг загвар үүсгэсэн амьтадын цусанд агуулагдах SOD, MDA болон TNF- α , IL-8 зэргийн хэмжээг тодорхойлсон. Судалгааны үр дүнд хяналтын бүлгийн амьтадын үзүүлэлтүүдийг эрүүл бүлэгтэй харьцуулахад SOD-ын хэмжээ 2.4 дахин буурч, MDA-ын хэмжээ 1.9 дахин, TNF- α -ын хэмжээ 3 дахин, IL-8-ын хэмжээ 3.3 дахин нэмэгдсэн байна. Испанийн эрдэмтэд болох T. Bricio, A. Molina, J. Egidio, E. Gonzalez, F. Mampasonар харханд адриааминээр үүсгэсэн бөөрний үрэвслийн үед шээсээр уураг алдахаас гадна IL-1 зэрэг цитокинүүд нэмэгддэг болохыг тогтоосон байдаг.⁹

Rene Kamgang, Angele Foyet Fondjo, Jean-Louis Essame Oyono зэрэг судлаачид харханд адриааминээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үед цусан дахь MDA-ын хэмжээ нэмэгдэж, SOD-ын хэмжээ буурдаг болохыг тогтоосон байдаг¹⁰ бол Хятадын эрдэмтэд болох Chun-Ling Liang, Jun-Biao Wu, Jie-Mei Lai, Shu-Fang Ye, Jin

Lin, Hui Ouyang, Janis Ya-Xian Zhan, Jiu-Yao Zhou нар цусан дахь MDA нэмэгдэж, SOD буурахаас гадна IL-8 нэмэгдэж, IL-4 буурдаг болохыг тогтоосон байна.¹¹

Харин Сармисан туулга 100 мг/кг, 200 мг/кг, 300 мг/кг тундаа супероксидисмутаза (SOD)-ийн хэмжээг 1.6-2 дахин нэмэгдүүлж, малондиальдегид (MDA)-ийн хэмжээг 1.5-1.7 дахин бууруулахаас гадна TNF- α -ийн хэмжээг 1.3-1.7 дахин, IL-8-ын хэмжээг 1.8-1.9 дахин бууруулж байна. ($p < 0.05$)

Дээрх эмгэг загварын үед бөөрний бичил бүтцэд ихээхэн эмгэг өөрчлөлт гардаг бөгөөд бидний судалгаагаар подоцит эсийн мембран гэмтэж үйл ажиллагаа нь алдагдсан болох нь гистологийн шинжилгээгээр тогтоогдсон бөгөөд Сармисан туулга нь уг эмгэг өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх нөлөө үзүүлж байна.

Мексикийн эрдэмтэд болох Pablo Bautista-Garcia, Josy L. Reyes, Dolores Martini, Magna C. Namorado, Bibiana Chavez-Munguna, Elizabeth Soria-Castro, Otmar Huber, Lorenza Gonzalez-Mariscal нар лабораторийн цагаан хулганад адриамицинээр үүсгэсэн бөөрний үрэвслийн эмгэг загварын үед лабораторийн шинжилгээний өөрчлөлтүүдээс гадна подоцит эсийн гэмтэл үүсч бөөрний нэвчүүлэх үйл ажиллагаа алдагддаг болохыг тогтоосон байдаг.¹¹

Дүгнэлт

Уламжлалт Сармисан туулга нь туршилтын амьтанд үүсгэсэн бөөрний хурц үрэвслийн эмгэг загварын үеийн өөх тос, уургийн солилцоо, антиоксидант тогтолцооны алдагдал, цитокины хөдлөл зүйд эерэг нөлөөтэйгээс гадна бөөрний подоцит эсийн гэмтлээс урьдчилан сэргийлэх замаар бөөр хамгаалах нөлөө үзүүлж байна.

Ном зүй

1. Х.Гэлэгжамц, Д.Энхзаяа, Т.Ариунаа, Ж.Тамир, Ж.Энхтуяа, Бөөр судлал сурах бичиг УБ 2006 он, х. 244-245
2. Ж.Тамир, Т.Ариунаа, Бөөрний архаг өвчин, тодорхойлолт, ангилал, онош, эмчилгээний орчин үеийн асуудлууд, МАУ 2007 №2 х. 53-57
3. Анагаах Ухааны Дөрвөн Үндэс, ӨМӨЗО, Хөх хот: 1997.
4. Ишданзанваанжил. Жүрү досил. Элэгний өвчнийг засах 32-р бүлэг. Улаанбаатар хот: Армийн хэвлэх үйлдвэр; 1991 он.
5. Bertani T, Poggi A, Pozzoni R, Delaini F, Sacchi G, Thoua Y, Mecca G, Remuzzi G, Donati MB. Adriamycin-induced nephrotic syndrome in rats: sequence of pathologic events. *Lab Invest.* 1982 Jan;46(1):16-23.
6. Eiya Okuda, Yukinori Oh, Hiroshi Tsuruda, Kaoru Onoyama, Satoru Fujimi, Masatoshi Fujishima. Adriamycin-induced nephropathy as a model of chronic progressive glomerular disease. *Kidney International*, Vol. 29 (1986), PP. 502—510
7. Zhi-Hui Ding, Li-Min Xu, Shu-Zhi Wang, Jian-Qun Kou, Yin-Li Xu, Cao-Xin Chen, Hong-Pei Yu, Zheng-Hong Qin, Yan Xie. Ameliorating Adriamycin-Induced Chronic Kidney Disease in Rats by Orally Administrated Cardiotoxin from *Naja naja atra*

- Venom. Evidence-Based Complementary and Alternative Medicine. Volume 2014, Article ID 621756, 10 pages. <http://dx.doi.org/10.1155/2014/621756>
8. R Franco, A Gut, A Ferrari-Spadotto, J Georgette, I Gavras and H Gavras. Pressor mechanisms in adriamycin-induced nephropathy with hypertension in rats. Hypertension. January 1994. Vol 23, No 1. 246-249.
 9. T. Bricio, A. Molina, J. Egido, E. Gonzalez, F. Mampaso. IL-1-like production in adriamycin-induced nephrotic syndrome in the rat. Clin. exp. Immunol (1992) 87, 117-121.
 10. Rene Kamgang, Angele Foyet Fondjo, Jean-Louis Essame Oyono. Effect of methanolic fraction of kalanchoe crenata on renal morphophysiology in adriamycin-induced impaired kidney in rats. International Journal of Pharmacy and Pharmaceutical Sciences. Vol 7, Issue 2, 2015.
 11. Chun-ling Liang, Jun-biao Wu, Jie-mei Lai, Shu-fang Ye, Jin Lin, Hui Ouyang, Janis Ya-xian Zhan, and Jiu-yao Zhou. Protection Effect of Zhen-Wu-Tang on Adriamycin-Induced Nephrotic Syndrome via Inhibiting Oxidative Lesions and Inflammation Damage.
 12. Pablo Bautista-Garcia, Josй L. Reyes, Dolores Martнn, Magna C. Namorado, Bibiana Chavez-Munguа, Elizabeth Soria-Castro, Otmar Huber, Lorenza Gonzйlez-Mariscal. Zona occludens-2 protects against podocyte dysfunction induced by ADR in mice. Am J Physiol Renal Physiol 304: F77–F87, 2013.

Abstract

Experimental animals created in adriamycin-induced nephropathy effects of traditional drug “Sarmisan tuulga” 1.7-3.9 times the amount of protein in the urine, serum triglycerides contained 2.3 times and 3.4 times the total amount of cholesterol reduction. And on disorders SOD increased 1.6-2 times the amount of MDA's 1.5-1.7 times, TNF- α 1.3-1.7 times the amount of IL-8 is 1.8-1.9 times the amount of reduction. According to the results of traditional drug “Sarmisan tuulga” in experimental animals acute inflammatory kidney disorder created by the generation of fat, protein exchange, antioxidant system loss, expedient gesture cytokine and podocyte kidney renal protective effect by preventing cell damage.

Key words: Traditional drug “Sarmisan tuulga”, nephropathy, adriamycin

Системийн анагаах ухаан ба эм найруулгын онцлог

Д.Амарзаяа¹, Б.Дагвацэрэн², Ч.Чимэдрагчаа², Л.Пүрэвжав¹, Д.Цэнд-Аюуш³

¹УАУТХ, УАУ-ны төв эмнэлэг

²Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн

³АШУҮИС, Монгол Анагаах Ухааны Институт

Үндэслэл: Сүүлийн 20-иод жил бие махбод, эд эрхтэн, эсийн дотоод, гадаад олон хүчин зүйлийн хоорондын харьцаа хамаарлыг олон салбар шинжлэх ухааны зааг дээр загварчлан судалсны үр дүнд Системийн биологи (systems biology), Системийн анагаах ухаан (systems medicine), Системийн эм судлал (systems pharmacology) гэсэн судалгааны шинэ чиглэл хандлага төлөвшин эрчимтэй хөгжиж байна (Т.Горбунова, О.В.Демин, 2010; Yan Giong Zhang, Danhua Wang Shufang Tan et.all, 2013). Тухайн шинэлэг хандлага, арга зүйн үүднээс авч үзвэл уламжлалт анагаах ухаан, түүний эм найруулах арга нь өвчний ангилал, явц, үе шат, мөн эд эрхтний хоорондын харьцаа хамаарлыг тусгасан системийн шинж чанартай болж ирж байна.

Уламжлалт анагаах ухаанд цөөн болон олон найрлагатай эм танг найруулахдаа бүлэглэн шатлах зарчмыг ашигласан байдаг. Бүлэглэн шаталж эм найруулах зарчим нь цөөн эмт бодисыг голлогч буюу үндсэн суурь болгон сонгон авч өвчний явцтай нь уялдуулан бусад эмт бодисыг хөл болгон нэмэх замаар олон найрлагатай эмийн жорыг бүтээсэн байдаг. Энэ эм найруулах аргын мөн чанар, үндэслэлийг судлах нь онол практикийн ач холбогдолтой бөгөөд шинэ эм бүтээх арга зүйн үндэслэл бий болно.

Түлхүүр үг. Бүлэглэн шаталж эм найруулах арга, системийн уламжлалт анагаах ухаан, голлогч эмт бодис, жолоодогч эмт бодис, өвчний орон, язгуурын ангилал

Материал арга зүй: Судалгааны хэрэглэгдэхүүнээр “Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Номлохуйн үндэс”-ний өвчний ялгалыг үзүүлсэн 12-р бүлэг, “Шинжлэл заслыг тодорхойлсон хойд үндэс”-ийн амьдруулан үйлдэх эмийн орны талх эмийн аймгийг үзүүлсэн 4-р бүлэг, өвсөн эмийн аймгийг үзүүлсэн 12-р бүлгийг сонгож авсан.

Бие махбод ба гадны нөлөөт орчны хүчин зүйлсийн хамаарлын зохиролт харьцаанаас үндэслэн боловсруулсан эмт бодис ба эмийн хий, шар, бадганы гэмд нөлөөлөх жишиг итгэлцүүрийг тооцох аргыг (Б.Дагвацэрэн, 1996) ашиглан бүлэглэн шаталж найруулсан эмүүдийн хий, шар, бадганд нөлөөлөх жишиг итгэлцүүрийг тооцсон.

Үр дүн: Бүлэглэн шаталж найруулсан 122 жорын хий, шар, бадганыг дарах жишиг итгэлцүүрийг тогтоолоо. Талх (УАУ-д нунтагласан эмийг хэлнэ), өвсөн эмийн аймагт буй бүлэглэн шаталж найруулсан эмийн жор найралтуудыг нэгтгэвэл (Хүснэгт 1)

Талх ба өвсөн эмийн аймагт багтах бүлэглэн шаталсан
эмийн жор найрлага

Хүснэгт 1

№	Бүлэглэн шаталж найруулсан жорын бүтэц	Тоо
1	Түшмэл гүргүмийн найрлага	14
2	Дунд халууныг арилгах зандангийн найрлага	15
3	Хүч ихтэй халууныг арилгах гаварын найрлага	15
4	Голлогч габүрийн найрлага	7
5	Анар голлосон найрлага	19
6	Анар-8 найрлага	8
7	Даль голлосон	9
8	Гаранзын найрлага	6
9	Халууныг арилгагч жолоодлоготой өвсөн эмийн найрлага	20
10	Хүйтнийг арилгагч жолоодлоготой өвсөн эмийн найрлага	9
Нийт		122

Олон найрлагатай уламжлалт эм танг бүлэглэн шаталж найруулах арга нь дотроо хэд хэдэн ялгаатай байна. Үүнд:

1. Хөндлөн хэлбэрийн бүлэглэн-шаталсан бүтэцтэй жор найрлага.
2. Босоо хэлбэрийн бүлэглэн шаталж эм найруулах арга.
3. Ташуу буюу салаалсан хэлбэрийн бүлэглэн шаталсан найрлагатай жорууд.
4. Холимог хэлбэрт дээрх гурван хэлбэрийн бүлэглэн-шаталж найруулах аргыг хамт хэрэглэснийг хэлнэ.

Дээрхи бүлэглэн-шаталсан бүтэцтэй дөрвөн хэлбэрийн эм найруулах аргаас хөндлөн хэлбэрийн жор найрлаганд багтах Гүргүм-7 жорын найрлагыг авч үзлээ. Талхан эмийн аймагт Гүргүм-7 найрлагууд нь хэвтээ буюу хөндлөн шатлалд багтах бөгөөд гүргүм, гиван, жуган 3-ыг голлогч болгон сонгон аваад эрхтэн, өвчний орон байдлыг харгалзан өөр дөрвөн эмт бодис нэмж элэгний, дэлүүний, олгойн, бөөрний г.м. Гүргүм-7-ийн цуврал жоруудыг бий болгожээ. Дэдлэгч Гүргүм-7 жорын хий, шар, бадганыг дарах жишиг итгэлцүүрийг тооцсон дүнг харуулав (Хүснэгт 2).

Бүлэглэн шаталж найруулсан дэдлэгч Гүргүм-7-ийн найруулсан 14 жорын жишиг итгэлцүүрийг тооцсон дүн

Хүснэгт 2

№	Эм, тангийн нэр	Хийг дарах ЖИ	Шарыг дарах ЖИ	Бадганыг дарах ЖИ	Эм, тангийн чадал
1	Гүргүмийн Голлогч-3	0.83 (++)	1.3 (+++)	(-)	-
2	Зүрхний халууны Гүргүм-7	0.78 (++)	0.72 (++)	0.13 (+)	Зүрхний халууныг арилгана.

3	Уушгины халууны Гүргүм-7	0.83 (++)	0.55 (++)	0.33 (+)	Уушгины халууныг арилгана.
4	Элэгний халууны Гүргүм-7	0.49 (+)	0.81 (++)	0.18 (+)	Элэгний халууныг арилгана.
5	Дэлүүнийхалууны Гүргүм-7	0.75 (++)	0.48 (+)	0.30 (+)	Дэлүүний халууныг арилгана.
6	Бөөрний халууны Гүргүм-7	0.23 (+)	0.55 (++)	0.21 (+)	Бөөрний халууныг арилгана.
7	Ходоодны халууны Гүргүм-7	0.12 (+)	1.1 (+++)	0.13 (+)	Ходоодны халууныг арилгана.
8	Савны халууны Гүргүм- 7	0.35 (+)	0.70 (++)	0.26 (+)	Савны халууныг арилгана.
9	Судлын халууны Гүргүм-7	0.35 (+)	0.68 (++)	(-)	Судлын халууныг арилгана.
10	Ясны халууны Гүргүм- 7	0.36 (+)	0.75 (++)	(-)	Ясны халууныг арилгана.
11	Хий халууны Гүргүм-7	1.2 (+++)	0.73 (++)	0.09 (+)	Хий халууныг арилгана.
12	Шарын халууны Гүргүм-7	0.35 (+)	1.21 (+++)	(-)	Шарын халууныг арилгана.
13	Бадган халууны Гүргүм- 7	0.60 (++)	0.71 (++)	0.32 (+)	Бадгана халууныг арилгана.
14	Цусны халууны Гүргүм- 7	0.35 (+)	1.05 (+++)	(-)	Цусны халууныг арилгана.
15	Хижгийн халууны Гүргүм-7	0.52 (++)	0.66 (++)	(-)	Хижгийн халууныг арилгана.

Тайлбар: Жишиг итгэлцүүр ЖИ (+++)<1.0; (++)=0.51-0.83; (+)=0.09-0.50; (-)= 0

Бүлэглэн шаталж найруулсан аргаас өвчнийг язгуурын ба орны үүднээс ялгасан ангилал хоорондын нарийн шүтэлцээг харж болно. Тухайлбал, бүлэглэн шаталж найруулсан дэдлэгч Гүргүм-7 (Зандан-8, Габүр-9 мөн адил)-ийн 14 найрлагыг (нийт 44) авч үзвэл (хүснэгт 2) тэдгээр нь өөр хоорондоо илүү нягт харилцан хамааралтай хий шар бадган түүнчлэн 5 цул, 6 сав эрхтэн зэрэг дэд тогтолцоонуудын дотоод дахь хөдлөнгөтэнцвэрт харьцаа хамаарлын өөрчлөлт явц (өвчин эмгэгийн), үе шатыг (бага, дунд, их халуун г.м) хадгалсан байна.

Хэлцэмж

Бүлэглэн шаталж найруулсан олон найрлагатай эмийн жор найрлага нь: 1) өвчний орон, язгуурыг, 2) өвчний явц, үе шатыг, 3) эд эрхтэн хоорондын харьцаа хамаарлыг харгалзсан байна. Сурвалж бичигт бүлэглэн шаталсан эмийн найрлагыг голлогч, жолоодлого гэх мэтээр тэмдэглэж байдаг. Дармаамаарамба Лувсанчойрог (XVIII зуун) “Бэрх оньсны очир зангилааг тайлагч” номынхоо талх эмийн аймгийн хэсэгт

“...Түшмэл мэт Гүргүм-7-гийн найрлага. Үүн дор адгийн халууныг арилгах Гүргүмийн найрлага, дунд зэргийн халууныг арилгах Занданы найрлага, маш халууныг арилгах габүрийн найрлага хэмээх гурав буй. ... Түшмэл мэт Гүргүм-7-ийн найрлагын зүйл 14 байхаас орны халууныг арилгах долоон найрлага нь гүргүм, жуган, гиван гол болох бөгөөд солигдох үгүй юм” гээд тэр гурвын дээр өөр зүйлийн дөрөв, дөрвөн эмт бодисыг (хүснэгт-2) нэмж зүрх, уушиг, элэг, дэлүү, бөөр, ходоод гэдэс, олгой савны халууныг арилгамай гэж бичсэн байна. Цааш нь “Язгуурын халууныг арилгах нь болвоос ... дээрхий гурван голлогчийн дээр мөн долоон янзын дөрөв дөрвөн өөр зүйл эмт бодисыг нэмж судас, яс, хий халуун, бадган халуун, цусны халуун, хижгийн халууныг тус тус арилгана” гэснээс үзэхэд орон ба язгуурын үүднээс ялгасан халуун өвчнийг эмчлэхээр заасан байна.

Мөн энэ номын өвсөн эмийн аймгийн хэсэгт эмийн жолоодлогын талаар: “... Зөөлнийг эрэх дор: найрлагын үүднээс зөөлнийг эрэх, жолоодлогын үүднээс зөөлнийг эрэх арга нь эмийн язгуур зохилдсон олон зүйлийг тааруулж өгөхийг хэлнэ. Жолоодлогоор аль зохистой жолоодлогын эм лугаа шүтүүлэхийг хэлмөй” гэснээс үзвэл өвчний явц, орон, язгуурыг харгалзан жолоодлогын нэмэлтийг зохицуулан эм найруулахыг чухалчилсан байна. Уламжлалт анагаах ухааны бүлэглэн шаталж эм найруулах аргыг задлан шинжилсэн дүнгээс үзвэл Системийн Уламжлалт анагаах ухаан, системийн уламжлалт эм судлалын шинэ хандлагыг нарийвчлан судалж шинжлэх явдал онол практикын ихээхэн ач холбогдолтой, ирээдүйтэй болох нь харагдаж байна.

Дүгнэлт:

1. Бүлэглэн шаталж олон найрлагтай эм найруулах арга нь зөвхөн Уламжлалт анагаах ухаанд өргөн хэрэглэж ирсэн өвөрмөц онцлогтой байна. Эм найруулах арга хэлбэрийн хувьд босоо, хөндлөн, салаа, холимог гэж ялгаж болно.
2. Бүлэглэн шаталж найруулсан эмийн жор найрлага нь өвчний явц үе шат, эд эрхтэн тогтолцооны бүтэц, бүтэцбэрийн хоорондын харьцаа хамаарлын тэнцвэрт байдал, түүний алдагдал мөн өвчний ангилалтай холбоотой байна.
3. Уламжлалт анагаах ухаан нь системийн шинж чанарыг хадгалах бөгөөд системийн Уламжлалт анагаах ухаан, Системийн Уламжлалт эмийн эмчилгээ, эм судлал хэмээн нэрлэж болохуйц онол, арга зүйн шинэ хандлагыг агуулсан байна.

Abstract**Systematic medicine and composition of traditional drugs**

Amarzaya.D¹, Dagvatseren.B², Chimedragchaa.Ch², Purevjav.L¹, Tsend-Ayush.D³

¹ Central Clinic of Traditional Medicine, ITMTM

² Institute of Traditional Medicine and Technology of Mongolia

³ Institute of Mongolian Medicine, MNUMS

Background

Module-hierarchical method of medicine preparation has been used widely in traditional medicine for the preparation of multi-compound medicine preparation.

Aim of study

This article aim to analyze traditional method of module-hierarchical of medicine preparation in prospect of theory and methodology of system as well as to determine its form and nature.

Materials and methods

Relevant sections of the book “Four principals of medicine” was used as a material in the research. Research was done by using reference index calculation method (Dagvatseren.B, 1996) that affects humors of the medicine (wind, bile, phlegm). Identification of diseases and the relationship between medicines was analyzed in accordance with the systematic general theory and methodology (Urmantsev.Yu.A., 1988).

Results

There are 8 groups of medicines in the powder and herbal medicines group of “Four principals of medicine” that were prepared by module-hierarchic: 1) Dignitary Gurgum-7, 2) Basic component Gabur, 3) Anar-Basic component, 4) Anar-4 basic component, 5) Dali-Basic component, 6) Compound of Garanz-6, 7) Herbal medicine which expel fever with a guide, 8) Herbal medicines which eliminate cold. Total of 124 recipes and compounds are included. .

Medicines prepared by module-hierarch are divided into: 1. Vertical 2. Horizontal 3. Beveled or branched 4. Mixed type by its form of method. When calculating the reference index of affecting the mistakes of medicine of 124 medicines and compositions, reference index of 119 medicines are in accordance with their using instructions. But reference index of 5 recipes that were prepared by leading and single taste exceeded the limit of 0:1.

Conclusions

Recipes and composition of medicines prepared by module-hierarchic depends on relationship between organs and system, its crisis (loss), disease progress and classification.

It will keep the systematic characteristics of traditional medicine and contains new independent theoretical and methodological approach that can be named as systematic traditional medicine, treatment and research of systematic traditional medicine.

Key words: Systematic medicine, basic substances, disease location and classification, methods of compounding medicines made by module-hierarchic

Уламжлалт “жонлон-5” тангийн фармакологийн судалгааны зарим үр дүн

П.Даваадулам¹, Б.Ууганбаяр², С.Олдох¹, Г.Мөнхзул²
¹АШУУИС, АУС, УАУИ, ²УАУТХ

Судалгааны ажлын үндэслэл

2012 оны байдлаар Монгол улсад үе мөчний өвчин 10000 хүн ам тутамд 82.26 байгаа нийт халдварт бус өвчнүүдийн 7-рт жагсаж байна.1

Статистик судалгаанаас үзэхэд 2009 онд УАШУТҮКК Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн 71% нь бодисын солилцооны эмгэгтэйн дээр 43% нь холбогч нэхдэс, үе мөчний эмгэгтэй, үүний 31.7% нь хэрх төст үетэс эмгэгээр, 68.3 % нь олон үетэс, 30 орчим хувь нь захын мэдрэлийн гаралтай өвдөлттэй ирч хэвтэн эмчлүүлсэн байна.

Тиймээс бид дээрх судалгааны үр дүнд тулгуурлан уламжлалт анагаах ухаанд хуучирсан халуун, халуун шар усны өвчин, хямарсан халуун, хэрх, тулай өвчин болон өвдөлт намдаах зорилгоор хэрэглэж ирсэн Жонлон-5 танг судлахаар сонгон авсан бөгөөд уг жор нь Ар үр (*Terminalia chebula*. Retz), Бар үр (*Terminalia bellerica*), Жүр үр (*Gardenia jasminoides*), Лидэр (*Sophora alopecuroides*), Сормууст дэгд (*Gentiana barbata*) гэсэн 5 хөл эмээс бүрддэг.2-5

Судалгааны ажлын зорилго:

Туршилтын амьтанд үүсгэсэн үений үрэвслийн эмгэг загварт уламжлалт “Жонлон-5” тангийн үзүүлэх нөлөөг судлах

Судалгааны ажлын материал, арга зүй

УАУТХ-ийн Эмийн үйлдвэрт үйлдвэрлэгдсэн Жонлон-5 танг туршилт, судалгаанд ашигласан бөгөөд туршилт судалгааг Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний төвд түшиглэн явуулсан.

Тангийн хурц хорон чанарыг 18-22 грамм жинтэй лабораторийн цагаан хулганад OECD-ийн удирдамж 420-ийг мөрдлөг болгон бэлдмэлийн тунг 2000 мг/кг хүртэл амаар өгч туршсан. Өвдөлт намдаах нөлөөг 20±2 грамм жинтэй эр, эм тэнцүү тооны 50 хулгана авч хяналтын болон харьцуулах, Жонлон-5 тангийн 50мг/кг, 100 мг/кг, 200 мг/кг гэсэн 5 бүлэгт хуваана. Хяналтын бүлэгт нэрмэл ус өгч, 2 дахь бүлэгт Индометацин 10 мг/кг, 3-5 дахь бүлэгт Жонлон-5 жорыг 50-200 мг/кг тунгаар өдөр бүр тогтсон нэг цагт нэг удаа амаар өгнө. Жорыг 4 өдөр өгч, хамгийн сүүлийн өдөр эм өгснөөс 1 цагийн дараа 0.6%-н цууны хүчлийн уусмалыг лабораторийн хулганы хэвлийн хөндийд 10 мл/кг тунгаар тарьж, тарьсан хугацаанаас 20 минутын туршид илэрч буй өвдөлтийн хариу урвал, мушгирч эвхрэх хөдөлгөөнийг тоолно.(Ghogh, 2008)

Туршилтын амьтанд үүсгэсэн үений үрэвслийн эмгэг загварт тангийн нөлөөг судлахдаа 180-200 грамм жинтэй 40 толгой Вистар үүлдрийн харх авч эрүүл (1-р бүлэг), хяналт (2-р бүлэг), харьцуулах (3-р бүлэг), Жонлон-5 (4-р бүлэг) жорын гэсэн 4 бүлэгт хуваасан. Үрэвсэл үүсгэхээс нэг цагийн өмнө эрүүл болон хяналтын бүлгийн амьтдад

нэрмэл ус, харьцуулах буюу 3-р бүлэгт Индометацин 10 мг/кг, 4-р бүлэгт Жонлон-5 жорыг 100 мг/кг тунгаар тус тус амаар өгсөн.

Сарвууны үрэвслийг үүсгэхдээ 0.9% натри хлоридын уусмалаар 1% каррагений уусмал бэлтгэж 0.1 мл-ийг туршилтын амьтны баруун сарвуунд тарина. Ингээд туршилтын 0, 30, 60, 120, 240 дахь минуутуудад үений үрэвслийн хэмжээг плетисмометрээр хэмжинэ. (Winter, Risley)⁴ цагийн дараа туршилтын амьтадыг егүүтгэж цусны ийлдэст МДА болон TNF- α , IL-1 β зэрэг цитокинүүдийг тодорхойлсон.

Судалгааны ажлын үр дүнг биостатистикийн үндсэн аргуудаар арифметик дундаж (M), стандарт хазайлт (δ), стандарт алдаа (m), итгэмжлэх хязгаар (CI-95%) болон дундаж тооны үнэн магадлалыг Стьюдентийн t шалгуураар шалган, боловсруулалтыг SPSS 20.0 программ ашиглан хийнэ.

Судалгааны ажлын үр дүн

Уламжлалт Жонлон-5 тангийн хурц хорон чанарын судалгааны үр дүн

Жонлон-5 тангийн хурц хорон чанарын судалгааг OECD-ийн удирдамж 420-ийн дагуу лабораторийн 5 цагаан хулганад эмийг 50 мг/кг, 200 мг/кг, 500 мг/кг, 1000 мг/кг, 2000 мг/кг тунгуудаар 1-р шатны тэмтрүүл туршилтыг явуулсан бөгөөд туршилтын амьтдад үхэх болон хордлогын ямар нэг шинж тэмдэг илрээгүй. Арьсанд улайх, тууралт өгөх, загатнах зэрэг харшлын ямар нэг хариу урвал илрээгүй, хөдөлгөөн болон хоол тэжээлийн дуршил, амьсгалын хэмнэл, дууг мэдрэх байдал зэрэг үнэлгээнүүд хэвийн байсан тул бид хурц хорон чанар тогтоох үндсэн туршилтыг 25 толгой лабораторийн цагаан хулганад эмийн тунг 2000 мг/кг хүртэл туршилт явуулсан. Туршилтын үр дүнгээс үзэхэд туршилтын амьтдад үхэх болон хордлогын ямар нэг шинж тэмдэг илрээгүй. Үүнээс үзэхэд уламжлалт Жонлон-5 тан нь хор багатай буюу GHS-ийн 5-р зэрэглэлд хамаарч байна.

Тиймээс бид эмчилгээний идэвхит тунг тооцохдоо хор багатай эмийн хүнд хэрэглэх дундаж тун болон Жонлон-5 тангийн олон янзын тунгуудаас эмчилгээний үйлдэл үзүүлж буй дундаж тунг 100-200 мг/кг байхаар сонгон авсан.

Жонлон-5 тангийн өвдөлт намдаах нөлөөг судалсан үр дүн

Туршилтын амьтны хэвлийн хөндийд цууны хүчлийг тарьсанаар уг хүчтэй цочруулын нөлөөгөөр үрэвсэл үүсч тэр хэсгийн захын мэдрэлийн ширхэгүүд цочирч өвдөлт үүсдэг байна. Уг өвдөлтийн эсрэг туршилтын амьтан мушгирч эвхрэх хөдөлгөөнөөр хариу үйлдэл үзүүлдэг.

Бид дээрх аргаар үүсгэсэн өвдөлтийн эмгэг загварын үед Жонлон-5 тангийн нөлөөг судлахдаа 2 ялгаатай тун дээр өвдөлтийн хариу урвал эхлэх хугацаа, нийт мушгирч эвхрэх хөдөлгөөний тоогоор үнэлсэн. Харьцуулах бүлэгт үрэвслийн шалтгаант өвдөлтийн үед хэрэглэгддэг Индометацин 10 мг/кг тунгаар өгч туршсан.

Туршилтын амьтны хэвлийн хөндийд цууны хүчлээр өдөөсөн

өвдөлтийн эмгэг загварт Жонлон-5 тангийн үзүүлэх нөлөө

Хүснэгт 1.

Бүлэг	№	Эмийнтун (мг/кг)	Өвдөлтийн хариу урвал эхлэх хугацаа (мин)	Өвдөлтийн хариу урвалынтоо (20 мин)
Хяналт	10	-	7.1	31.6
Индометацин	10	10	17.7	9.8
Жонлон-5	10	100	11.2	24.3
Жонлон-5	10	200	12.5	25.1

Хүснэгтээс харахад туршилтын бүлгүүд болох индометацин, Жонлон-5 тангийн 100 мг/кг болон 200 мг/кг тунгаар хэрэглэсэн бүлгийн амьтадын өвдөлтийн хариу урвал эхлэх хугацаа нь хяналтын бүлэгтэй харьцуулахад уртассан байна. Харин өвдөлтийн хариу урвалын тоо буурсан байгаа болох нь харагдаж байна. ($p < 0.01$)

Харин уламжлалт Жонлон-5 тан нь лабораторийн цагаан хулгана дээр цууны хүчлээр үүсгэсэн өвдөлтийн эмгэг загварын үеийн өвдөлтийн хариу урвал эхлэх хугацааг 1,6- 1,8 дахин уртасгаж, өвдөлтийн хариу урвалын тоог 20,6%-23,1%-иар бууруулж байна.

Каррагенаар өдөөсөн сарвууны хурц үрэвслийн үед Жонлон-5 тангийн нөлөөг судалсан үр дүн

Каррагеныг туршилтын амьтанд сарвуунд тарихад хэсэг газрын хурц үрэвсэл үүсдэг бөгөөд энэ үед экссудаци давамгайлсан явагддаг. Үрэвслийн медиаторуудын үйлчлэлээр венийн цус дүүрэлт болж венийн судасны хананд үзүүлэх гидростатик даралт нэмэгдэн судас өргөсч нэвчимтгий чанар ихэссэний үр дүнд цусны шингэн хэсэг болох сийвэн нь гадагш шүүрэн гарна. Түүнчлэн үрэвслийн голомтод гиперонки, гиперосми болсноор цусны шингэн хэсэг нь онкос, осмос даралт багатай цусны сийвэнгээс үрэвслийн голомт руу шилжин хуримтлагдаж цусны дүрст элементүүд ялангуяа лейкоцитүүд судаснаас гадагшлан экссудат үүснэ.

Хүснэгт 2.

Каррагенинаар өдөөсөн сарвууны хурц үрэвслийн үеийн
хавангийн хэмжээнд Жонлон-5 тангийн үзүүлэх нөлөө

Бүлэг	Эмийн тун (мг/кг)	Хавангийн хэмжээ (мл)				
		0 минут	30 минут	60 минут	120 минут	240 минут
Эрүүл	-			0.55±0.04		
Хяналт	-	0.53±0.03	0.82±0.02	0.96±0.04	1.09±0.09	1.44±0.07
Индометацин	10	0.53±0.04	0.63±0.03	0.65±0.05	0.67±0.05	0.70±0.06
Жонлон-5	100	0.54±0.01	0.77±0.05	0.79±0.07	0.81±0.02	0.99±0.04

Хүснэгтээс харахад каррагенин тарьсан хяналтын бүлгийн амьтадын сарвуунд үүссэн хавангийн хэмжээг эрүүл бүлэгийн үзүүлэлттэй харьцуулахад туршилтын 30 дахь минут (0.82)-нд 1,5 дахин, 60 дахь минут (0.96)-нд 1,8 дахин, 120 дахь минут (1.09)-нд 2 дахин, 240 дэх минут (1.44)-нд 2.6 дахин нэмэгдсэн байна. Эндээс харахад туршилтын амьтадын сарвууны үнд каррагенин тарихад экссудаци давамгайлсан үрэвсэл явагддаг болох нь харагдаж байна.

Харин уламжлалт Жонлон-5 тан нь туршилтын бүх хугацаанд хяналтын бүлэгтэй харьцуулахад статистикийн үнэн магадлалтайгаар туршилтын амьтны сарвуунд үүсгэсэн хаванг бууруулах нөлөөтэй байна. Тухайлбал туршилтын 30 дахь минутанд 6,1%-иар, 60 дахь минутанд 17,7%-иар, 120 дахь минутанд 25,7%-иар, 240 дэх минутанд 31,3%-иар тус тус сарвуунд үүссэн хавангийн хэмжээ бага байна. ($p < 0.05$) Мөн харьцуулах бүлэгт хэрэглэсэн Индометацин эм нь сарвууны хавангийн хэмжээг хяналтын бүлэгтэй харьцуулахад туршилтын 30 дахь минутанд 23,2%-иар, 60 дахь минутанд 32,3%-иар, 120 дахь минутанд 38,5%-иар, 240 дэх минутанд 51,4%-иар тус тус бага байна.

Туршилтын амьтанд каррагенинаар үүсгэсэн сарвууны үрэвслийн үед бие махбодын өөхний хэт исэлдэлтийн процесс-антиоксидант (ӨХИП-АО) тогтолцооны тэнцвэр алдагдан Малондиальдегид, Диений коньюгат, Диений кетон зэрэг өөхний хэт исэлдэлтийн бүтээгдэхүүнүүд үрэвслийн голомт болон цусны сийвэнд ихэсдэгийг судлаачид тогтоосон байдаг. (Б.С.Утешеев, Ф.Я.Байурин. 1998) Тиймээс бид уг эмгэг загварын үеийн цусны сийвэнд агуулагдах Малондиальдегидын хэмжээнд Жонлон-5 тангийн үзүүлэх нөлөөг судласан.

Туршилтын амьтанд үүсгэсэн сарвууны хурц үрэвслийн үеийн цусны сийвэнд агуулагдах малондиальдегидын хэмжээнд Жонлон-5 тангийн үзүүлэх нөлөөг судласан дүн

Хүснэгт 1.
M±SEM

Бүлэг	Тун (мг/кг)	Малондиальдегид (nmoli/ml)
Хяналт	-	0.79±0.03
(0.9% NaCl)	10	0.52±0.04
Индометацин	100	0.66±0.05

Хүснэгтээс харахад уламжлалт Жонлон-5 тан (0.66±0.05) өгсөн бүлгийн амьтадын ийлдэст агуулагдах МДА-ийн хэмжээг хяналтын бүлэг (0.79±0.03)-тэй харьцуулахад 16.5%-иар бага байна. Харин харьцуулах бүлэгт хэрэглэсэн Индометацин эмийн бүлгийн амьтадын цусны сийвэнд агуулагдах МДА-ийн хэмжээ нь хяналтын бүлэгтэй харьцуулахад 34,2%-иар бага байна.

Бид мөн TNF- α , IL-1 β зэрэг үрэвслийн цитокинүүдийг тодорхойлж тэдгээр Жонлон-5 тангийн үзүүлэх нөлөөг харьцуулан судласан. Судлаачид төрөл бүрийн шалтгаанаар үүссэн үрэвслийн үед идэвхижсэн макрофаг, лимфоцитүүдээс цитокинүүд ялгарч үрэвслийн үйл явцад оролцдог болохыг судлан тогтоосон байдаг.

Туршилтын амьтанд үүсгэсэн сарвууны хурц үрэвслийн үеийн цитокины хөдлөл зүйд
Жонлон-5 тангийн үзүүлэх нөлөө

Хүснэгт 2.

Бүлэг	Тун (мг/кг)	TNF- α (pg/ml)	IL-1 β (pg/ml)
(мг/кг)	-	198.3 \pm 10.2	29.8 \pm 1.23
Эрүүл	-	387.2 \pm 27.1	95.1 \pm 5.47
Хяналт (0.9% NaCl)	10	276.9 \pm 10.5	56.2 \pm 3.54
	100	306.7 \pm 30.7	55.4 \pm 3.13

Хүснэгтээс харахад хяналтын бүлгийн амьтадын цусны сийвэндэх TNF- α -ийн хэмжээ нь эрүүл бүлэгтэй харьцуулахад 1,95 дахин, IL-1 β -ийн хэмжээ нь 3,2 дахин их байгаа нь харагдаж байна. Хурц үрэвслийн үед хүн болон амьтны цусны сийвэнд үрэвслийн явцыг идэвхижүүлдэг TNF- α , IL-1 β , IL-6 зэрэг цитокинүүд нэмэгдэж, харин үрэвслийн эсрэг нөлөөтэй цитокин (IL-10)-үүд буурдаг нь судалгаагаар тогтоогдсон байдаг.

Химийн хорууд, бактерийн эндотоксин, дархан бүрдэл болон физикийн хүчин зүйлүүдийн нөлөөгөөр үүсдэг полипептидүүдийн нэг болох хавдар үхжилийн хүчин зүйл- α (TNF- α)-ийн хэмжээг тодорхойлсон.

Харин уламжлалт Жонлон-5 тан өгсөн бүлгийн амьтадын цусны сийвэнд агуулагдах TNF- α -ийн хэмжээг каррагенин тариад эм өгөөгүй хяналтын бүлэгтэй харьцуулахад 20,8%-иар бага байна. Харин харьцуулах бүлэгт хэрэглэсэн Индометацин эмийн бүлгийг хяналтын бүлэгтэй харьцуулахад TNF- α -ийн хэмжээ 28,5%-иар бага байна. Мөн Жонлон-5 хэрэглэсэн бүлгийн амьтадын TNF- α -ийн хэмжээг Индометацин эмийн бүлэгтэй харьцуулахад 9,7%-иор их байна

Мөн уламжлалт Жонлон-5 тан болон харьцуулах бүлэгт хэрэглэсэн Индометацин эм хэрэглэсэн бүлгийн амьтадын цусан дахь IL-1 β -ийн хэмжээг хяналтын бүлэгтэй харьцуулахад аль аль нь 1,7 дахин бага байна.

Дээрх судалгааны үр дүнгээс харахад Жонлон-5 тан нь туршилтын амьтанд үүсгэсэн сарвууны хурц үрэвслийн үед түүнийг идэвхижүүлдэг цитокинүүд болох TNF- α , IL-1 β зэргийг бууруулах замаар үрэвслийн үйл явцыг дарангуйлдаг байж болохоор байна.

Хэлцэмж:

Сүүлийн үеийн судалгаанаас харахад Францад хүн амын 73%, Германд 70%, Англид 43%, АНУ-д 42% нь ургамлын гаралтай уламжлалт эм хэрэглэж байна. Дэлхийн олонхи улс оронд байгалийн гаралтай хор гаж нөлөө багатай эмийн бэлдмэлүүдэд ихээхэн ач холбогдол өгч үүнийг Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас сайшаан дэмжсэн бодлого явуулж байгаа билээ.6

Манай улс нь Уламжлалт анагаах ухааны талаар төрөөс баримтлах бодлоготой цөөхөн орны нэг бөгөөд дээрхи дэлхий нийтийн баримталж буй бодлогуудтай холбоотой дорвитой ажлуудыг хийж эхлээд байна.

Манай судлаачид уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэж ирсэн эмийн түүхий эдүүдийг харьцангуй сайн судлаж байгаа боловч нийлмэл найрлагатай жоруудыг харьцангуй цөөн судалсан байгаа юм. Тиймээс судлаач бид практикт хамгийн өргөн хэрэглэгддэг жоруудаасаа эхлэн тэдгээрийн шинжлэх ухааны үндэслэлүүдийг судлан тайлбарлах нь зайлшгүй тулгамдсан асуудлуудын нэг юм.

Жонлон-5 танг уламжлалт анагаах ухаанд хуучирсан халуун, халуун шар усны өвчин, хямарсан халуун, хэрх, тулай өвчин болон өвдөлт намдаах зорилгоор хэрэглэж ирсэн бөгөөд одоогийн уламжлалт анагаах ухааны эмнэлгийн практикт хамгийн өргөн хэрэглэгддэг жоруудын нэг боловч түүний найрлага, үйлдэл үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр судлаж тогтоосон ажил байхгүй байгаа юм.

Бид Жонлон-5 жорын үений үрэвслийн эсрэг нөлөөг судлахын тулд туршилтын амьтны сарвуунд каррагенин тарих замаар үүсгэн судалсан.

Каррагенаар туршилтын амьтны сарвуунд үүсгэсэн хурц үрэвслийн үед альтераци болон эксудаци давамгайлан явагддаг байна.

A. L. Wills(1969), B. Bhukya, R. N. R. Anreddy, C. M. William, K. M. Gottumukkala (2009), P. M. Brooks, R. O. Day(1991) зэрэг олон судлаачид туршилтын амьтны сарвуунд карраген тарьхад гистамин, простагландин, брадикинин зэрэг үрэвслийн медиаторуудын нөлөөгөөр сарвуунд хаван үүсдэгийг тогтоосон байдаг.7-8

Гистамин нь үрэвсэл болон харшлын эмгэгүүдийн үед хамгийн эрт ялгарч хүчтэй үйлчлэл үзүүлдэг гол медиатор юм. Тэрээр үрэвслийн голомтод эхний 60 минутанд үйлчлэл үзүүлээд гистаминаза ферментийн нөлөөгөөр идэвхигүй болдог. Серотонин альфа нь тромбоцитын мөхлөгт агуулагддаг бөгөөд идэвхижсэн шигүү мөхлөгт эсээс ялгарах тромбоцит идэвхижүүлэгч хүчин зүйл, судасны ханын ил гарсан коллаген, АДФ, тромбин, адреналин, дархан бүрдэл зэргийн үйлчлэлээр ялгардаг.

Кальцийн ион, тромбин, коллаген, АДФ, адреналин зэрэг өдөөгчдийн үйлчлэлээр эсийн мембраны фосфолипаза А2 идэвхижин эсийн мембраны фосфолипидийг задлан арахидоны хүчил үүсэх бөгөөд энэ нь циклооксигеназа болон липоксигеназын үйлчлэлээр задарна. Ингэж задрахдаа тогтворгүй хэлбэрийн простогландинууд үүсч цаашид тогтвортой PgE2, PgD2 хэд хэдэн төрөл хэлбэрүүдэд шилждэг. Эдгээр

простогландинууд нь судас нарийсгах ТхА2, тромбоцитын агрегаци, адгезийг саатуулах, судас өргөсгөх простациклин, судас өргөсгөн нэвчимтгий чанарыг ихэсгэн хавагнуулах, өвтгөх, загатнуулах нөлөө үзүүлдэг байна.

Энэ үйл явц нь үрэвслийн цусны эргэлт, судасны өөрчлөлттэй холбоотой бөгөөд цууны хүчлийн шууд үйлчлэлээр рефлексийн замаар артериолууд түр агшина. Энэ агшилт нь тогтворгүй бөгөөд ихэвчлэн 3-5 секунд үргэлжилдэг. Үүний дараа үрэвслийн голомтод их хэмжээгээр үүссэн идэвхит медиаторуудын үйлчлэлээр артериолын булчингийн тонус суларч урсан ирэх цусны хэмжээ ихэсч урсгал нь түргэсэх ба нөөц капиллярууд үйл ажиллагаанд орж эдийн бодисын солилцоо сайжран дулаан үүсэлт нэмэгдэнэ. Энэ бүхний дүнд артериол, капилляр дахь гидростатик даралт ихэссэнээр цусны уураг багатай хэсэг судаснаас гардаг.

Үрэвслийн медиаторуудын үйлчлэл болон артерийн цус дүүрэлтийн үр дүнд венийн судас өргөсч урсгал нь удаашран нэвчимтгий чанар ихсэн цусны шингэн хэсэг болон дүрст элементүүд судаснаас гарч үрэвслийн голомтод хуримтлагдана. Энэ үйл явцыг экссудаци гэдэг.

Каррагенаар сарвуунд хурц үрэвсэл үүсгэхэд эхний 0-2 цагт гистамин, серотонин, брадикинин зэрэг үрэвслийн медиаторууд их хэмжээгээр ялгардаг бол 3 цагаас хойш простогландинийн ялгаралт ихэсдэг (Spector and Willoughb, 1963, Ueno et al. 2000)⁹ бөгөөд энэ үед сарвууны хаван хамгийн их хэмжээндээ хүрдэгийг тогтоосон байдаг (Kirkova et al. 1992).¹⁰

Судлаач Nantelet al (1999) каррагенаар сарвуунд хурц үрэвсэл үүсгэхэд гол нөлөө үзүүлдэг простогландинийн үүсэх механизмыг тайлбарласан бөгөөд энэ нь COX-2 ферменттэй шууд холбоотой болохыг тогтоосон байна.¹¹

Бид туршилтын амьтны сарвуунд карраген тарьж хурц үрэвслийн эмгэг загвар үүсгэсэн бөгөөд хяналтын бүлгийн амьтадын сарвуунд үүссэн хавангийн хэмжээг эрүүл бүлэг (0.55 ± 0.04)-ийн үзүүлэлттэй харьцуулахад туршилтын 30 дахь минут (0.82 ± 0.02)-нд 1.5 дахин, 60 дахь минут (0.96 ± 0.04)-нд 1.8 дахин, 120 дахь минут (1.09 ± 0.09)-нд 2 дахин, 240 дэх минут (1.44 ± 0.07)-нд 2.6 дахин тус тус нэмэгдсэн байна.

Судлаачдын үзсэнээр туршилтын амьтны сарвуунд карраген тарихад чөлөөт радикалууд их хэмжээгээр үүсдэг бөгөөд хаван үүсэх механизмыг уг чөлөөт радикалуудтай холбон тайлбарласан байдаг. Эдгээр чөлөөт радикалууд нь NF-κB-д нөлөөлж улмаар азотын исэл (S. Cuzzocrea, B. Zingarelli, 1996)¹², циклооксигеназа-2 (K. Subbaramaiah, A. J. Dannenberg, 2003)¹³, TNF-α (B. Saad, B. S. Abouatta, W. Basha et al., 2006)¹⁴, IL-1β (J. Dawson, A. D. Sedgwick, 1991)¹⁵ зэрэг үрэвслийн явцыг дэмжих нөлөөтэй цитокинүүдийн ялгаралтыг нэмэгдүүлдэг бол нөгөө талаас дээр үүссэн чөлөөт радикалууд нь эсийн мембраны фосфолипидыг задалснаар МДА (H.Y. Chang, M.J. Sheu, C.H. Yang et al, 2011)¹⁶ үүсгэдэг байна. Мөн нейтрофил эс үрэвслийн голомтод

ихэссэнээр тэр хэсэгт хүчилтөрөгчийн хангамж муудаж азотын исэл үүсэх явцыг түргэсгэдэг байна.

Дээрх судлаачдын үр дүнгээс харахад хаван нь азотын исэл, циклооксигеназа-2, TNF- α , IL-1 β зэрэг цитокинүүд, МДА зэрэг олон хүчин зүйлүүдийн нөлөөгөөр үүсдэг байна.17,18

Бид Жонлон-5 жорын ӨХИП-АО тогтолцоонд хэрхэн нөлөөлөхийг судалж үзсэн. Судалгааны үр дүнд Жонлон-5 жор нь МДА-ийн хэмжээг хяналтын бүлэг (0.79 \pm 0.03)-тэй харьцуулахад 16.5 хувиар бага байгаа нь тогтоогдсон.

Бид каррагенаар өдөөсөн хурц үрэвслийн үед үрэвслийн явцыг идэвхижүүлдэг цитокинүүд болох макрофаг эсээс ялгардаг TNF- α , IL-1 β зэргийг тодорхойлсон.

Жонлон-5 жор нь хяналтын бүлэгтэй харьцуулахад TNF- α нь 1.95 дахин, IL-1 β нь 3.2 дахин тус тус бага байсан.($p < 0.05$)

Судлаач Baggiolini et al.,(1994), Ribeiro et al., (2000) нарын стеройдын бус эмүүд нь үрэвслийн үйл явцыг идэвхижүүлэгч цитокинүүд болох TNF- α , IL-1 β зэргийг бууруулдаг болохыг тогтоосон үр дүнтэй бидний судалгааны үр дүн тохирч байна.19,20

Судлаач Prakash Chandra Gupta (2012) Ар үр нь иммунмодулятор нөлөөтэй болохыг тогтоосон байна. Ихэнх судлаачид Ар үрийн үрэвслийн эсрэг нөлөөг түүний гол үйлчлэгч бодис болох полифенолт нэгдэл (Галлийн хүчил), тритерпиноидуудтай нь холбон тайлбарласан байдаг. Тритерпиноидууд нь дан ганц үрэвслээс гадна өвдөлт намдаах, иммунмодулятор, бактерийн эсрэг зэрэг олон нөлөө үзүүлдэг байна.

Ringbom et al., (1998)²¹, Kim et al.,(2001)²² зэрэг судлаачид тритерпиноидууд нь циклооксигеназа-2 ферментийн идэвхийг саатуулах замаар простагландин-2-ийн ялгаралтыг саатуулдаг болохыг тогтоосон байдаг бол судлаач Geetha and Varalakshmi (1998)²³ нар уг үйлдэл нь стеройдын бус үйлдэлтэй үрэвслийн эсрэг нөлөөт эмүүдтэй төстэй байдгийг судлан тогтоосон байна.²⁴

Дүгнэлт

Каррагенаар өдөөсөн сарвууны хурц үрэвслийн үед Жонлон-5 жор нь түүнээс урьдчилан сэргийлэх, эмчлэх нөлөө үзүүлж байна.

Ном зүй

1. Эрүүл мэндийн үзүүлэлт 2012. Улаанбаатар хот: “Мөнхийн үсэг групп” ХХК; 2009 он.
2. Анагаах ухааны дөрвөн үндэс. 1990 он, Улаанбаатар, х.381-383
3. Олдох С, Цэрэнцоо Б, Батхуяг П. Монгол эмийн судлал. 2009 он, Улаанбаатар хот, х. 141, 303
4. Сээсрэгдорж С, Чимэдрагчаа Ч, Хишигжаргал С, Цэрэндагва Д., Чулуунчимэг Б. Монголын уламжлалт анагаах ухааны өвчнийг анагаах увидас. Улаанбаатар: 2005. х.130-132, 243, 245-248

5. Ц.Амгалан. Жонлон-5 тан эмийн фитохими, стандартын судалгаа. Анагаах ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ хот, 2010 он. Оточ манарамба дээд сургуулийн номын сан.
6. Чулуунцэцэг Д. Дэлхийн эрүүл мэндийн салбарын шинэ зууны сорилт ба азийн боломж. Монголын анагаах ухаан сэтгүүл. Улаанбаатар: 2009. (3)149. х. 20-24.
7. A.L. Wills, “Release of histamin,kinin and prostaglandinsduringcarrageenin induced inflammation of the rats,” inProstaglandins, Peptides and Amins, Academic Press, London, UK, 1969; 31–48,.
8. Bhukya, R. N. R. Anreddy, C. M. William, and K. M.Gottumukkala, “Analgesic and anti-inflammatory activities ofleaf extract of KydiacalycinaRoxb,” Bangladesh Journal ofPharmacology, 2009; 4(2):101–104,
9. Ueno A, Naraba H, Ikeda Y, Ushikubi F, Murata T, Naramiya S, Ohishi S. Intrinsic prostacyclin contributes to exudation induced by bradikinin or carrageenan: a study on the pawedema induced in ip-receptor deficient mice. Life Sci. 2000; 66: 155–160,
10. Kirkova M, Kassabova T. Russanov E. In vivo effects of indomethacin. I. Activity of antioxidant enzymes and lipid peroxidation. Gen Pharmacol 1992; 23: 503–507.
11. Nantel F, Denis D, Gordon R, Northey A, Cirino M, Metters KM, Chan CC. Distribution and regulation of cyclooxygenase-2 in carrageenan induced inflammation. Br J Pharmacol 1999; 128: 853–859.
12. S. Cuzzocrea, B. Zingarelli, G. Calapai, F. Nava, and A. P.Caputi, “Zymosan-activated plasma induces paw oedemabynitric oxide and prostaglandin production,” Life Sciences, 1996; 60(3):215–220.
13. K. Subbaramaiah and A. J. Dannenberg, “Cyclooxygenase 2: amolecular target for cancer prevention and treatment,” Trendsin Pharmacological Sciences. 2003; 24(2):96–102,
14. B. Saad, B. S. Abouatta, W. Basha et al., “Hypericumtriquetrefolium derived factors downregulate the production levels of LPS-induced nitric oxide and tumor necrosis factor- in THP-1 cells,” Evidence-Based Complementary and AlternativeMedicine, 2007; 4:425–430,
15. Dawson J, Sedgwick A. D, Edwards J. C.W, Lees P. A comparative study of the cellular, exudative and histological responses to carrageenan, dextran and zymosan in themouse. International Journal of Tissue Reactions. 1991;13(4):171–185.
16. Chang H.Y, Sheu M.J, Yang C.H. et al., “Analgesic effects and the mechanisms of anti-inflammation of hispolon in mice,” Evidence-Based Complementary and AlternativeMedicine, vol. 2011, Article ID 478246.
17. S. A. Trushin, K. N. Pennington, E. M. Carmona et al., “Proteinkinase C α (PKC α) acts upstream of PKC θ to activate I κ Bkinase and NF- κ B in T lymphocytes,” Molecular and CellularBiology. 2003; 23(19):7068–7081.

18. Kwon H.K, Lee C. G, So J. S. et al., Generation of regulatory dendritic cells and CD4⁺Foxp3⁺ T cells by probiotics administration suppresses immune disorders. Proceedings of the National Academy of Sciences of the United States of America. 2010; 107(5):2159–2164.
19. Baggiolini M, Dewald B, Moser B. Interleukin-8 and related chemotactic cytokines-CXC and CC chemokines. Adv. Immunol. 1994; 55: 97–179.
20. Ribeiro, R.A., Vale, M.L., Thomazzi, S.M., Paschoalato, A.B., Poole, S., Ferreira, S.H., Cunha, F.Q., Involvement of resident macrophages and mast cells in the writhing nociceptive response induced by zymosan and acetic acid in mice. Eur. J. Pharmacol. 2000; 387:111–118
21. Ringbom T, L Segura, Y Noreen, P Perera, L Bohlin. Ursolic acid from *Plantago major*, a selective inhibitor of cyclooxygenase-2 catalyzed prostaglandin biosynthesis. J Nat Prod 1998; 61: 1212-1215.

Abstract

Some results of pharmacological research of traditional Drug Jonlon-5

P. Davaadulam¹, B. Uuganbayar², S. Oldokh¹, G. Munkhzul²

¹Mongolian National University of Medical Science, Medical School - Institute of Traditional Medicine

²Institute of traditional medicine and technology

Traditional drug Jonlon-5 have been widely used in the clinical practice for recent years in traditional medicine.

The study was conducted on the experimental animal wistar rats by the carrageenan induced mice paw edema (Winter et al. 1962, Vogel, 2002) methods. We performed chemical and pharmacological investigation was based and implemented scientific research laboratory of Institute of Traditional Medicine and Technology.

The Jonlon-5 significantly ($P < 0.05$) inhibited carrageenan induced rat paw edema as compared to control group. TNF- α secretion was magnified by carrageenan injection (387.2 pg/ml). TNF- α secretion was reduced, comparable to carrageenan group, as a response to extract administration. Administration of Jonlon-5 significantly reduced inflammatory mediator secretion TNF- α by 20.8%, IL-1 β – 41.7%, to be close to inhibition level of Indo-methacin administration.

Jonlon-5 significantly decreased ($P < 0.05$) of serum malondialdehyde (MDA) 16.5% in animal model.

Key words: Traditional drug Jonlon-5, arthritis, carrageenan

**Антацид кальци-6 биологийн идэвхит бэлдмэлийн
ходоод улаан хоолойн сөөргөөнд үзүүлэх үр дүнг багажийн шинжилгээгээр
тогтоосон нь**

Алимаа У¹, Баярхүү.Ц², Оюунцэцэг Х⁴, Баярмаа.Н⁵, Сээсрэгдорж.С⁶
¹АШУУИС УАУИ, ¹АШУУИС АУС, ²АШУУИС Их сургуулийн нэгдсэн эмнэлэг
alimaa.emch@yahoo.com

Товч утга

Антацид кальци-6 бэлдмэлийг ходоод улаан хоолойн сөөргөөд (ХУХСӨ) хэрхэн нөлөөлж байгааг багажын шинжилгээгээр тогтоох зорилгоор судалгааг явууллаа. Судалгааг санамсаргүй хяналтат туршилт судалгааны аргаар хийв. Судалгаа 2 шаттай явагдлаа. Судалгааны 1-р шатанд оролцогсод Антацид кальци-6 биологийн идэвхит бэлдмэл уулган ходоодны хүчил тодорхойлох рН мониторинг шинжилгээгээр хүчиллэгийг 24 цагийн турш хянасан. Улаан хоолойн сөөргөөнд нөлөөлөх байдлыг эмчилгээний өмнө болон дараах үзүүлэлтийн дунджаар хамааралт бүлгийн t тестээр үнэлсэн. Улаан хоолойн сөөргөөнд нөлөөлөх байдлыг DeMeester-ийн шалгуур үзүүлэлтүүд, Г.А. Агафанова, А.П. Холопов нарын шалгуураар, хүчил саармагжуулах хугацааг ходоодны хүчил эргэн хэвийн байдал орох хугацаагаар тогтоов. Үр дүн нь бэлдмэл статистик үнэн магадтайгаар ($p < 0,001$) улаан хоолойг шүлтжүүлж байгааг илтгэж байна. Судалгааны 2-р шат: Оролцогсод GerdQ асуумж судалгаа, ходоод улаан хоолойн уян дурангийн шинжилгээ хийсний дараа Антацид кальци-6 биологийн идэвхит бэлдмэлийг 21 хоног уулган /өдөрт нэг удаа өглөө 10 цагт, 1,5гр тунгаар/ үр дүнг тооцсон. Эмчилгээний үр дүнг GerdQ асуумж судалгаагаар тооцоход 72,1% буюу статистик үнэн магадтайгаар уг бэлдмэл нь ходоод улаан хоолойн сөөргөөг бууруулж байв. Уян дурангийн шинжилгээгээр улаан хоолойн салст бүрхэвчийн өөрчлөлтүүд 86,11%(31), ходоодны үрэвслийн идэвхжил 72,22%(26)-д багассан байв. Иймээс бид Антацид кальци-6 бэлдмэл нь ходоодны хүчил саармагжуулах үйлдэлтэй бөгөөд ходоод улаан хоолойн сөөргөө, ходоодны архаг үрэвсэлд хэрэглэхэд тохиромжтой гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

Түлхүүр үг: Сөөргөө, Антацид кальци-6, рН метр, уян дуран, GerdQ

Удиртгал

Монгол улсын насанд хүрсэн хүн амын дунд ХУХСӨ 28,9%-д нь илэрсэн байна.[1] ХУХСӨ нь дангаар хоол боловсруулах эрхтэний архаг өвчний 1,5% -г эзлэхийн зэрэгцээ хоол боловсруулах эрхтэний эмгэгтэй хавсарч тохиолдох нь элбэг.[2] Монгол улсын эрүүл мэндийн судалгааны ажлын тэргүүлэх чиглэлд Уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай эвцэлдүүлэн нэгдсэн онол бий болгох талаар тусгасан байдаг.[3] Дээрх чиглэлийг үндэслэн эх бичиг сурвалж судлалын харьцуулах

аргыг хэрэглэн жишихэд уламжлалт анагаах ухааны хийгээр сарнисан шарын өвчин нь орчин үеийн анагаах ухааны ходоод улаан хоолойн сөөргөө өвчинтэй дүйлгэж үзэх боломжтой байлаа. Энэ өвчинд жоншоор гол болгосон эмүүдийг өргөнөөр хэрэглэдэг байжээ. Эдгээрт үндэслэн шимжүүлж номхотгосон жоншинд суурилсан Антацид кальци-6 биологийн идэвхит бэлдмэл гарган авсан болно.[4,5] Иймээс бид Антацид кальци-6 биологийн идэвхит бэлдмэлийг ХУХСӨ-д хэрхэн нөлөөлж байгааг орчин үеийн анагаах ухааны эмнэлзүйн, багажын шинжилгээгээр тогтоож түүнийг цаашид шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хэрэглэх боломжийг судлахаар болсон.

Зорилго

Антацид кальци-6 бэлдмэлийн ходоод улаан хоолойн сөөргөөнд үзүүлэх нөлөөллийн эмнэлзүйн судалгааг явуулж үр дүнг тогтоох

Судалгааны материал, арга зүй

Судалгааг ХУХСӨ шинж тэмдгүүд илэрсэн судалгаанд хамрагдах шалгуурын дагуу сонгогдсон өвчтнүүдээс таниулах хуудсаар зөвшөөрөл авч, 46 хүнийг хамруулав. Судалгаа 2 шаттай явагдлаа.

Судалгааны 1-р шат: Оролцогсод ходоодны хүчил тодорхойлох рН мониторинг аппаратаар шинжилгээг хийв. Шинжилгээг үнэлэхдээ өлөн үеийн улаан хоолой ходоодны орчинг тодорхойлсны дараагаар биологийн идэвхит бэлдмэлээ 1,5 граммыг 100,0 усанд найруулан өгөөд эм уусны дараах улаан хоолой, ходоодны хүчиллэгийн байдлыг 24 цагийн турш хянасан. Улаан хоолойн сөөргөөнд нөлөөлөх байдлыг DeMeester-ийн шалгуур үзүүлэлтүүд, Г.А. Агафанова, А.П. Холопов нарын шалгуураар тогтоов. Хүчил саармагжуулах хугацааг ходоодны хүчил эргэн хэвийн байдал орох хугацаагаар тогтоов. Судалгааны 2-р шат: Оролцогсод GerdQ асуумж судалгаа, ходоод улаан хоолойн уян дурангийн шинжилгээ хийсний дараа Антацид кальци-6 бэлдмэлийг 21 хоног уулган /өдөрт нэг удаа өглөө 10 цагт, 1,5гр тунгаар /, үр дүнг тооцсон. GerdQ асуумжийг баллын оноогоор, дурангийн шинжилгээнд илрэх улаан хоолойн үрэвслийг Los Angeles-ийн ангилалаар, ходоодны үрэвслийг Сиднейн системийн (1996) аргачлалыг баримтлан үнэлсэн. Судалгааны үр дүнг SPSS 17 программаар статистик ач холбогдлыг үнэлсэн.


Үр дүн

Судалгааны 1-р шат: Судалгаанд өөрийн хүсэлтээр 9 хүн хамрагдсан. 24 цагийн ходоод улаан хоолойн рН метрийн шинжилгээгээр Антацид кальци-6 бэлдмэлийн улаан хоолойн орчин, сөөргөөнд нөлөөлөх байдлыг судлахад бэлдмэл уухаас өмнө улаан хоолойн дундаж рН $5,75 \pm 0,14$ байснаа уусны дараа $9,7 \pm 0,02$ болсон ба хоногийн дундаж хэмжээ $7,8 \pm 0,09$ байв. Энэ нь уг бэлдмэл статистик үнэн магадтайгаар ($p < 0,01$) улаан хоолойг шүлтжүүлсэн байгааг илтгэж байна. Мөн DeMeester-ийн шалгуур


үзүүлэлтүүдээс хоногт тохиолдох сөргөөний тоо $24,4 \pm 2,38$, таван минутаас удаан илэрсэн сөргөөний тоо $2,8 \pm 0,5$, DeMeester-ийн индекс $13,52 \pm 0,93$ байгаа нь уг бэлдмэл улаан хоолойн сөргөөг багасгаж байгааг илтгэнэ. Ходоодны хүчил саармагжуулах үйлдлийг Г.А. Агафанова, А.П. Холопов нарын (1984) шалгуур дүгнэлтээр үнэлэхэд бэлдмэл ууснаас хойш нэг цагийн дараа ходоодны $pH=4,6 \pm 1,5$ болж хүчил саармагжуулах үйлдэл хангалттай болох нь нотлогдлоо. Уг бэлдмэлийн хүчил саармагжуулан барих дундаж хугацаа нь $19,3 \pm 0,9$ цаг байна.

Судалгааны 2-р шат: Судалгаанд 36 хүн хамрагдав.

Сөргөөт үрэвслийн идвэхжил /n=36/




**Эмчилгээний үр дүн
Эмнэлзүйн шинж /n=46/**




Дээрх хүмүүст эмчилгээ эхэлснээс хойш эмнэлзүйн үндсэн шинжүүд буюу цээж хорсолт, ам гашуу оргих нь $4,7 \pm 0,8$ өдрийн дараагаас багасаж байсан бөгөөд 21 хоногийн эмчилгээний дараа цөсний сөргөө урсгалын хам шинжүүд 70,2%, ходоодны шүүрэл ихдэлтийн хам шинжүүд 67,6%, өвдөлтийн хам шинжүүд 64,7%-иар тус тус багассан. GerdQ асуумж судалгаагаар тооцоход эмчилгээний үр дүн 72,1% буюу статистик үнэн магадтайгаар нотлогдов.

**Эмчилгээний үр дүн
GerdQ асуумж судалгаа /n=46/**



**Эмчилгээний үр дүн
Дурангийн шинжилгээ/n=36/**



Дурангийн шинжилгээний үр дүнг 21 хоногийн эмчилгээний дараа харьцуулан дүгнэхэд улаан хоолойн салст бүрхэвчийн өөрчлөлтүүд 86,11%(31), ходоодны үрэвслийн идвэхжил 72,22%(26)-д багассан байв.

Хэлцэмж:

Ходоодны хүчил хамааралт эмгэгийн үед эмийн нөлөөгөөр ходоодны хөндийн рН түвшин 4,0 ээс дээш болохыг эмийн хүчил бууруулж буй хамгийн тохиромжтой үр дүн гэж тооцож байна.[6] Антацид кальци-6 биологийн илэвхит бэлдмэлийг ууснаас хойш нэг цагийн дараа ходоодны рН=4,6±1,5 болж хоногийн дундаж рН 3.6±1.2 байгаа нь протоны шахуургыг саатуулагч эм омеразолтой үр дүн ойролцоо байна. Мөн Антацид кальци-6 бэлдмэлийг уухад улаан хоолойн орчин шүлтжин, DeMeester индекс, хоногт эзлэх сөөргөөний тоо багасан, 5 минутаас удаан илрэх сөөргөөний тоо эрүүл хүнийхтэй ойролцоо болсон нь Ц. Сарантуяа (2006) нарын судалгаагаар омепразол эмийг өдөрт 1 удаа өглөө уулган ХУХСӨ-ийг эмчлэх [7] загвар эмчилгээний үр дүнтэй ойролцоо үр дүнтэй байна.

Дүгнэлт:

1. Антацид кальци-6 бэлдмэл нь ходоодны хүчил саармагжуулах үйлдэлтэй бөгөөд өдөрт нэг удаа хэрэглэнэ.
2. Антацид кальци-6 бэлдмэлийг ходоод улаан хоолойн сөөргөө, ходоодны архаг үрэвсэлд хэрэглэхэд тохоромжтой.

Ашигласан хэвлэл:

1. Б.Гантуяа, Н.Баярмаа, бусад. Монгол улсын насанд хүргэгчдийн ходоод улаан хоолойн өвчний тархалтыг судалсан дүн. 2014
2. Гантуяа, Оюунцэцэг Х, Баярмаа Н, Бира ... Ходоод улаан хоолойн сөөргөө өвчнийг илрүүлэх инвазив бус арга, эмнэлзүйн хөтөлбөр, Онош, 2013, (60)2013, N05(060)
3. Монголын эрүүл мэндийн эрдэм шинжилгээний тогтолцооны судалгаа УБ 2006 х20
4. Лувсан. (1989), Монгол эмийн судлал. Үндэстэний хэвлэлийн хороо, х: 172. 173
5. Олдох С, Цэрэнцоо Б, Батхуяг П. Монгол эмийн судлал УБ.2009. х. 128
6. Valentin Becker, Stefan Grotz et al. Positive predictors for gastroesophageal reflux disease and the therapeutic response to proton-pump inhibitors; [World Journal of Gastroenterology : WJG](#)2014 April 14; 20(14): 4017–4024. Published online 2014 April 14.
7. Сарантуяа Ц. Ходоод-улаан хоолойн сөөргөө өвчний үеийн улаан хоолой, ходоодны бүтэц-үйл ажиллагааны онцлог. АУ-ны Докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ: ЭМШУИС; 2006.

Determination of the efficiency of Antacide Calcium 6 biological preparation to gastro-eosophageal reflux disease by radiological study

Alimaa.U¹, Bayarkhuu.Ts², Oyuntsetseg.Kh⁴, Bayarmaa.N⁵, Seesregdorj.S⁶

¹MNUMS School of Medicine Insititue of the traditional Medicine, ¹MNUMS School of Medicine, ²MNUMS University teaching hospital, alimaa.emch@yahoo.com

Abstract

The study's goal was to determine efficiency of the Antacide Calcium-6 to Gastro-eosophageal reflux disease (GERD) by radiological study. The material and methods are experimental study and we collected occasionally participants. The study was 2 stages. In the first stage, participants are given Antacide Calcium-6 p.o, and then monitored gastric acidity by pH monitoring for 24 hours. We evaluated how to effect to reflux condition in before and after treatment by relational groups t score. Also we determinate efficient to GERD by DeMeester score, G.A. Agafanova, A.P.Kholopov scores, time to neutralize gastric acidity by time to gastric acidity return normal. First stages results are this preparation alkalified eosophagus ($p < 0,001$). The second stage: Participants are given Antacide calcium-6 for 21 days p.o (1 times per day, in 10 A.M, 1.5g) after collected GerdQ questions and did gastro-eosophageal flexible endoscopy. Treatments results evaluated by GerdQ and Antacide calcium-6 decreased to gastro-eosophageal reflux by 72.1% ($p < 0,001$). Eosophageal mucous membrande changes were 86.11% ($n=31$), gastric inflammation's activity was decreased 72.22% ($n=26$) by endoscopic examination. In conclusion, Antacid calcium-6 biological preparation has neutralizing actions to gastric acidity. Therefore this preparation is comfortable to treat GERD and chronic gastritis.

Тойн жамбалдоржийн намтрыг хөөж тодруулсан нь

*Д.Алтанчулуу1, Д.Амарсайхан2, Т.Содгэрэл3, С.Сээсрэгдорж1
1АШУҮИС, АУС-ийн Монгол анагаах ухааны институт
2АШУҮИС, Эрдмийн сургалтын алба
3Оточ маарамба дээд сургууль*

Товч хураангуй

Жамбалдоржийн намтар судлалд “Ганц тэнгэр очир тарни Ишидонровдамбийжалсан Цог сайтын өөрийн явдал ёсны тийн номлол энэ насны үзэгдлийн нойроос сэргээгч хүслийн эрдэнэ хэмээх оршвой” бүтээлийг эх үндэс болгож баримтлах нь зүйтэй байна. Үүнийг иш үндэс болгохдоо дараах гаргалгаанд бид үндэслэж байгаа болно. Үүнд:

1. Тус бүтээл нь Жамбалдоржийн намтарыг бүрэн хамруулж чадсан байна.
2. Тус бүтээлийг түүний гарын шавь болох Жамъянпэрэнлэй бичсэн нь хамгийн бодиттой үнэн зөв бичигдсэн байх итгэл үнэмшлийн нотолгоо болж байна

3. Мөн энэ бүтээл гар дамжаагүй эх хувилбараараа олдсон нь алдаа мадаг гарахаас сэргийлж чадсан гэдэгт үндэслэж байгаа болно.

Түлхүүр үг: Оточ, эх сурвалж, түүх, судлал

Удиртгал: Жамбалдоржийн талаар судлаачид багагүй бүтээл бичсэн байдаг. Гэхдээ эдгээр судалгаанууд нь түүний бүтээлүүдтэй холбоотой байгаагийн зэрэгцээ түүний анагаах ухааны чиглэлээр туурвисан “Үзэсгэлэнт нүдэн чимэг” зохиолын талаар ишлэл татсан судалгаанууд цөөнгүй байна. Харин түүний намтар бүтээлтэй холбоотой хийгдсэн өргөн дэлгэр судалгаа ховор байгаа юмаа. Бид Жамбалдоржийн “Үзэсгэлэнт нүдэн чимэг” хэмээх алдартай томоохон бүтээлийн доторх “Модон эмийн аймаг” хэсгийг нэлээд нарийвчлан судлахаар зорилго болгон тавиад байгаа юм. Нэгэнт бид алдарт оточ, найман тойн Жамбалдоржийн анагаах ухааны томоохон бүтээлийг судлах зорилго тавьсан, нөгөө талаар түүний намтар түүхтэй холбоотой судалгаа бага байгаад үндэслэж, Өвөр Монголын их сургуулийн доктор профессор А.Эрдэмбаяр Төвдөд суралцаж байх үедээ Монгол нутгийн гэвш Лувсанданзан багшаас олж авсан, Жамбалдоржийн гарын шавь тойн Жамъянпэрэнлээгийн бичиж үлдээсэн гэж үздэг “Ганц тэнгэр очир тарни Ишидонровдамбийжалсан Цог сайтын өөрийн явдал ёсны тийн номлол, энэ насны үзэгдлийн нойрноос сэргээгч хүслийн эрдэнэ хэмээх оршвой” гэдэг Жамбалдоржийн намтартай холбоотой судрыг профессороос зөвшөөрөл авч судлан тодруулсан болно.

Зорилго:

Жамбалдоржийн намтар түүхийг тодруулан судлах

Зорилт:

1. Жамбалдоржийн бага насны үеийг судлах
2. Жамбалдоржийн сурч боловсорч, өсч хөгжсөн үеийг судлах
3. Жамбалдоржийн ажиллаж амьдарч байсан үеийн түүхийг судлах

Судалгааний хэрэглэгдэхүүн, арга зүй

Судалгааны ажлыг АШУҮИС-ийн АУС-ийн Монгол анагаах ухааны институтийг түшиглэн, судалгаандаа “Ганц тэнгэр очир тарни Ишидонровдамбийжалсан Цог сайтын өөрийн явдал ёсны тийн номлол энэ насны үзэгдлийн нойроос сэргээгч хүслийн эрдэнэ хэмээх оршвой” бүтээлийг эх хэрэглэгдэхүүн болгож, Найман тойн Жамбалдоржийн намтар түүхтэй холбоотой бусад бүтээлүүдтэй харьцуулан, Түүхэн хүн судлалын арга, Түүхэн харьцуулалтын арга, Герменевтик арга зүйг ашиглан гүйцэтгэсэн.

Судалгааны үр дүн:

1. Жамбалдоржийн бага насны үе

Найман тойн Жамбалдорж 18-р зууны усан хулгана жил буюу 1792 онд Өвөрмонголын Найман хошууны 9-р засаг төрийн дархан жүнван, Чингис хааны угсаа болох эцэг Болчог хийгээд эх Балму нарын хоёрдугаар хүү болон заяасан бөгөөд эцэг эх нь түүнд Жамбалдорж хэмээх нэрийг өгчээ. Тэрээр 7 наснаас эхлэн Монгол, Манж, Хятад бичиг тэргүүтнийг сурч улмаар 16 настайдаа Богд их эзэн хааны гончиг болж, морин авд мордож сайтар сайшаагдсан тул их Сайшаал ерөөлт хаанд таалагдаж, тогосын өдөн жинс зүүж, гончиг амбан цолоор шагнагдан дотоод түшмэл болж байжээ. Мөн 19 нас хүрэхэд эцэг эх нь Харчин баруун гарын хошууны 10-р засаг төрийн дүүрэн чин вангийн хэргэмт жүнван манж Базарын охиныг хатан болгон залж хоёр хүүтэй болсон байна. [2] 18-19-р тал.

2. Жамбалдоржийн эрдэм номд шамдсан үе:

Тэрээр 23 насандаа Зитан хамба Түмэд Агвааншаравын өлмийн дэргэд “Бодь мөрийн зэргийн хөтөлбөр”-ийг сонссоноор орчлонгоос уйдах сэтгэл үүссэн боловч эхнэр хүүхдээ орхиж чадаагүй ажээ. Улмаар 25 насандаа гэрээс гарах санаа маш их төрсөн учир бурхан багш Шагжамүнийн зам мөрийг даган эд хөрөнгө, эрх мэдлээ бүгдийг орхиж 1817 онд их хамба Агвааншаравын зааварчлагаар өөрийн янаг нөхөр, садан төрөл бүхнийг орхиж Сичуанаар дамжин Үйзэнд хүрч ирээд Брайвуны алдарт гомон данцанд орж суралцаж эхэлжээ. Улмаар Лхазимба Ишданзангаас Ишдонровдамбийжалсан хэмээх сахилын нэр хайрласан байна. Тэрээр Брайвун, Лхас зэрэг газраар суралцах хугацаандаа 150 гаруй Монгол, Төвөд эрдэмтэн багш нарыг оройн чимэг болгон шүтэж Ганжуур, Данжуур зэрэг 300 гаруй боть зохиолын иш лүнг хүртэж бурхан номын онол ёс зохиол бүтээлд мохошгүйгээр суралцжээ. Жамбалдорж 30-аад насны үедээ Ванчин богд Дамбийнямаас гэлэн сахил авч 33 насандаа нутагтаа буцсан байна. [2] 19-20-р тал.

3. Жамбалдоржийн өгөл насны үе

Жамбалдорж нутагтаа ирээд хэдэн жил болсны дараа Утайн оронд хүрч, Ямандагийн бүтээлийг хийж байхдаа зүүдэндээ Үйзэнд очих тухайгаа мэдсэн гэдэг. Тэндээс Лавран хийгээд Гүмбүм хийдээр дамжин, Үйзэнд хүрээд Төвөдийн олон арван сүм хийдэд хүрч авшиг, жанан, номын хөтөлбөр хүртээж байжээ. Лхас, түүний ойролцоох хийдүүд болон Брайвун хийдэд сууж байхдаа заримдаа нутагтаа буцахыг ихээр хүсэмжилдэг байсан боловч, бурхан номын төлөө зүтгэж хойшлуулсаар байж эрдэм номыг ихээр бясалгаж, олон сайхан гэлээн гэвш нарын ховор нандин эрдэм ном, бясалгалыг сурч эзэмшиж, өөрөө ч бас олон шавь сургаж, сүсэгтэн олонд ном тавьж, өөрийн нэрт багш нар болох Хансүр Агваанлуvsан, Жал хамба, Рагваанжалцан, лхаарамба Содном, тэргүүтэн нараасаа түрүүлэн олон арвин хүмүүст авшиг иш, жанан хөтөлбөр хийгээд хот мандалын зан үйл “эрдэнийн эрхис”-ийг соёрхон номолж нэгэн үзүүрт сэтгэлээр бурхан номыг уламжлан хөгжүүлж байжээ. Жамбалдорж ном номлох болон бурхан номын үйлсээ бадруулсаар туулай жил болох 1855 онд таалал төгсжээ. [2] 20-21-р тал.

Хэлцэмж дүгнэлт:

Бид Жамбалдоржийн намтар бүтээлд “Ганц тэнгэр очир тарни Ишидонровдамбийжалсан Цог сайтын өөрийн явдал ёсны тийн номлол, энэ насны үзэгдлийн нойроос сэргээгч хүслийн эрдэнэ хэмээх оршвой” бүтээлийг эх үндэс болгож баримтлах нь зүйтэй хэмээн үзэж байна. Энэ нь

1. Тус бүтээлд түүний намтар бүтээлийг бүрэн хамруулж чадсан
2. Түүний гарын шавь болох Жамъяанпэрэнлэй бичсэн нь дандаа хамт амьдарч байсан учраас алдаа эндүүрэл гарах магадлал бага
3. Энэ бүтээл гар дамжаагүй эх хувилбараараа олдсон зэрэгт үндэслэж байгаа болно.

Нөгөө талаар өмнөх үеийн зарим судалгаануудад Жамбалдоржийн түүх намтартай холбоотой баримтат эх сурвалж, тэмдэглэлүүд ховор байсантай холбоотой алдаа мадаг цөөнгүй бйгаа талаар профессор А.Эрдэнэбаяр тэмдэглэжээ. Тухайлбал Жамбалдоржийг Падгар хийдэд сууж байсан өөр нэгэн Найман тойнтойд эндүүрэн түүнийг найман хошууны 12-р засаг Сагарын ууган хүү, Бор хошуу сүмийн 4-р дүрийн гэгээн болно гэж үзэж байсан эндүүрэл болно гэж үзсэн байдаг. [2] 13-р тал.

Түүнчлэн Ш.Болд, М.Амбага, Б.Саранцэцэг, Ж.Болорцэцэг нарын “Монгол туургатны анагаах ухааны алдарт эмч, мааранба мэргэдийн намтар бүтээлийн тойм” хэмээх номонд [3] 134-р тал. Жамбалдоржийг мөн Өвөр монголын найман хошууны 12-р үеийн засаг төрийн дархан Чин ван Сагарын гэрт мэндэлжээ. Бор хошуу сумын 4-р дүрийн гэгээн гэсэн болон таалал болсон оныг 1885 он гэж бичсэн нь мөн алдаатай байгаа юм.

Эцэст дүгнэвэл тойн Жамбалдорж нь 1792-1855 оны хооронд амьдарч байсан. Удам угсаа сайтай, 7 наснаасаа эхлээд Монгол, Манж, Хятад хэл сурч, 23 наснаасаа Төвөд хэл, буддын мэдлэг ухааны чиглэлээр суралцаж, улмаар 25 насандаа эд хөрөнгө, эрх

мэдэл хотол төгөлдөр байсан бүхнийг орхиж, 1817 онд Их Хамба Агвааншаравын зааврын дагуу баруун газар Үйзан, Брайван хийд, Лхас зэрэг газраар 150 гаруй Монгол Төвөд мэргэдээс суралцан “Гаанжуур”, “Даанжуур”-г судалж, анагаах ухаан, тарнийн ухааны чиглэлээр 300 гаруй боть зохиолын иш, лүнг хүртэж, бурхан номын онол ёс, зохиол бүтээлд ганц үзүүрт сэтгэлийг барьж суралцан уламжлан хөгжүүлсэн монгол мэргэдийн нэг байжээ хэмээн үзэж байна.

Ашигласан хэвлэл;

[1]. Тойн Жамьяанпэрэнлэй “Ганц тэнгэр очир тарни Ишидонровдамбийжалсан Цог сайтын өөрийн явдал ёсны тийн номлол энэ насны үзэгдлийн нойроос сэргээгч хүслийн эрдэнэ хэмээх оршвой” гэх Найман тойн Жамбалдоржийн хуучин төвөд цаасан дээр бичигдсэн намтар зохиол. Модон барын төвөд судар. Урт нь 53 см, өргөн нь 9 см нийт 25 хуудас 50 нүүртэй. Төмөр хонин жил бичсэн.

[2]. Өвөр монголын их сургуулийн доктор профессор А. Эрдэмбаярын зохиол “Найман тойн Жамбалдоржын намтар” судлалд. Хөх хотын ардын хэвлэлийн хороо. 2009 он. Цаасны хэмжээ 880x1230 1/32. 13,16,18,19,20,21-р тал.

[3]. Болд.Ш, Амбага.М, Саранцэцэг.Б, Болорцэцэг Ж. “Монгол туургатаны анагаах ухааны алдарт эмч,мааранба мэргэдийн намтар бүтээлийн тойм” Өвөр монголын шинжлэх ухааны техникийн мэргэжлийн хэвлэлийн хороо. 2006 он. Цаасны хэмжээ 850x1168 1/32. 134-р тал.

Analysis on Toin Jambaldorj's biography

Altanchuluu.D1, Amarsaikhan.D2, Sodgerel.T3, Seesregdorj.S1
1MNUMS, School of Medicine, Institute of Mongolian Medicine
2MNUMS, Division of Academic Education
3Otoch Manramba Medical Institute

Introduction:

There are dozens of research work about Toin Jambaldorj. But most of them based on his works including fiction of medicine, “Beautiful eyes”. We started detailed research on his work “wooden herb species” of his book “Beautiful eyes”. As we started research on great healer Nayman Toin Jambaldorj's biography and work, we analyzed and made research on his work “Gants tengerc ochir tarny Ishiddonrovdambiijalsan Tsog saityn ouryn yawdal yosny tiin nomlol ene nasny uzegdlyn noir-ous sergeegch khuslyn erdene khemeeh orshiwoy”. This work/fiction was inherited by Tibetan monk Louwsanzandan to professor of Inner Mongolian University Erdembayar during his study in Tibet.

Keywords: Healer, source, historical studies.

**Ерөнхий унтуулгатай эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын үеийн
пнеумоперитонеум ба Трендленбургийн байрлал нь амьсгалын үйл ажиллагаанд
нөлөөлөх нь**

Ц.Уугангэрэл, Н.Баярцогт, С.Дүүрэнбаяр, Б.Сайнзаяа

Мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасаг, Нийслэлийн Өргөө Амаржих Газар

Судалгааны зорилго: Эмэгтэйчүүдийн дурангийн мэс заслын үед хэвлийн хөндийг нүүрсхүчлийн хийгээр (CO_2) хийлж Трендленбургийн байрлалд оруулах шаардлагатай болдог. Пнеумоперитонеум (ПП) болон Трендленбургийн байрлал нь мэдээгүйжүүлгийн үеийн амьсгалын үйл ажиллагаанд өөрчлөлт үүсгэж болох юм. Энэ судалгаа нь ПП болон Трендленбургийн байрлал нь уушгины уян хатан чанар (Cdyn) болон амьсгалын хүрээний даралтанд өөрчлөлт оруулж байгааг батлахыг зорьсон юм.

Арга зүй: Эмэгтэйчүүдийн төлөвлөгөөт дурангийн мэс засалд орох зүрхний болон уушгины эмгэггүй 21 эмэгтэйг сонгож авсан. Унтуулгад тиофентал натрий, фентанил, атракриум, изофлюран хэрэглэсэн. Амьсгалын оргил даралт (PIP), плат даралт (platP), амьсгалын төгсгөл дэхь нүүрсхүчлийн хийн хэмжээ (etCO_2) зэрэг үзүүлэлтүүдийг интубацийн дараа хэвлийн хөндийг хийлэхээс өмнө, хэвлийн хөндийг 15 ммH₂O хүртэл даралтаар хийлсэний дараа, 20°-д Трендленбургийн байрлалд оруулсаны дараах 10, 20, 30 минут, хэвлийн хөндийгөөс хийг гадагшлуулсаны дараа тус тус хэмжиж эдгээр бүлгүүдийг хооронд нь харьцуулсан. Уушигны динамик уян хатан чанарыг тооцоолж гаргасан.

Үр дүн: Хэвлийн хөндийг хийлсэний дараа амьсгалын хүрээний оргил даралт (PIP) 6 см.H₂O, плат даралт (platP) 5 смH₂O, тус тус статистик үнэн магадтай ($P < 0.05$) илэрхий ихэссэн ба харин эсрэгээр уушигны динамик уян хатан чанар нь (Cdyn) 11 ml/cmH₂O – р статистик үнэн магадтай ($P < 0.05$) буурсан байна. Ерөнхийдөө, Трендленбургийн байрлал нь цусны эргэлтийн болон амьсгалын үйл ажиллагаанд онцгой нөлөө үзүүлээгүй байна.

Дүгнэлт: Хэвлийн хөндийг нүүрсхүчлийн хийгээр хийлсний дараа уушгины динамик уян хатан чанар буурч, харин амьсгалын хүрээний даралтууд нэмэгдсэн байна. Трендленбургийн байрлал нь эдгээр үзүүлэлтүүдэд нөлөө үзүүлээгүй байна.

Түлхүүр үгс: Уушигны динамик уян хатан чанар, пнеумоперитонеум, Трендленбургийн байрлал, амьсгалын хүрээний даралт.

Клиник судалгааны ач холбогбол: Мэдээгүйжүүлэгч эмч нар нь дурангийн мэс заслын үеийн хэвлийн хөндийг хийлэх, Трендленбургийн байрлалд оруулах үеийн амьсгалын үйл ажиллагааны өөрчлөлтүүдэд анхааралтай хандах, шаардлагатай үед арга хэмжээ авахад бэлэн байх нөхцөлд дурангийн хагалгааг хийх хэрэгтэй.

**Цэвэршилтийн дараах анхдагч ясны сийрэгжилттэй эмэгтэйчүүдэд
остеокальци-5 бэлдмэлийн үзүүлэх нөлөөгуламжлалт анагаах ухааны биеийн
өвөрчлөлттэй харьцуулан судласан нь**

Д.Бямбадалай¹, М.Мөнхзол², С.Сээсрэгдорж³

¹УАУЭСКТ, ²АШУУИС ЭЗ-БАС, ³АШУУИС-УАИ,

Dalai6698@yahoo.com

Товч утга: Цэвэршилтийн дарааханхдагч ясны сийрэгжилттэй эмэгтэйчүүдэд Остеокальци-5 бэлдмэлийн үзүүлэхнөлөөг тодорхойлон улмаарУАУ-тай холбон үр дүнг тооцох зорилгоор цэвэршилтийн дараах анхдагч ясны сийрэгжилт гэж оношлогдсон 50-65 насны 120 эмэгтэйг санамсаргүй хяналтат эмнэл зүйн туршилт судалгаанд хамруулж биеийн өвөрчлөл тогтоох аргаар хувь хүн бүрийн өвөрчлөлийг тогтоосон. Мөн стандарт бүлэгт(n=60)цитраткальци-Дэмийг, туршилтын бүлэг (n=60)остеокальци-5 бэлдмэлийгуулгаж ясны эрдэсжилтийн нягтшил, яс хугарах эрсдэлээрүр дүнг тооцон уламжлалт анагаах ухааны биеийн өвөрчлөлттэй харьцуулан судалсан.

Үр дүн:Судалгаанд оролцсон остеопороз оношлогдсон эмэгтэйчүүдийн 65,8% нь бадганы өвөрчлөлттэй байсан. Судалгааны бүлгүүдэдэм, бэлдмэлтийг 2 сарын турш уулгасны дараа SOS хэмжээ 3-4%-аар өссөн, яс хугарах эрсдэл 39,6%-аар буурсан үр дүн гарсан.

Дүгнэлт: Уламжлалт анагаах ухаанаах яс сийрэгжих өвчнөөр бадганы өвөрчлөлтэй хүн голчлон өвддөг болох нь харагдсан. Остеокальци-5 бэлдмэл нь цэвэршилтийн дараах ясны сийрэгжилтийн үедясны хатуу эдийн нягтшилыг нэмэгдүүлэх замаар хугарал үүсэх эрсдэлийг бууруулж байгаа нь тогтоогдлоо. Мөн Остеокальци-5 бэлдмэлийн үр дүн нь биеийн өвөрчлөлөөс хамаарахгүй ч ходоодны галын илч сайтай, хөдөлгөөний идэвхитэй хүмүүст илүү харагдаж байсан.

Түлхүүр үг: SOS, жонш, эрсдэл, биеийн өвөрчлөл

Удиртгал:ДЭМБ-ийн мэдээлснээр халдварт бус өвчлөлийн тархалтаараа яс сийрэгжих эмгэг нь зүрх судасны өвчин, хавдар, чихрийн шижингийн дараа 4-р байранд оржээ¹. Ясны сийрэгжилт нь олон төрлийн шалтгаан, хэв шинжээр үүсдэг хэдий ч нийт тохиолдлын 80% нь цэвэршилтийн дараах үеийн эмэгтэйчүүдэд тохиолддог². Дээрх эмгэгийн үед эм бэлдмэлүүд ихэнхдээ нийлэг байдлаар гарган авсан, удаан хугацаагаар хэрэглэхэд гаж нөлөөтэй, өртөг өндөр байдаг тул байгалийн гаралтай хоруу чанар багатай, зөөлөн үйлчилгээтэй,биемахбодид хялбар шингэдэг, элдэв гаж нөлөө бага, өртөг хямд зэрэг давуу талтай бэлдмэлүүдийг зохион бүтээх явдал нь чухал ач холбогдолтойд тооцогдож байна. Д.Цэнджав, С.Сээсрэгдорж нарын судлаачид уламжлалт анагаах ухааны эмийн түүхий эдүүдэд суурилсан Остеокальци-5 найрлагыг

бүтээж ясны сийрэгжилт үүсгэсэн SD үүлдрийн харханд уулгаж үр дүнг тооцоход ясны эдийн задралыг бууруулж яс үүсэлтийг дэмждэг болох нь батлагдсан³ бөгөөд ясны сийрэгжилтийг эмчлэх, урьдчилан сэргийлэх үйлдэлтэй цэвэр байгалийн гаралтайуг бүтээгдэхүүний хүний бие махбодид үзүүлэх үйлдлийг судлах эмнэл зүйн судалгааг хэрэгжүүлэх үндэслэл болсон болно.

Судалгааны зорилго: Цэвэршилтийн дарааханхдагч ясны сийрэгжилттэй эмэгтэйчүүдэд Osteокальци-5 бэлдмэлийн үзүүлэх нөлөөг тодорхойлон улмаар УАУ-тай холбон үр дүнг тооцох

Судалгааны материал, аргазүй: Бид судалгаандаа цэвэршилтийн дараах 50-65 насны остеопороз оношлогдсон эмэгтэйчүүдийн ясны хатуу эдийн нягтралыг тодорхойлон улмаар Osteокальци-5 бэлдмэлийн остеопорозын эсрэг үйлдлийг УАУ-тай холбон үр дүнг тооцох зорилгоор 120 оролцогчийг хамруулсан. Тусгайлан боловсруулсан биеийн өвөрчлөл тогтоох асуумж авч ясны хатуу эдийн нягтыг SOS, Tba Z оноогоор тодорхойлов⁴. Оролцогчдын биеийн өвөрчлөлийг тогтоохдоо биемахбодын төрөлх өвөрмөц чанарыг тодорхойлох шалгуур, аргуудыг ашиглан монгол хүний амьдралын ахуй нөхцөлийн онцлогийг тусгасан бусад судлаачидтай хамт өөрчлөн боловсруулсан Д.Давгацэрэн, Ө.Батчимэг, Г.Наранцэцэг нарын аргыг хэрэглэв⁵. Остеопорозтой оролцогчдыг стандарт эмчилгээний бүлэг n=60 /цитраткальци Д 600 мг-р өдөрт 2 удаа 2 сар/, туршилтын бүлэг n=60 /остеокальцийг 1500 мг-р өдөрт 2 удаа 2 сар/ гэж хуваан судалгааны төгсгөлд ясны эдийн нягтралыг давтан хэмжиж эм бэлдмэлийн үр дүнг харьцуулан дүгнэв.

Үрдүн: Нийт 120 оролцогч хамруулсан ба дундаж нас $56,2 \pm 4,06$ байв. Оролцогчдын 14,3%-д остеопени, 71,4%-д остеопороз илэрсэн бөгөөд онош батлагдсан 50 хүнийг эмнэлзүйн судалгааны 2 дахь шатанд хамруулан судалгааг хэрэгжүүлсэн ба биеийн жингийн индекс нь остеопороз оношлогдсон эмэгтэйчүүдэд $27,4 \pm 5,2$ байсан ба цэвэршилтийн дундаж $47,6 \pm 4,4$ байв.

Хүснэгт-1


Яс сийрэгжилтийн тохиолдлыг Уламжлалт анагаах ухаан талаас биеийн өвөрчлөлтэй холбон судалсан дүн

№	Биеийн өвөрчлөл	Хүний тоо	Хувь
1	Хий дийлэнх	22 оролцогч	18,3%
2	Шар дийлэн	19 оролцогч	15,8%
3	Бадган дийлэнх	79 оролцогч	65,8%

Хүснэгтээс үзэхэд ясны сийрэгжилтээр бадган дийлэнх өвөрчлөл бүхий эмэгтэйчүүд ихэвчлэн өвчилж байгаа нь харагдаж байв.

Цэвэршилтийн дараах анхдагч яс сийрэгжилтэнд Osteокальци-5 бэлдмэлийг 2 сарын турш уулгаж үзэхэд дараах үр дүн гарсан. Нийт 2 шатны судалгаанд оролцогчдод

эхлээд шуу ясны SOS нь $3836 \pm 107,4$ м/с, Т оноо -3.4 ± 0.88 , хугарал үүсэх эрсдэл 31.5 ± 1.7 хувь тодорхойлогдсон. ($p < 0.05$). Шуу ясны SOS нь настай урвуу хамааралтай ($r = -0.346$ $p < 0.01$) ба мөн Т оноо нь настай урвуу хамааралтай ($r = 0.346$ $p < 0.01$) байгаа нь тогтоогдсон. Судалгааны төгсгөлд буюу эм бэлдмэлийг 2 сарын турш уусны дараа давтан шинжилгээ хийхэд Остеокальци-5 бэлдмэлийн бүлэгт SOS нь 3960 ± 152 м/с болж өссөн, Т оноо нь -2.4 ± 0.14 , хугарал үүсэх эрсдэл 19 ± 1.7 болж буурсан бол цитраткальци уусан бүлэгт Т оноо -2.6 ± 0.78 , SOS $3947,4 \pm 201$ м/с, хугарал үүсэх эрсдэл 19.5 ± 0.24 хувь болтол буурсан байв ($p < 0.05$).



Зураг 1. Шуу ясны SOS хэмжээнд Остеокальци-5 бэлдмэлийн үзүүлсэн нөлөө

Мөн судалгааны дараа биеийн өвөрчлөлийг давтан тодорхойлоход өөрчлөлт төдийлөн илрээгүй бөгөөд харин галын илч, хөдөлгөөний идэвхитэй харьцангуй их өөрчлөлт илэрчээ. Өөрөөр хэлбэл эм бэлдмэлийг хэрэглэсний дараа илэрсэн SOS-н эерэг дүн нь биеийн хөдөлгөөний идэвхийн их 46,7%, хөдөлгөөний идэвхи дунд зэрэг 30%, удаан буюу унтамхай 23,3%-д илэрчээ. Харин ходоодны галын илчийн хэмжээг давтан тодорхойлж үзэхэд тогтмол сайн буюу тэгш 50%, тогтмол биш тэгшгүй 30%, удаан өлсдөг муу 20% тохиолдож байсан ба SOS хэмжээ нь галын илч их хүмүүст өсөх хандлагатай байгаа нь тогтоогдлоо ($p < 0.05$).

Хэлцэмж: Дорно дахины анагаах ухааны биологийн исэлдэлт явагдах “Тунгалаг цөв”-ийн ялгаралт, орчин цагийн бодисын солилцооны биохимийн “Анаболизм-Катаболизм” явагдах зүй тогтолтой ижил үйл явц юм. Яс сийрэгжилт үүссэний дараа орчин үеийн шинжлэх ухаанд оношлох олон арга бий болсон ч ясны сийрэгжилтээс урьдчилан сэргийлэх Уламжлалт анагаах ухаанаар өвчлөх магадлалыг тооцоолох нь чухал юм. Ходоодны галын илч буюу хоол боловсруулдаг гол үүрэгтэй ялзлагч бадгана, шингээгч шар, гал тэгшитгэгч хий гурав чухал үүрэгтэй. Ходоодны бадган, хий өвчин, эс шингэсэн хоолыг боловсруулж чадахгүй болох нь даамжраад архагшвал ясны сийрэгжилд хүргэдэг. Хүйтэн чанартай өвчний үед ясны сийрэгжилт үүсэх нь элбэг тул судсыг шинжлэхэд алгуур, дорой, живэнгүй лугшина.

Бидний судалгаанаас харахад бадганы өвөрчлөлттэй эмэгтэйчүүд яс сийрэгжилтээр ихэнхдээ өвчилж байгаа нь харагдсан. Мөн ясны хэмийг барилдуулах, яс бороолуулах чадалтай давсан, хугарсныг залгах, хэмийг тогтоох чадалтай ажигцэрон, илч сэлбэх, идээг шингээх, дурыг нээх, бадган халууныг арилгах мана, арүрийн найрлага бүхий Остеокальци-5 бэлдмэл ходоодны галын илчийг дэмжин нь тунгалаг цөвийн ялгаралтыг сайжруулж байгаа нь тогтоогдсон бөгөөд Д.Цэнджав, С.Сээсрэгдорж нарын судлаачдын ясны сийрэгжилт үүсгэсэн SD үүлдрийн харханд уулгаж тооцсон үр дүн нь бидний судалгаар мөн батлагдсан юм.

Дүгнэлт: Цэвэршилтийн дараах ясны сийрэгжилттэй эмэгтэйчүүдэд Остеокальци-5 бэлдмэлийг 2 сар хэрэглэсний дараа ясны эдийн нягтшил ихсэх ба бадган өвөрчлөлтэй хүмүүст ясны сийрэгжилт тохиолдох хандлагатай бөгөөд галын илч сайтай хүмүүст эмчилгээний үр нөлөө сайн илэрч байгаа нь тогтоогдлоо.

Ном зүй:

1. WHO scientific group on the assessment of osteoporosis at primary health care level, 2004.
2. A.Cranney, L.Waldegger, I.D.Graham, M.Man-Son-Hing, Byszewski, D.S.Ooi et al. Systemic assessment of the quality of osteoporosis guidelines. BMC Musculoskeletal Disorders. 2002; 3:20-30.
3. Д.Цэнджав, Л.Мөнхтулга, С.Сээсрэгдорж. Жоншны бэлдмэлийн ясны сийрэгжилтэнд үзүүлэх үйлдлийг судалсан дүн АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. ЭМШУИС, 2013
4. R.Keith, Mc.Cormick, DC, CCSP Osteoporosis: Integratin Biomarkers and Other Diagnostic Correlates into the Management of Bone Fragility. Alternative Medicine Review. Volume 12, Number 2, 2007
5. С.Өлзийбат, С.Сээсрэгдорж, Г.Сүхбат. Хүний төрөлх өвөрмөц чанарыг харьцуулсан судалгаа АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2011 он

Study of pharmaceutical preparation of osteocalcium-5 for primary osteoprosis after menopause

*D. Byambadalai¹, M. Munkhzol², S. Seesregdorj³,
Dalai6698@yahoo.com*

Abstract: Determining effect of pharmaceutical preparation of Osteocalcium-5 for 50-65years old patients who diagnosed as primary osteoprosis after menopause. All 120 volunteers were divided randomly into control and clinical experiemental group also private specialty test was taken from each group as well.

Control group (n60) had oral medication Citratcalcium D, clinical experiement group had oral Osteocalcium-5. After medication result of mineral density of osteoprosis , fracture risk and result of private specialty were compared.

Result: 65.8% of patients who diagnosed as primary osteoprosis after menopause are concept of Badgan private specialty. After 2 months of oral medication in each group SOS measurement enhanced by 3-4%, fracture risk decreased by 39.6%.

Conclution: In Traditional medical, concept of Badgan private specialty more tendency for osteoprosis. Osteocalcium-5 improves osteon of compact bone patiets with osteoprosis after menopause and decreased risk of fracture. Also result of pharmaceutical preparation of Osteocalcium -5 does not depend on private specialty but patients who are active lifestyle and stomach fire is proper had possitive effect.

Key words: SOS, Osteoprosis, spar, risk, private specialty

Хүний биеийн мөчдөд байрлах бэрх оньсны талаар сурвалж болон тайлбар зохиолуудын харьцуулсан судалгаа

Д. Дашизвэг¹, О.Одмаа², С. Сээсрэгдорж.³

¹АШУУИС, АУС-ийн УАУИ-ын магистрант, ²ХӨСҮТ ³АШУУИС, АУС, УАУИ
dasha_d46@yahoo.com, 99290610

Товч утга:

Зорилго: Хүний биеийн мөчдөд байрших бэрх оньсны бэлчрийн нэршил, байршлийг сурвалж болон тайлбар зохиолуудад харьцуулан судлах

Арга, аргачлал: Эх бичиг, сурвалж бичиг судлалын арга, задлан шинжлэн нэгтгэн дүгнэх арга, магадлан жагсаах аргуудаар хийж гүйцэтгэв.

Үр дүн: Махны оньс 18, өөхний оньс 6, ясны оньс 6, шөрмөсний оньс 10, судасны оньс 72, нийт 112 гэж “Алтан хадмал”, “Дөрвөн рашаан”, “Ар үрийн прэнва” зохиолуудад бичсэн боловч нэг бүрчлэн тэмдэглэж нэршил, байрлалыг тогтооход булчин/мах/-гийн оньс 22, булчирхай/өөх/-н оньс 8, судасны оньс 60, ясны оньс 26, бүлх шөрмөсний оньс 10 байна. Мөн судасны бэрх оньсыг 60 гэж бичсэн боловч “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Бэрх оньсны очир зангилааг тайлагч” зохиолуудад 58 байсан ба Ишбалжирын зохиолд 62 байлаа. “Алтан хадмал”-д бэрх оньсны нэршлийг илүүтэй гаргаж өгсөн бол “Ар үрийн прэнва” зохиолд зөвхөн тоогоор тэмдэглэсэн байна. Түүнчлэн зарим бэрх оньсны байрлал төдийлөн оновчтой бичигдээгүй бөгөөд нэршил, бичиглэлийн зөрүү их байлаа.

Дүгнэлт: Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгож авсан сурвалж тайлбар зохиолуудад бэрх оньсны тоо, нэршил, байрлалын нилээд ялгаа зөрүү байгаа тул бүх зохиолуудыг хамарсан нэгдсэн нэг ойлголттой болох нь зүйтэй байна.

Түлхүүр үгс: эх сурвалж, оньс, тоо, нэршил, байрлал

Удиртгал: Уламжлалт анагаах ухаанд “бэрх оньс” хэмээх биеийн бүтэц зүйн чухал асуудлын талаар “Бэрх оньсны бэлчрийг мэдэхгүй, бэлчрийн бэрхшээх ёс мэдэхгүй гарын авлага зохисгүйгээс болж махны бэрх оньсыг гэмтээвэл боом шиг хавдах, ясны оньс гэмтвэл их өвдөх, бүлх шөрмөсний оньс гэмтвэл тахир доголлон болох, судас өөх цул савны оньс гэмтвэл амь насыг хөнөөх ч явдал байдаг юм” хэмээсэн байдаг.[1-5] Үүний талаар хийгдсэн судалгаа, ном зохиол ховор байгаа бөгөөд нэгдсэн нэг ойлголт мэдлэг байхгүй байна. Бид судалгаандаа хүний биеийн мөчдийн хэсгийн бэрх оньснуудыг сонгон авч харьцуулж судлах нь зөөлөн, ширүүн засал мөчдөд их хийгддэг тул онол, практикийн ач холбогдол ихтэй гэж үзэж судалгааны үндэслэл болгож авлаа.

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй: “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”-ийн хорин тавдугаар бөлгийг эх хэрэглэгдэхүүн болгож, Дарма маарамба Лувсанчойраг “Алтан хадмал”, “Бэрх оньсны очир зангилааг тайлагч” хатгах заслын бөлөг, Ишбалжир “Дөрвөн рашаан” заслын бэлчрүүд ба оньсон газруудыг таних тухай зэрэг тайлбар

зохиолуудтай харьцуулан эх бичиг, сурвалж судлалын арга, задлан шинжлэн нэгтгэн дүгнэх арга, магадлан жагсаах аргуудаар хийж гүйцэтгэв. [6-9]

Үр дүн: Махны оньс 18, өөхний оньс 6, ясны оньс 6, шөрмөсний оньс 10, судасны оньс 72, нийт 112 гэж “Алтан хадмал”, “Дөрвөн рашаан”, “Ар үрийн прэнва” зохиолуудад бичсэн боловч нэг бүрчлэн тэмдэглэж нэршил, байрлалыг тогтооход булчин/мах/-гийн оньс 22, булчирхай/өөх/-н оньс 8, судасны оньс 60, ясны оньс 26, бүлх шөрмөсний оньс 10 байна. Мөн судасны бэрх оньсыг 60 гэж бичсэн боловч “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Бэрх оньсны очир зангилааг тайлагч” зохиолуудад 58 байсан ба Ишбалжирын зохиолд 62 байлаа. Дарма маарамба Лувсанчойрагийн “Алтан хадмал”-д нэршил байршлыг илүүтэй авч үзсэн бол Лүнриг Дандарын “Ар үрийн прэнва” зохиолд зөвхөн тоогоор бичиж тэмдэглэсэн байна. (Хүснэгт 1)

Бэрх оньсны тооны зөрүүтэй байдал

Хүснэгт 1

	Анагаах ухааны дөрвөн үндэс	Алтан хадмал	Бэрх оньсны очир зангилааг тайлагч	Дөрвөн рашаан	Ар үрийн прэнва
махны оньс	22	18/16/	22	18/22/	18
өөхний оньс	8	6/8/	8	6/8/	6
судсын оньс	60/58/	72	60/58/	72/62/	72
ясны оньс	26	6	26	6	6
б.шөрмөсний оньс	10	10	10	10	10
нийт	126/124/	112	126/124/	112/108/	112

Махны бэрх оньс нь “Анагаах ухааны дөрвөн үндэс”, “Бэрх оньсны очир зангилааг тайлагч” зохиолуудад 22 гэж бичигдсэн бөгөөд “Алтан хадмал”, “Дөрвөн рашаан” зохиолуудад 18, “Дөрвөн рашаан” зохиолд 22 бичигдсэн байна. Үүнээс “Алтан хадмал”-д чичрэх махны оньс 2, хонины сүүл гэх оньс 2, булчингийн голын оньс 2 нийт 6 махны оньсыг бичилгүй 16-н оньсыг тэмдэглэжээ. Өөхний оньс бүх зохиолуудад тооны хувьд ижил, нэршилийн хувьд ялгаатай байлаа. Ясны оньсыг “Алтан хадмал”, “Бэрх оньсны очир зангилааг тайлагч”-д 6 гэж бичсэн байна. Гэвч бусад зохиолуудтай адил 26 байлаа. Бүлх шөрмөсний оньс бүх зохиолуудад тоо, нэршил, байрлал ялгаагүй, судасны бэрх оньс нэршил, тооны ялгаа ихтэй байна. “Алтан хадмал” зохиолд нийт 72 судсыг бүрэн бичсэн бөгөөд 12 судас бусад зохиолоос илүү бичсэн байна. Бүнза, ганза, рүгго, лониндомза, чинтирийдомза, лочиндомза, ёвгон 12 судас нь байршил тодорхой бус байна. (Хүснэгт 2)

Судасны бэрх оньсны харьцуулсан үр дүн

Хүснэгт 2

Анагаах ухааны дөрвөн үндэс	Алтан хадмал	Бэрх оньсны очир зангилааг тайлагч	Дөрвөн рашаан
Хий гүйх цагаан судас			
1.зажидын оньс 2	чүза 2	цүрза 2	зажидаас салсан усан судас 2
2.раднаагийн оньс 2	радна 2	радна 2	радна 2
3.тахимын судсын 2	жидвү 2	жидбү 2	жидбү 2
4.нугасны судасны 2	жүнза 2	жүнза 2	жүнза оньс 2
5.хөлийн эрхийн үсний судсын оньс 2	бирго 2	жүза, баргу 2	бриагу оньс 2
Цусны судас			
1.онбо судлын оньс 2	-	онбу 2	онбу оньс 2
2.судасны оньс 2	гава 2	күгба 2	гүа судсын оньс 2
3.дүнбүд судсын 2	дүнбүд 2	дүнбүд 2	дүнбүд судсын оньс 2
Шарын халууныг төрүүлэх оньс			
1.сэржигуа судасны оньс 2	далны бариулын үеийн завсарт гава 2	сэржигуа 2	сэржгауа оньс 2
2.жариг оньс 2	жарэн 2	жарван 2	хизэжэриг оньс 2
Цус алдаж, үл тогтох тул цус алдах оньс			
1.тохойн дотор судасны оньс 2	нодга 2	нодга 2	нодга 2
2.тохойн гадар судасны оньс 2	рүтүн 2	рүтүн 2	рүтүн 2
3.хөлийн их судасны оньс 2	зачэн 2	забузи 2	зэпүжэ 2 нь жишүг 2
4.шилбэний булчингийн үзүүр 2	мадсүм гэдэг жиншүг 2	элгэн судас мадсүм 2	лонза 2
Бадгана хүйтнийг үүсгэх оньс			
1.хар хуягийн оньс 2	нагү 2	нагү 2	нагү 2
2.ясанд шигдсэн 2	рүйшэн 2	рүйшэн 2	рүйшэн 2
3.хөл эргүүлэх 2	гандэг 2	гандэг 2	гандэг 2
4.дэлүүний хар судасны оньс 2	занаг 2	дэлүүний хар судас 2	занаг 2
Хий цус 2 нийлэн лугших зүрхний судас			
1.тавхайн дүгриг	тилпорог 2	шагар 2	тилпорог
2.хар судасны оньс 2	гүлзанагбо 2	гүлзанагбо 2	гүлзанагбо
3.төмөр буурцаг 2	жагжисаранма 2	жагжисаранма 2	жагжисаранма
4.сэржэгадүг судасны2	гадүн 2	сэржэгадүг 2	сэржэгадүг
-	гавзанагбо 2	гавзанагбо 2	гавзанагбо
5.зүрхний судас улаан нүдний оньс 2	мигмар 2	зүрхний судас мигмар 2	нинзэмигмар
6.түргэн судасны оньс 2	ниюуруа 2	зүрхний судал ниюуруа 2	ниюуруа
7.хөдлөх судасны 2	гүлза 2	гүлза 2	гүлза
8.эмчийн үзэх судасны оньс 2	даза 2	-	шинжих судас даза
		парза 2	парза

9.амь насны 2	лаза 2	лаза 2	лаза
10.зүрхний өнцгийн 2	асо 2	асулига 2	асулига
11.зүрхний судас хөлс цугларах оньс 2	үлдү 2	зүрхэн судал үлдү 2	нинзэ-үлдү 2

Хэлцэмж: Эртний Сушрута Самхати (Shusruta samhita) сударт бэрх оньсны нийт хэмжээг 107 гэж бичсэн байдаг. Үүнд махны оньс 10, ясны оньс 8, судасны оньс 37, цул савын оньс 13 байна. Энэхүү зохиолын дараагаар “АУДҮ” түүний тайлбар зохиолууд бичигдсэн нь бэрх оньс нийт 302 бөгөөд махны оньс 45, өөхний оньс 8, ясны оньс 32, шөрмөсний оньс 14, цул савын оньс 13, судасны оньс 190 болж хөгжижээ. Үүнээс дөрвөн мөчинд 112 байдаг. Мөн маш бэрх 96, дунд бэрх 49, адаг бэрх 157 байдаг. Хэрвээ ханаж болох 77 судсыг хасвал бэрх оньс нийт 232 байж болох юм. Бэрх оньс гэдэг бол хамгийн наад захдаа дарахад өвддөг. Эсвэл гэмтэж шархадвал хүнийг удаан зовоодог орон буюу цэг мөн.[10] Бэрх оньсны тухай Өвөр Монголын судлаач Б.Цэцэнт “Бэрх оньс гэдэг бол хатуу, ширүүн засал буюу гэмтлийн явцад өвдөх, хавдах, цус их гарах, минчүүрэх, үхэтхийх мэт шинж илрүүлэх буюу хөдөлгөөн, ажиллагаа нь харшлагдах ба зохих эмчилгээгээр дамжсан ч өвчин нь хүндрэх эсвэл зэмдэгшрэх, цаашилбал амь насыг хөнөөж мэдэх бүтэц, орон, цэгүүдийг заана” хэмээн томъёолсон байна.[10] Толгойд орших мах, яс, судсын бэрх оньсыг тогтоон, махны оньсонд орших булчингууд, ясны оньсонд гавлын заадаснууд, судлын оньсонд орших артери, вен, мэдрэлийн багцуудын анатомын нэршлийг нь тодорхойлсон.[11]

Дүгнэлт: Бэрх оньсны тоо, нэршил, байршлыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай байгаа бөгөөд бэрх оньсыг анатоми, эд эс судлалын арга зүйгээр судалж нотолгоожуулах нь чухал байна.

Ном зүй

1. “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот. 1977.
2. Дарма маарамба Лувсанчойраг. Алтан хадмал. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1988. Хөх хот. х.142-164.
3. Дарма маарамба Лувсанчойраг. Бэрх оньсны очир зангилааг тайлагч. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1998. Хөх хот. х.534-551.
4. Ишбалжир. Дөрвөн рашаан. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1998. х.292-307.
5. Лүнрэгдандар. Арүрийн прэнва. Өвөр монголын ардын хэвлэлийн хороо. 1999. Хөх хот. х. 20-30.
6. Болд.Ш. Монголын уламжлалт анагаах ухааны хөгжлийг эх сурвалжийн судалгаагаар тодруулах нь. АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2005.
7. Ганбаяр.Я. Эмийн дөрвөн үндэсний гарсан ёс зохиолын судалгаа. АУ-ны докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. 2005.

8. Авирмэд.С. Гүн Гомбожавын “Эмийн нэршлийн Төвөд Хятад хэлний хадмал оршвой” зохиолын харьцуулсан судалгаа. АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2014.
9. Далантай.Б. Ишданзанваанжилын Уламжлалт анагаах ухааны чиглэлээр туурвисан “Шүрэнчимэг” зохиолын судалгаа. АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2014.
10. Цэцэнт.Б. Монгол анагаах ухааны бэрх оньсны сурвалж бичгийн судалгаа. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот. 2009.
11. Болортамир. Ж. Толгой хүзүүний бэрх оньсны бүтэц, болон ханах судасны ханын бичил эргэлтийн зарим онцлог. АУ-ны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар. Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль. 2005.
12. ЭМШУИС Докторантур магистрантурын алба “Диссертаци бичих үлгэрчилсэн загвар” УБ. 2014.

Comparison study of between hand and leg of human body critical points in the source and literature

D.Dashzeveg¹, S.Seesregdorj²

¹*Graduate resident of the traditional pathology*

²*MNUMS, School of Medicine, Institute of Traditional Medicine, Department of Clinical Medicine*

Dasha_d46@yahoo.com 99290610

Key words: source, critical point, number, name, location

Purpose: We goaled located in the hand and leg of human body critical points's name and description of source and commentary writers comparative study.

Methods: Our research work is done using different methods across analysis and sum-up, researching method on source material, and making phenomenological lists.

Results: In "Anagaakh ukhaanii durvun undes" source, "Altan khadmal", "Berkh onisnii ochir zangilaag tailagch" and "Durvun rashaan" literature wrote location in the hand and leg critical points number of muscle 18, fat 6, bone 6, tendon 10 and vessel 72 total of 112, but a written note of each name, identify the location of the muscle /meat/ 22's critical points, gland /fat/ 8, bone 26, tendon 10 and vessels 60 total of 138. And vessel critical points was listed as 60, but other literature had 58 and Ishbaljir's literature had 62. "Altan khadmal" literature wrote Tibetans name of critical points, the "Ar uriin preuva" literature recorded only enumerating of the number. In addition, some critical points's position is written in the name and marked differences.

Conclusions: We should all the literature combined with a common understanding because the number, name and location of critical points very difference.

Өвдөгний үений остеоартроз өвчний үед түрэм заслын үзүүлэх нөлөө

Э.Жаргалхүү¹, Д.Баярмаа², С.Сээсрэгдорж³

¹Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн хүрээлэн

²АШУҮИС – АУС – Уламжлалт Анагаах Ухааны Институт

Jagaa_3@yahoo.com

Судалгааны ажлын үндэслэл:

Үе мөчний цагаан шар усны өвчин буюу өвдөгний үений остеоартроз нь монголчуудын дунд цаг уур, орчны нөлөө, хэрэглэж буй хоол хүнс, амьдралын буруу хэвшил зэргээс хамаарч нэлээд элбэг тохиолдож байна. Тухайлбал: УАУТХЭмнэлэгт 2014 онд 3682 өвчтөн хэвтэн эмчлүүлсний 14% нь холбогч эд нэхдэс, үе мөчний эмгэгтэй, үүний 37,7% нь хэрх, хэрх төст үетэс эмгэгээр, 68,3% нь олон үетэс эмгэгтэй ирж хэвтэн эмчлүүлсэн байна. [1]

Монголын ард түмэн амьдралын урт удаан хугацаандаа эмчлэн засах арга ухааныг эзэмшин дадал, туршлагатай болон уламжлагдсаар ардын эмнэлэгийн өвөрмөц өвийг бий болгосон байна. Өвчний урхагийг дотроос нь гадагшлуулах хануур засал, умардын оронд үүссэн хүйтэн өвчнийг анагаадаг төөнө засал, тархины доргилтыг бариа заслаар эмчлэх уламжлалт арга, яс барих, зүйх арга, Лүнрэг Дандарын 5 рашаан, сам соруул гээд бүгд Монголоос гаралтай, Монгол хүний оюун ухаанаар буй болсон эмчлэх урлагийн аргууд юм.[2]

Монголын уламжлалт анагаах ухааны сурвалж бичгүүдэд дурьдсанаар түрэм засал нь бадган хүйтнийг арилгаж, шар ус хатаах үйлдэлтэй нэг зүйлийн гадар засал юм. Түрэм засал нь ханах, төөнөх, жигнэх, дэвтээх, түрхэх зэрэг таван заслын бурууг дарагч заслын дээд юм гэжээ.[3,4,5] Иймээс уламжлалт түрэм заслыг эмнэлзүйн нөхцөлд судлах нь ач холбогдол ихтэй байна.

Зорилго: Өвдөгний үений остеоартроз өвчний үед түрэм засал эмчилгээний үзүүлэх нөлөөг судлах

Зорилт:

1. Түрэм заслын талаар сурвалж болон тайлбар зохиолуудын хүрээнд тодруулах
2. Өвдөгний үений далайцад үзүүлэх нөлөөг судлах
3. Өвдөгний үений остеоартроз өвчний үеийн эмнэлзүйд үзүүлэх нөлөөг судлах

Түлхүүр үг: Түрэм, Өвдөг, Далайц

Судалгааны ажлын материал, арга зүй

2015 оны 07-08 сард УАУТХЭмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн өвдөгний үений контрактур үүссэн, артроз өвчтэй 7 өвчтөний үений далайцыг гониометрээр хэмжиж, эмнэлзүйн зовиурыг Лекений индекс (0-6 балл) - аар үнэллээ. Тусгайлан бэлдсэн мөнгөн зүүг артрозтой өвчтөний өвдөгний үенд 1 удаа хатгаж зүү тус бүрийг 3 ширхэг

уул өвсөн төөнөөр төөнөлөө. Эмчилгээнээс 9 хоногийн дараа үений далайц, эмнэлзүйн зовиурыг харьцуулан үнэллээ.

Статистик боловсруулалт

Судалгааны ажлын үр дүнг SPSS-20, Prism-5 программ дээр, two way RM ANOVA post hoc (Bonferroni) анализ ашиглан үнэллээ. Бүлэг хоорондын ялгаа ($P < 0.05$) байхад үнэн магадлалтай гэж үзэв.

Судалгааны ажлын үр дүн


Түрэм заслын талаар сурвалж болон тайлбар зохиолуудын хүрээнд тодруулсан дүн:

Түрэм засал нь тусгай үйлдсэн хатгуураар хүний биеийн тогтсон бэлчирт хатган сэдэлт өгч өвчнийг эмчлэх нэгэн зүйлийн уламжлалт засал юм. XVIII зууны үеийн Монгол мэргэдийн нэг болох Ишбалжирын “Рашааны ундрал” зохиолд “Түрэм буюу хатгуур заслыг халуун, хүйтэн хоёр зүйл байдаг” тухай тэмдэглэжээ. “Анагаах ухааны дөрвөн үндэс” зохиолд хатгах засал бол таван заслын буруудлыг дарах эрхэм засал мөн гэжээ.[3] “Дөрвөн рашаан” сударт хатгуурын тус эрдэм нь өөр заслаар засаад эдгэрээгүй олонхийг хатгуур заслаар эдгээж болох юм гэсэн байдаг.[4] “Зарлигын эрхэст харанхуйг арилгагч зул” сударт ханах, төөнөх, жигнэх, дэвтээх, түрхэх зэрэг таван заслын чадал, хүчнийх нь бурууг дарагч хатгуур болвоос заслын дээд юм гэж ач холбогдол өгч бичсэн байдаг. [5] Уламжлалт сурвалж болон тайлбар зохиолуудад түрмийн хатгах бэлчир орныг 110 байдаг гэж нарийвчлан заасан.

Өвдөгний үений эмгэгт түрэм заслын үзүүлсэн нөлөө:

Судалгаанд хамрагдсан 7 эмчлүүлэгчийн өвдөгний үений тэнийх хөдөлгөөн (162.8 ± 6.3^0) – ийг эрүүл хүнтэй харьцуулахад 10%, нугалах хөдөлгөөн (77.8 ± 5^0) – ийг мөн харьцуулахад 42,4%-аар тус тус буурсан байна.

Эмчилгээний өмнө өвдөгний үений тэнийх хөдөлгөөн (162.8 ± 6.3^0), нугалах хөдөлгөөн (77.8 ± 5^0) байсан ба түрэм засал хийснээс 9 өдрийн дараа тэнийх (171.4 ± 5.5^0), нугалах хөдөлгөөн (90 ± 13.2^0) болж статистик ач холбогдол ($*P < 0.05$) бүхий ялгаатайгаар 5.2% ба 15.6% тус тус нэмэгдсэн байна. (Зураг 1.)



Зураг 1. Өвдөгний үений далайц эмчилгээний өмнө ба дараа, n=7 (P<0.05)

Эмнэлзүйн зовиурыг үнэлэх Лекений индексийн үнэлгээ:

Шөнө өвддөг гэсэн зовиур эмчилгээний өмнө (1.4±1.34) балл байсан бол эмчилгээний дараа (1.0±1.2) балл болж статистик ач холбогдол (*P<0.05) бүхий ялгаатай буурсан байна. Явахад өвдөлттэй гэсэн зовиур эмчилгээний өмнө (2.2±0.44) балл байсан бол эмчилгээний дараа (1.2±0.44) балл болж статистик ач холбогдол бүхий (*P<0.05) ялгаатай буурсан байна. Хоёр цагаас дээш суухад өвддөг гэсэн зовиур эмчилгээний өмнө (0.8±0.44) балл байсан бол эмчилгээний дараа (0.1±0.44) балл болж статистик ач холбогдол бүхий (*P<0.05) ялгаатай буурсан байна. (Хүснэгт 1.)

Хүснэгт 1.

Лекений индексийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлт	Эмчилгээний өмнө (n=7)	Эмчилгээний дараа (n=7)
Шөнөдөө өвдөлттэй эсэх	1.4±1.34	1.0±1.2*
Явахад өвдөлттэй эсэх	2.2±0.44	1.2±0.44*
2 цагаас дээш суухад өвдөлттэй эсэх	0.8±0.44	0.1±0.44*
Өглөөний хөшингө	1.6±0.54	0.8±0.44*
30 минутаас дээш зогсоход өвдөлттэй эсэх	1.2±0.44	0.6±0.54*
Хөдөлгөөн хязгаарлагдах	4.6±1.14	3.2±0.83*
Нийт	1.9±1.37	1.1±1*

*P<0.05 vs эмчилгээний өмнө. Two way RM-ANOVA

Өглөөний хөшингө эмчилгээний өмнө (1.6±0.54) балл байсан бол эмчилгээний дараа (0.8±0.44) балл болж статистик ач холбогдол бүхий (*P<0.05) ялгаатай буурсан байна. 30 минутаас дээш зогсоход өвддөг гэсэн зовиур эмчилгээний өмнө (1.2±0.44) балл байсан бол эмчилгээний дараа (0.6±0.54) балл болж статистик ач холбогдол бүхий (*P<0.05) ялгаатай буурсан байна. Өвдөгний үений хөдөлгөөн хязгаарлагдах зовиур эмчилгээний өмнө (4.6±1.14) балл байсан бол эмчилгээний дараа (3.2±0.83) балл болж статистик ач холбогдол бүхий (*P<0.05) ялгаатай буурсан байна. (Хүснэгт 1.)

Хэлцэмж:

Монгол мэргэдийн бүтээлүүдэд хүйтэн сэрүүн нөхцлөөс шалтгаалж үүссэн хийн өвчин, бадганы өвчин, хий бадган хавсарсан хүйтэн чанартай өвчин, эс шингэсэн, бэтэг, усан хаван, шар усны өвчин ялангуяа үе, мөчний хүйтэн шар усны өвчин, цагаан судлын өвчин буюу мэдрэлийн гаралтай өвчнүүдэд илүү тохирно хэмээжээ. Түүнчлэн түрэм заслын хатгах бэлчир, байршил эмчилгээний заалтыг нарийвчлан заасан байна.

БНХАУ-ын ӨМӨЗО-ны судлаач Алтанчимэг (2011) нарын судалгаагаар бүсэлхийн нугалмын жийргийн ивэрхий өвчний үед халуун хатгуур заслын

эмчилгээний 14 дэхь өдөр хурц өвчтэй хүмүүст 61,9%, архаг өвчтэй хүмүүст 83,5% тус тус эмнэлзүйн зовиурыг бууруулж, архаг өвчний үед илүү үр дүнтэй болохыг тогтоожээ.

УАУТХЭмнэлэгт 2010-2012 онд амбулаториор өвдөгний үений остеоартроз оношоор эмчлүүлэгсдэд хийгдсэн “кастемент бигнүүр”-ийн эмнэлзүйн судалгаагаар эмчилгээний өмнө үений нугалах хөдөлгөөн (95.0 ± 3^0) байсан ба эмчилгээний дараа (105 ± 5^0) болж 10%-аар нэмэгдсэн бол харьцуулж хийсэн шавар эмчилгээний өмнө үений нугалах хөдөлгөөн (92.5 ± 3^0) байсан ба эмчилгээний дараа (99.5 ± 3^0) болж 7,5% нэмэгджээ. [6]

Харин бидний судалгаагаар өвдөгний үений остеоартрозтой эмчлүүлэгсдэд түрэм засал эмчилгээний өмнө нугалах хөдөлгөөн (77.8 ± 5^0) байсан ба эмчилгээ хийснээс 9 өдрийн дараа нугалах хөдөлгөөн (90 ± 13.2^0) болж 15,6%-аар, тэнийх хөдөлгөөн 5,2%-иар нэмэгдсэн. Энэ нь түрэм засал үений нугалах хөдөлгөөний далайцыг шавар эмчилгээнээс 2 дахин, бигнүүр эмчилгээнээс 5,6%-иар илүү нэмэгдүүлж байна. Эндээс авч үзвэл уламжлалт түрэм засал нь хий, бадган хавсарсан архаг өвчний үед ялангуяа үе мөчний цагаан шар усны өвчинд үр дүнтэй болох нь харагдаж байна.

Дүгнэлт

1. Тайлбар зохиолуудад түрэм заслыг хий, бадган дийлэнх хүйтэн өвчний үед хэрэглэх бөгөөд нийт хатгах бэлчир оронг 110 байдгийг заажээ.
2. Түрэм засал нь өвдөгний үений контрактур үүссэн артрозын үед далайцыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна.
3. Өвдөгний үений остеоартроз өвчний үеийн эмнэлзүйн зовиурыг бууруулах нөлөөтэй байна.

Ном зүй

1. УАУТХЭмнэлгийн 2014 оны статистик тайлан мэдээ
2. Алтанчимэг “Бүсэлхийн нугалмын жийргийн ивэрхий өвчний эмнэлзүйн илрэлийг уламжлалт заслаар эмчлэх нь” Улаанбаатар 2011. х17
3. Ютэг Ёндонгомбо “Анагаах ухааны дөрвөн үндэс” Өвөрмонголын шинжлэх ухаан техник мэргэжлийн хэвлэлийн хороо. Хөх хот 1997. Х504
4. Ишбалжир “Дөрвөн рашаан” Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот 1998. х219-220
5. Д.Лувсанзориг “Зарлигын эрхэст харанхуйг арилгагч зул” Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. Хөх хот 1998. х58
6. Д.Баярмаа, Б.Саран, Б.Дагвацэрэн “Остеоартроз өвчний үед кастемент бигнүүрийг хэрэглэсэн судалгааны дүн” Монголын уламжлалт анагаах ухаан сэтгүүл. Улаанбаатар 2013. х49-54

Abstract

Result of Turem treatment in knee osteoarthritis

Jargalkhuu E¹, Bayarmaa D², Seesregdorj S³

¹Institute of Traditional Medicine and Technology

²MNUMS-MSU-Institute of Traditional Medicine.

Keywords: turem, knee, amplitude

Abstract: Turem treatment which corrects defect of the five types of traditional therapy is a top value that is written to source and description novel. The turem treatment is contribution in the traditional medicine from Mongolians. Traditional literature had taught Indications and precautions for turem treatment and written 110 points in detail. Knee osteoarthritis is wide spread among the Mongolians . Because it has many causes: weather , environment, diet, wrong life style. We measured amplitude of the knee joint by goniometer and signs and symptoms assessed by Leken’s functional index (0-6 scores). In our study, before the treatment knee joint flexion movement was (77.8 ± 5^0) and after 9 days, flexion movement was improved approximately by 15,6%, reached (90 ± 13.2^0),. Knee extensor movement was increased by 5,2%. The turem treatments result of flexor movement of knee joint was two times than mud therapy. Such movement increased by 5,6% compared to compress therapy.

Туршилтын амьтанд үүсгэсэн элэгний хурц үрэвслийн эмгэг загварт**“Антомен” бэлдмэлийн үзүүлэх нөлөө**

Уранбайгаль.Н¹, Ариунаа.З², Чимэдрагчаа.Ч²

¹Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль, Уламжлалт Анагаахын Институт

²Уламжлалт Анагаах Ухаан Технологийн Хүрээлэн

Товч утга

Элэгний цочмог архаг үрэвсэл, элэгний хатуурал, хавдар нь манай орны хувьд нийт өвчлөлийн дээгүүр байранд ордог. Тиймээс элэг хамгаалах үйлчилгээтэй шинэ эм бэлдмэл хийх нь судлаач бидний тэргүүнд тавих асуудал болж байна. Бид УАУТХ-ийн эмийн үйлдвэрт үйлдвэрлэгдсэн “Антомен” бэлдмэлийг сонгон авч судалгаандаа ашигласан. Элэгний хурц үрэвслийн эмгэг загварыг Handa.S.S, Sharma.A нарын аргаар үүсгэж Вистар үүлдрийн 40 харх авч 4 бүлэг болгон хуваагаад туршилт явуулсан. Туршилт 7 хоног үргэлжилж 8 дах хоногийн өглөө амьтнаас цус, эдийг авч биохимийн үзүүлэлт (АсАТ, АлАТ, ШФ) болон гистологийн шинжилгээ хийсэн. Судалгааны үр дүнд “Антомен” бэлдмэл нь элэгний үрэвсэл дарах, элэг хамгаалах үйлчилгээтэй болох тогтоогдсон.

Түлхүүр үг: Lonicera altaica Pall, Mentha arvensis, CCL₄, элэгний үрэвсэл

Удиртгал

2013 оны байдлаар хүн амын өвчлөлийн тэргүүлэх 5 шалтгааны эхний 2-т хоол боловсруулах тогтолцооны өвчин /10 000 хүн амд 1056.8/ орж, хоол боловсруулах тогтолцооны өвчний дотор элэгний эмгэг 27.0 хувь, цэсний хүүдийн өвчнүүд 14.6 хувийг эзэлж байна. Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын 23.4 хувийг эзэлж байгаа ба 10000 хүн амд 26.3 ноогдож байна. Тэргүүлэх 5 шалтгааны 1-т элэгний хорт хавдар байна.[1]. Тиймээс элэг хамгаалах, элэгний хатуурал, хавдараас урьдчилан сэргийлэх үйлчилгээтэй шинэ эм бэлдмэл хийх нь бидний зорилго болно.

Материал, арга зүй

Судалгаанд УАУТХ-ийн Эмийн үйлдвэрт үйлдвэрлэгдсэн “Антомен” бэлдмэлийг ашиглав. Бэлдмэлийн хурц хорон чанарын судалгааг лабораторийн цагаан хулганад

OECD-ийн удирдамж 420-ийг мөрдлөг болгон тодорхойлов. Туршилтын амьтанд элэгний хурц үрэвслийн эмгэг загварыг Handa.S.S, Sharma.A (1990) [2] нарын аргаар 40 толгой Вистар үүлдрийн харх авч 4 бүлэгт хуваан бүлэг тус бүрт 10 харх байхаар сонгон авсан. Туршилт 7 хоног үргэлжилсэн бөгөөд 8 дахь өдрийн өглөө амьтнаас цус, эдийг авч биохимийн үзүүлэлт (АсАТ, АлАТ, ШФ) болон гистологийн шинжилгээ хийсэн. Судалгааны ажлын үр дүнг биостатистикийн үндсэн аргуудаар арифметик дундаж (M), стандарт хазайлт(μ), стандарт алдаа (m), итгэмжлэх хязгаар (CI-95%) болон дундаж тооны үнэн магадлалыг ANOVA тестээр шалган, боловсруулалтыг SPSS 16.0 программыг ашиглан хийж гүйцэтгэсэн.

Үр дүн

“Антомен” бэлдмэлийн хурц хорон чанарыг тодорхойлоход туршилтын амьтдад үхэх болон арьс, үс, хөдөлгөөн, амьсгал, хоолны дуршил зэрэгт ямар нэг өөрчлөлт гараагүй. Харханд дөрвөн хлорт нүүрстөрөгч –өөр өдөөсөн элэгний хурц үрэвсэлд “Антомен” бэлдмэлийн үзүүлэх нөлөөг АсАТ, АлАТ, ШФ-ийн үзүүлэлтээр үнэллээ.

Хүснэгт 1. Антомен бэлдмэлийн үзүүлэх нөлөө

Д/д	Туршилтын бүлгүүд	АсАТ(U/L)	АлАТ(U/L)	ШФ(U/L)	P
1	Эрүүл (n=10)	67.9	79.1	367.1	P<0.05
2	Хяналт (n=10)	541.5	479.3	1043.9	P<0.05
3	Карсил (n=10)	276.5	263.7	616.6	P<0.05
4	Антомен (n=10)	401.1	297.1	813.7	P<0.05

Хүснэгт 1-ээс харахад хяналтын бүлгийн амьтдын үзүүлэлтийг эрүүл бүлэгтэй харьцуулахад АсАТ-ын хэмжээ 8, АлАТ-ын хэмжээ 6, ШФ-ийн хэмжээ 2.8 дахин тус тус нэмэгдсэн байна. Эндээс харахад туршилтын амьтдад элэгний үрэвслийн эмгэг загвар үүссэн гэдэг нь харагдаж байгаа бөгөөд Антомен бэлдмэлийг өгсөн бүлгийг хяналтын бүлэгтэй харьцуулахад АсАТ-ын хэмжээ 25.9, АлАТ-ын хэмжээ 38, ШФ-ийн хэмжээ 22.1 хувиар тус тус бага байв.

Хэлцэмж

ССL₄-өөр үүсгэсэн эмгэг загвар нь туршилтын амьтны элэгний эсийн гадаргууд өөхний хэт исэлдэлтийн процессийг идэвхжүүлж эсийн мембраныг шууд гэмтээдэг бөгөөд бидний судалгааны дүнгээс харахад эрүүл бүлгийг хяналтын бүлэгтэй харьцуулахад АсАТ-ын хэмжээ 8, АлАТ 6, ШФ 2.8 дахин тус тус ихэссэн байгаа нь туршилтын амьтдад элэгний үрэвслийн эмгэг загвар үүссэн байгаа нь харагдаж байна. Туршилт судалгааны үр дүнд антомен бэлдмэл өгсөн бүлгийг хяналтын бүлэгтэй харьцуулахад АсАТ 25.9, АлАТ 38, ШФ 22.1 хувиар тус тус багассан байна. Энэхүү үр дүн нь З.Ариунаа нарын 2009 оны судалгаагаар алтайн даланхальсны бэлдмэл нь зохиомлоор үүсгэсэн асептик үрэвслийн үед гадаргуугийн нөхөн төлжилтийг дэмжих, элэгний архаг үрэвсэл, циррозын үед элэгний эсийн задралыг бууруулах, эсийн нөхөн төлжилтийг сайжруулдаг болохыг нотолсон үр дүнтэй нийцэж байна.[3] Мөн Kowti Rajesh нарын Энэтхэгийн эрдэмтдийн 2013 оны судалгаагаар батрашийн хандмал нь элэгний эс хамгаалах, хэт исэлдэлтийн эсрэг үйлдэлтэй болох нь батлагдсан үр дүнтэй тус тус тохирч байна.[4]

Ном зүй

1. <http://www.chd.moh.mn/images/pdf/sma/uzuulelt/uzuulelt%202013%20on.pdf>
2. Handa SS, Sharma A: Hepatoprotective activity of andrographolide from *Andrographis paniculata* against carbon tetrachloride. Indian J Med Res [B]
3. З.Ариунаа, Ц.Хайдав, Б.Ууганбаяр, Б.Дагвацэрэн, Л.Галцог. Алтайн далан хальсны бэлдмэлийн фитохими болон фармакологийн судалгааны зарим үр дүн. Монголын анагаах ухаан, 2009, 2(148)
4. Kowti Rajesh, A.H.M. Vishwanath Swamy, Shivakumar.S.Inamdar, Vedamurthy Joshi, Abdul nasir Kurnool. Hepatoprotective and antioxidant activity of ethanol extract of *Mentha arvensis* leaves against carbon tetrachloride induced hepatic damage in rats. International journal of pharm tech research. 2013. Vol.5, No.2, pp 426-430

Abstract

Hepatoprotective effect of “Antomen” preparation on CCL₄ induced hepatic damage in rats

Uranbaigali.N¹, Ariunaa.Z², Chimedragchaа.Ch³

¹Mongolian National University of Medical Sciences

²Institute of traditional medicine and technology

Keywords: Loniceraaltaica Pall, Mentha arvensis, CCL₄, hepatitis

Background: In the world the second out of top 5 diseases is gastroenterological diseases, particularly hepatocholelcytic diseases. LoniceraaltaicaPall, Menthaarvensis are contained in “Antomen” and were used in traditional medicine hepatocholelcytic inflamations, oedema, gastric diseases.

Objective: To study Antomen’s effect on rats with acute hepatic inflamation.

Methods: 40 wistar rats weighing 180-220 g were divided into 4 groups: healthy, control, with standard treatment and antomen’s treatment. Group1 rats were fed with normal standard diet for a week.Group 2 rats (control rats were injected into abdomen with CCL₄0.8 mg/kg together with olive oil with dosage of 1:1. Control rats were given orally 0.9%NaCl with dosage of 0.8 mg/kg). Group 3 (rats were injected into abdomen with CCL₄0.8 mg/kg together with olive oil with dosage of 1:1. Group 3 rats were given orally Carsil with dosage of 40 mg/kg). The last group (rats were injected into abdomen with CCL₄0.8 mg/kg together with olive oil with dosage of 1:1. Group 4 rats were given orally antomen 200 mg/kg)

The experiment continued for a week and on eighth day GPT, GOT and histopathological tests were done.

Results:From the result of the study it was determined the preparation has no toxicity. There were no any differences observed in movements, appetite, and color of skin in mise. Group 4 rats were compared with control rats and indications such as GPT-25.9%, GOT-38%, alkaline phosphatase-22,1% were decreased.

Conclusion: It can be clearly shows that antomen preparation has hepatoprotective effect.

Өтгөн хаталтыг дасгал хөдөлгөөнөөр эмчилэх нь*Б.Нямжав¹ Ч.Батнайрамдал²**АШУУИС, УАИ***Хураангуй:**

Өтгөн хаталтыг эмийн бус аргаар эмчлэх зарим асуудалд дүн шинжлэл хийх

Судалгааг 2015.06 сараас 2015.09 сар хүртэлх хугацаанд судалгааны болон хяналтын бүлгийн нийт 60 хүнийг оролцуулан хийж гүйцэтгэв. Бидний судалгаанд 20-с дээш насны, жирэмсэн бус, өтгөн хатах хам шинжтэй, нэг болон хоёрдугаар зэргийн таргалалттай, тулгуур эрхтэн системийн эмгэггүй хүмүүсийг мөргөл болон иогийн дасгал хөдөлгөөний хоёр бүлэг болгон бүлэг тус бүрд 25 хүнийг хамруулав.

Хяналтын бүлэгт асуумжаар өтгөн хаталтгүй, байнгын дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг 10 хүнийг хамруулсан. Нийт судалгаанд оролцогчдод антропометрын хэмжилтүүдийг хэмжиж, венийн судасны цусанд электролитын хэмжээг тодорхойлсон.

Ус уулгаж мөргөл хийснээс хойш өтгөн хаталттай хүнд 97.8 ± 3.7 мин, иогийн дасгал хийснээс хойш өтгөн хаталттай хүнд 100.6 ± 6.3 минутын дараа туулгалт эхэлж байгаа нь судалгааны явцад ажиглагдав.

Өтгөн хаталттай хүмүүсийн биеийн жингийн индекс (БЖИ) мөргөл хийхээс өмнө 30.64 кг/м^2 , мөргөл хийсний дараа 25.23 кг/м^2 , иогийн дасгал хийхээс өмнө 31.17 кг/м^2 , иогийн дасгал хийсний дараа 28.81 кг/м^2 байв.

Сунаж мөргөх, иогын дасгал хөдөлгөөний дараа туулгах үйл эрчимжиж байгаагаас харахад хөдөлгөөний хомсдол нь өтгөн хатахад хүргэдэг гол эрсдэлт хүчин зүйлийн нэг болж байна. Сунаж мөргөсөний дараа БЖИ болон электролитийн баланс тогтворжиж байгаагаас үзэхэд мөргөх болон иог нь эмчилгээний үр дүнтэй болохыг харууллаа.

Түлхүүр үг:

Дасгал хөдөлгөөн, мөргөл, өтгөн хаталт

Удиртгал

Дасгал хөдөлгөөнөөр хичээллэснээр бодисын солилцоо эрчимжиж судасны ханан дахь хорт бодисын хуримтлалыг бууруулж улмаар илүүдэл жинг багасгана, мөн стрессээ

тайлж хүн тайван байснаар артерийн даралтад эерэг нөлөө үзүүлнэ гэж үздэг. Монголчууд эрт үеэс тогтмол хөдөлгөөнтэй амьдарлын хэв маягаар амьдарч ирсэн бөгөөд сүм хийд явж эргэл мөргөл, гороо хийх, аргал түүх түлш түлээгээ бэлтгэх, хонь малаа явган хариулах, малынхаа ноосыг хяргах, эмнэг сургах, жин тээх зэрэг хөдөлгөөнийг хийхээс гадна хоол хүнсээ амьдрал ахуйтайгаа зохицуулж өвлийн улиралд илчлэг ихтэй махан хүнс базааж, өрөм, шар тос бэлтгэх, ногоо, жимсийг хатаах, даршлах зэргээр идэш бэлтгэн, харин зуны улиралд сүү, цагаан идээг голчлон хэрэглэж махан хүнсний хэрэглээг багасгаж өвлийн идэштэй хамт бэлдсэн борцыг хоол ундандаа хэрэглэж амьдарлын зөв хэв маягыг баримтлан хооллож иржээ. Энэ их хөдөлгөөн, хоол хүнсний зохицуулга нь биед илүүдэл өөх тос хуримтлагдахаас сэргийлж бодисын солилцооны үйл ажиллагааг хэвийн байлгахүндэс болж байна.

Судалгааны шинэлэг тал: Монголын уламжлалт өв, соёлын салшгүй хэсэг болох бурханы шашины зан үйл- мөргөлийг эрүүл мэндтэй холбон судалж түүний эрүүл мэндийн ач холбогдлыг нотолгоонд суурилан гаргаж тавих

Судалгааны зорилго: Өтгөн хаталтыг эмийн бус, мөргөлийн аргаар эмчлэх асуудалд дүн шинжлэл хийх

Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй

АШУҮИС-ийн АУС-н УАҮИ-н онолын тэнхмийн удирдлаган дор УХТЭ болон Дашчойлон хийдэд түшиглэн 2015.06-2015.09 хооронд нийт 60 хүнд Хельсинкийн тунхаглалын дагуу боловсруулсан таниулсан зөвшөөрлийн хуудсыг оролцогчдод танилцуулан судалгаанд оролцох зөвшөөрөл авч судалгаанд хамруулсан. Бид судалгаандаа 20-с дээш насны, жирэмсэн бус, өтгөн хатах хам шинжтэй, 1 болон 2-р зэргийн таргалалттай, тулгуур эрхтэн системийн эмгэггүй хүмүүсийг мөргөл болон иогийн дасгал хөдөлгөөний хоёр бүлэг болгон бүлэг тус бүрд 25, нийт 50 хүн хамруулав. Мөн хяналтын бүлэгт 10 хүн хамруулсан. Хяналтын бүлгийн оролцогчид нь асуумжаар өнгөн хаталтгүй, байнгын дасгал хөдөлгөөнөөр хичээллэдэг хүмүүс юм. Нийт судалгаанд оролцогчдод антрапометрын хэмжилтүүдийг хэмжиж, венийн судасны цусанд электролитын хэмжээг тодорхойлсон.

Үр дүн:

Мөргөл хийхийн өмнө судалгаанд оролцогчдын цусанд дах электролитийн хэмжээ дунджаар Са 1,58ммоль/л, Mg 1,24ммоль/л, Na 113,52ммоль/л, Cl 73,8ммоль/л, Здах өдрийн дараа Са 1,24ммоль/л, Mg 0,91ммоль/л, Na 102,18ммоль/л, Cl 61,3ммоль/л, судалгааны төгсгөлийн өдөр Са 1,37ммоль/л, Mg 1,17ммоль/л, Na 109,8ммоль/л, Cl 68,3ммоль/л байв.

Иогийн дасгал хийхийн өмнө судалгаанд оролцогчдын цусанд дах электролитийн хэмжээ дунджаар Са 1,63ммоль/л, Mg 1,20ммоль/л, Na 121,8ммоль/л, Cl 68,3ммоль/л, Здах өдрийн дараа Са 1,49ммоль/л, Mg 0,98ммоль/л, Na 113,1ммоль/л, Cl 57,8ммоль/л, судалгааны төгсгөлийн өдөр Са 1,53ммоль/л, Mg 1,0ммоль/л, Na 115,8ммоль/л, Cl 60,3ммоль/л байв.

	Мөргөл			Иог			Хяналт
	Эхний өдөр	Здах өдөр	Сүүлийн өдөр	Эхний өдөр	Здах өдөр	Сүүлийн өдөр	
Са /ммоль/л/	1.58	1.24	1.37	1.63	1.49	1.53	2.3
Mg /ммоль/л/	1.24	0.91	1.17	1.20	0.98	1.0	1.87
Na /ммоль/л/	113.52	102.18	109.8	121.8	113.1	115.8	128.3
Cl /ммоль/л/	73.8	61.3	68.3	68.3	57.8	60.3	90.8

Дүгнэлт:

Өтгөн хатахад хөдөлгөөн багатай байх нь нөлөөлөх хүчин зүйл болж байгаа нь харагдлаа. Сунаж мөргөсөний дараа БЖИ болон электролитийн баланс тогтворжиж байгаа нь сунаж мөргөх хөдөлгөөн эмчилгээний эерэг үр дүнтэй болохыг харууллаа.

Ном зүй

1. Хандсүрэн.Б, Сүхбат.Г “Анхдагч артерийн гипертензитэй өвчтөнийг дасгал хөдөлгөөний жороор эмчилсэн үр дүн” Монголын анагаах ухаан, 2009 он
2. Arthur Agatston. The Core of Heart Health. 2007

3. Ариунаа.Х “Спортын урт буугаар шагайн зогсох үеийн хөвчин биеийн зарим булчингийн био цахилгаан идэвхижилийн байдал”
4. Б.Дагвадорж Н.Бира Ц. Сарантуяа Б.Болор “Баас хатах хамшинжийг эрт оношлох арга” Онош, 1999, (001) 1999.No1(001)
5. Д.Энхжаргал, З.Ариунаа “Хоол боловсруулах замын эмгэгийн уламжлалт эмчилгээний үр дүнг чанд авиагаар үнэлэх нь” Монголын анагаах ухаан, 2009, 3(149)

Abstract

Exercise to be done during the constipation symptom

Goal: To do analysis on some issues about treatment for constipation using non-drug method

Hypothesis: There is a probability that people who pilgrimage have high muscle development comparing to people who do normal exercise and movement.

Methods: Total 60 people have been involved from June 2015 until September 2015 and total 50 people have been involved after people aged more than 20 years old, not pregnant, having constipation symptom, with 1 or 2nd class of overweight, without any disorder of supporting organs are divided into 2 groups and 25 were participated who do pilgrimage or yoga exercise. Also, 10 people were involved in control group. According to the questionnaire, they haven't got light constipation and do permanent exercises and movement. All participants were measured by anthropometer and defined their electrolyte volume in the blood of vein.

Result

For electrolyte volume in blood of the participants in the research before their pilgrimage, Ca was 1,58 mmol/L, Mg was 1,24 mmol/L, Na was 113,52 mmol/L, Cl was 73,8 mmol/L in average, Ca was 1,24 mmol/L, Mg was 0,91 mmol/L, Na was 102,18 mmol/L, Cl was 61,3 mmol/L after three days, Ca was 1,37 mmol/L, Mg was 1,17 mmol/L, Na was 109,8 mmol/L, Cl was 68,3 mmol/L at the last day of the research.

For electrolyte volume in blood of the participants in the research before their yoga exercise, Ca was 1,63 mmol/L, Mg was 1,20 mmol/L, Na was 121,8 mmol/L, Cl was 68,3 mmol/L in average, Ca was 1,49 mmol/L, Mg was 0,98 mmol/L, Na was 113,1 mmol/L, Cl was 57,8

mmol/L after three days and Ca was 1,53 mmol/L, Mg was 1,0 mmol/L, Na was 115,8 mmol/L, Cl was 60,3 mmol/L at the last day of the research.

Conclusion:

It has been determined that less movement causes influencing factor for constipation. It shows that treatment is effective because body weight index and electrolyte balance is becoming stable after the stretch and pilgrimage.

Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч”-д харшлах идээний талаар өгүүснийг тодруулсан нь*Б.Нансалмаа¹ Т.Лхамжав² Г.Эрдэнэбулган³ С.Сээсрэгдорж⁴**¹²³ АШУҮИС.АУС.УАУИ.604**⁴ АШУҮИС.АУС.УАУИ*

Үндэслэл: Биеийг эрүүл байлгаж, эм заслын үйлдлийг нэмэгдүүлэхэд идээ ундааны цээрлэл чухал ач холбогдолтой. Энэ тухай “Идээ ундааны жинхэнэ товч” номонд <<Юуны урьд идээ ундааны цээрлэлийг баримталж махбодын жинхэнэ чанарыг үл алдагдуулан дараа нь сая эм заслыг үйлдэж өвчин эмгэгээс сэргийлнэ>> гэсэн байдаг. Түүхэн эх сурвалж судлаачдын бүтээл тэмдэглэлээс харахад монголчууд идээ ундааны зүйлийг амьдрахын шүтээн хэмээн үзэж өвчнөөс урьдчилан сэргийлэх үндэс гэж үзсээр иржээ.

Дэлхий ертөнц глобалчлагдаж, улс орон хөгжихийн хэрээр хүмүүсийн хооллолтын хэв маяг, хоолны шинж чанарт өөрчлөлт орж байгаа нь хүний биед өвчин эмгэг үүсгэх нэг шалтгаан болж байна. Эрүүл зөв хооллолтын талаар хүмүүсийн тэр бүр мэдээд байдаггүй зүйлийн нэг бол хоорондоо үл зохицох буюу харшлах идээ ундаа юм. Хүссэн бүхнээ эсвэл олдсон бүхнийг нэг дор холилдуулан идэх нь хүний биед муугаар нөлөөлж хоол биш хор болдог байна. Мөн эм ууж хэрэглэж байх үед идэж болдоггүй идээ ундаа байдаг.

Энэ талаар Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч” номонд идээ ундааны харшлах зүйл болон эм уухад цээрлэх зүйлийн талаар бичиж тэмдэглэсэн зүйлс нэлээд их байдаг. Нөгөө талаар энэхүү ном нь Монголын Юань гүрнээс хойших хаад ноёдын ордонд бэлтгэн хэрэглэж байсан идээ ундаа, баримталж байсан дэг жаяг, амьдрал ахуйгаас үндэслэн бичигдсэн учир одоо үед үүнийг нарийвчлан судалж үзэх нь ач холбогдолтой.

Зорилго

Хүсэхүйн “Идээ ундааны жинхэнэ товч”-д харшлах идээний талаар өгүүснийг тодруулан судалсан нь

Зорилт

1. Идээ ундааны жинхэнэ товчийн агуулгыг тоочиж илэрхийлэх
2. Харшлах идээ ундааг судлан тодруулах
3. Эм уухад харшлах идээ ундааг тодруулах

Судалгааны арга зүй

1. Эх бичиг, сурвалж бичгийн харьцуулан судлах арга [1] [2]
2. Задлан шинжилж нэгтгэн дүгнэх арга [1]

Түлхүүр үг

Идээ ундаа, эм, цээрлэл, харшлал

Эх хэрэглэгдэхүүн

Хүсэхүй эмч 13 зууны сүүл 14 эхэн хагасын үед амьдарч байжээ. 1314-1320 онд тэрбээр хааны ордны идээ ундааны зоогийг тусгайлан хамаарч тохируулдаг дотоод сайд бөгөөд шадар эмчийн ажлыг хариуцаж байсан байна. Хубилай сэцэн хаанаас Есөнтөмөр хаан хүртэлх монгол хааны ордонд хэрэглэгдэж байсан идээ ундааны зүйл, эрдэнийн үрэл, эм тан, эмч нарын туршлагат жор, эгэл бус нууцыг цуглуулан эмхтгэж “Идээ ундааны жинхэнэ товч” хэмээх монголын анагаах ухаанд шууд холбогдох анхны идээ ундааны тухай бие даасан зохиолын 1330 онд бичжээ.[3]

Энэхүү номыг олон зуун жилийн дараа Хөхлуу гэгч хүн Монголчилж 1982, 2013 ондуудад 224 хуудас бүхий ном уйгаржин монгол бичгээр хэвлүүлсэн байна. Мөн 2005 онд СХУ-ны доктор дэд профессор С.Сэдэддулам, Анагаах ухааны магистр Т.Алимаа нар кирилл дээр хөрвүүлэн 170 хуудас ном хэвлүүлсэн. Хамт хэрэглэхэд болон эмэнд харшлах идээ ундаа, идээний ашиг хор, идээний хорыг тайлах аргыг талаар 85-95 хуудсанд бичснийг эх хэрэглэгдэхүүн болгож авлаа.

Үр дүн: Энэхүү ном нь гурван дэвтэр (бүлэг) бүхий бүтээл бөгөөд нэгдүгээр дэвтэрт Гурван хаан богдын товч тэмдэглэл, цээрлэх зүйлүүд, эрхэм найралт идээ ундаа хэсэгт 24 төрлийн шөл, 5 төрлийн зууш, 5 төрлийн ялчэн (холимог), 11 төрлийн боорцог, 2 төрлийн шуубин, 10 төрлийн шош, 2 төрлийн шармал, 5 төрлийн идээ, 4 төрлийн мантуу, 4 төрлийн шингэн будаа, 5 төрлийн махан хоол болон бусад 17 төрлийн хоол нийтдээ 94 зүйлийн хоолны орц, найрлага үйлдлийг тайлбарлан бичсэн. Хоёрдугаар дэвтэрт 56 төрлийн тан, ширгээмэл, зутан, цайны орц найрлага, хийх арга болоод үйлдэл үйлчилгээний тухай бичсэн. Мөн усны зүйл хоёр, арш сахиулсаны эм адис 26 зүйл, өвчнийг 67 зүйлийн идээ ундааны заслаар засах зэргийг бичиж тэмдэглэсэн байна.

Мөн энэ бүлэгт цаг улирлын өөрчлөлт солигдолтыг дагаад хүний бие организм өөрчлөгдөж байдгийг үндэслэн тухайн улирлын онцлог болон тэр үед тохирох идээ, ундааг хэрэглэх, хувцас хунар өмсөх, хэзээ унтаж, сэрэх юу юуг хийж болох, болохгүй зэрэг явдал мөрийн нөхцөлүүд, хамтад нь идэж хэрэглэж болохгүй 84 зүйлийн цээрлэл, идээний хорыг хэрхэн яаж тайлах арга, түүнчлэн араатан, жигүүртэн, ургамлын дүрс хувирсан гаж хэлбэр нь хүнд хор болно гэж үзэн хачин жигтэй хэлбэр дүрстэй болж хувирсан зүйлийг идэхээс цээрлэхийн тухай бичсэн байна. Гуравдугаар дэвтэрт амуу будааны 23 зүйл, араатны 33 төрөл, жигүүртний 24 төрөл, загасны 22 төрөл, ногооны 46 төрөл жимсний 39 төрөл, 28 зүйлийн эмт бодисын тухай бичигджээ. [1]

Идээ ундааны харшлалд морины махтай хамт хэрэглэж болохгүй 3 зүйл байна. Морины махын сангийн хуучин эмтэй идэж үл болно. Морины махыг надма хийгээд гаатай хамт идэж үл болно. Хонины элэгтэй хамт хэрэглэж болохгүй 2 зүйл

байна. Хонины элгийг чинжүүтэй хамт идэж үл болно. Идвээс зүрхний тамирыг хөнөөнө. Хонины элгийг гахайн махтай идэж үл болно.

Хонины гүзээг хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Хонины гүзээг эрс буурцаг ба гүйлсийн үртэй хамт идэж үл болно. Идвээс хүнийг гэмтээнэ.

Хонины махыг хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Хонины махыг загасны мах хийгээд дарсан тарагтай хамт идэж үл болно.

Үхрийн махтай хамт идэж болохгүй 2 зүйл байна. Гахайн махыг үхрийн махтай хамт идэж үл болно. Үхрийн махыг туулайн бөөртэй хамт идэж үл болно.

Үхрийн элэгтэй хамт идэж болохгүй 1 зүйл байна. Үхрийн элгийг цулбуурт загастай хамт идэж үл болно. Идвээс хийг үүсгэнэ.

Үхрийн гэдэстэй хамт идэж болохгүй 1 зүйл байна. Үхрийн гэдсийг нохойн махтай хамт идэж үл болно.

Гахайн махтай хамт хэрэглэж болохгүй 7 зүйл байна. Гахайн махыг үхрийн махтай хамт идэж үл болно. Гахайн махыг хэлтэг загастай идэж үл болно. Гахайн махыг үсүтэй хамт идэж үл болно. Идвээс гэдсийг илжрүүлнэ. Сам хорхойг гахайн махтай хамт идэж үл болно. Идвээс дуслыг хорлоно. Шар буурцгийн үртсийг гахайн махтай хамт идэж үл болно. Хонины элгийг гахайн махтай идэж үл болно. Бүдэнгийн махыг гахайн махтай идэж үл болно. Идвээс нүүр харлана.

Гахайн элэгтэй хамт хэрэглэж болохгүй 1 зүйл байна. Гургуулыг гахайн элэгтэй хамт идэж үл болно.

Туулайн махтай хамт хэрэглэж болохгүй 3 зүйл байна. Туулайн махыг гаатай хамт идэж үл болно. Идвээс наян хижигт нэрвэгдэнэ. Тахианы махыг туулайн махтай хамт идэж үл болно. Идвээс туулгуулна. Гаймуу талхыг туулайн махтай хамт идэж үл болно. Идвээс яр шарх гарна.

Туулайн бөөртэй хамт идэж болохгүй 1 зүйл байна. Үхрийн махыг туулайн бөөртэй хамт идэж үл болно.

Нохойн махтай хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Үхрийн гэдсийг нохойн махтай хамт идэж үл болно. Мөрөг загасыг нохойн махтай хамт идэж үл болно.

Тахианы махтай хамт хэрэглэж болохгүй 4 зүйл байна. Тахианы махыг загасны шөлтэй хамт идэж үл болно. Идвээс бэтгэрнэ. Тахианы махыг туулайн махтай хамт идэж үл болно. Идвээс туулгуулна. Сам хорхойг тахианы махтай хамт идэж үл болно. Улаан гүйлсийг тахианы махтай хамт идэж үл болно.

Тахианы өндгийг хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Тахианы өндгийг лаг мэлхийн махтай хамт идэж үл болно. Тахианы өндгийг түүхий сонгино сармистай хамт идэж үл болно. Идвээс хийг хорлоно.

Гургуулын махыг хамт хэрэглэж болохгүй 6 зүйл байна. Гургуулыг гахайн элэгтэй хамт идэж үл болно. Гургуулыг цулбуур загастай хамт идэж үл болно. Идвээс солиорч балайрах өвчнийг үүсгэнэ. Гургуулыг сагагийн гурилтай хамт идэж үл болно.

Идвээс хорхой өвчинд нэрвэгдэнэ. Гургуулыг хушга хийгээд мөөгтэй хамт идэж үл болно. Гургуулыг хэлтэг загастай хамт идэж үл болно.

Гургуулын өндгийг хамт хэрэглэж болохгүй 1 зүйл байна. Гургуулын өндгийг сонгинотой хамт идэж үл болно. Идвээс хорхой өвчинд нэрвэгдэнэ.

Бүдэнгийн махыг хамт идэж болхгүй 2 зүйл байна. Бүдэнгийн махыг гахайн махтай идэж үл болно. Идвээс нүүр харлана. Бүдэнгийн махыг хээрийн мөөг далдуугийн зүйлтэй хамт идэж үл болно.

Загасны махтай хамт хэрэглэж болохгүй 3 зүйл байна. Гүүний сүүг загасны махтай хамт идэж үл болно. Идвээс бэтгэрнэ. Хонины махыг загасны мах хийгээд дарсан тарагтай хамт идэж үл болно. Шилмийг загасны махтай хамт идэж үл болно.

Цулбуур загастай хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Гургуулыг цулбуур загастай хамт идэж үл болно. Идвээс солиорч балайрах өвчнийг үүсгэнэ. Үхрийн элгийг цулбуурт загастай хамт идэж үл болно. Идвээс хийг үүсгэнэ.

Мөрөг загастай хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Мөрөг загасыг нохойн махтай хамт идэж үл болно. Эрс буурцгийн мөрөг загастай хамт идэж үл болно.

Хэлтэг загастай хамт хэрэглэж болохгүй 3 зүйл байна. Гургуулыг хэлтэг загастай хамт идэж үл болно. Гахайн махыг хэлтэг загастай идэж үл болно. Хэлтэг загасыг чихэр бурамтай хамт идэж үл болно.

Лаг мэлхийн махыг хамт хэрэглэж болохгүй 3 зүйл байна. Тахианы өндгийг лаг мэлхийн махтай хамт идэж үл болно. Нугасны махыг лаг мэлхийн махтай хамт идэж үл болно. Арвай ногоог (шарвалж) лаг мэлхийн махтай хамт идэж үл болно.

Сам хорхойтой хамт идэж болохгүй 4 зүйл байна. Сам хорхойг чихэртэй хамт идэж үл болно. Сам хорхойг тахианы махтай хамт идэж үл болно. Сам хорхойг тахианы махтай хамт идэж үл болно. Шоо бугын махыг сам хорхойтой хамт идэж үл болно.

Дэгсрэнгэй идэж болохгүй 2 зүйл байна. Модон шавдал хийгээд алимыг дэгсрэнгэй хамт идэж үл болно.

Чихэр бурамтай хамт хэрэглэж болохгүй 4 зүйл байна. Хэлтэг загасыг чихэр бурамтай хамт идэж үл болно. Улаан халмануудыг чихэртэй хамт идэж үл болно. Хулсан модны сүүг чихэртэй хамт идэж үл болно. Сам хорхойг чихэртэй хамт идэж үл болно.

Сагагийн гурилыг хамт хэрэглэж болохгүй 2 зүйл байна. Шаргал загасыг сагагийн гурилтай хамт идэж үл болно. Гургуулыг сагагийн гурилтай хамт идэж үл болно. Идвээс хорхой өвчинд нэрвэгдэнэ.

Түүхий сонгино сармистай хамт идэж болохгүй 4 зүйл байна. Гургуулын өндгийг сонгинотой хамт идэж үл болно. Идвээс хорхой өвчинд нэрвэгдэнэ. Тахианы өндгийг түүхий сонгино сармистай хамт идэж үл болно. Идвээс хийг хорлоно. Түүхий сонгиныг балтай хамт идэж үл болно. Янжуу гүйлсийг түүхий сонгинотой хамт идэж үл болно.

Эрс буурцагтай хамт идэж болохгүй 2 зүйл байна. Эрс буурцгийн мөрөг загастай хамт идэж үл болно. Хонины гүзээг эрс буурцаг ба гүйлсийн үртэй хамт идэж үл болно. Идвээс хүнийг гэмтээнэ.

Улаан гүйлстэй хамт идэж болохгүй 3 зүйл байна. Болжморын махыг улаан гүйлстэй хамт идэж үл болно. Улаан гүйлсийг тахианы махтай хамт идэж үл болно. Улаан гүйлс хийгээд төмөр зангууг балтай хамт идэж үл болно.

Улаан халматай хамт идэж болохгүй 2 зүйл байна. Улаан халмануудыг чихэртэй хамт идэж үл болно. Шүлхий амууг улаан халматай хамт идэж үл болно. Идвээс өвчнийг хөдөлгөнө.

Балтай хамт идэж болохгүй 5 зүйл байна. Улаан гүйлс хийгээд төмөр зангууг балтай хамт идэж үл болно. Түүхий сонгиныг балтай хамт идэж үл болно. Чавгыг балтай хамт идэж үл болно. Гашуун идээг балтай хамт идэж үл болно.

Дарсан тарагтай хамт идэж болохгүй 2 зүйл байна. Сүүт ногоог дарсан тарагтай хамт идэж үл болно. Хонины махыг загасны мах хийгээд дарсан тарагтай хамт идэж үл болно. Бугын махтай идэж болохгүй 2 зүйл байна. Бугын махыг вяа загас (хамуут загас)-тай хамт идэж үл болно. Шоо бугын махыг сам хорхойтой хамт идэж үл болно. Гогодыг хамт идэж болохгүй нэг зүйл байна. Гогодыг архитай хамт идэж үл болно гэж бичжээ..

Хэлцэмж: Нийтдээ давхцсан тоогоор 86 зүйлийн хоорондоо үл зохилдох идээ ундааг бичжээ. АУДҮ болон “Идээ ундааны жинхэнэ товч” номнуудад давхцан дурьдагдсан идээ ундаа, түүхий эд 10 байгаа хэдий ч түүнтэй харшлах идээ нь өөр өөр бичигджээ. Жишээлбэл: АУДҮ-д тахианы махыг тарагтай үл зохицно гэсэн бол “Идээ ундааны жинхэнэ товч”-д туулайн мах, сам хорхой, улаан гүйлс, загасны шөлтэй үл зохицно гэсэн байна. Энэхүү номнуудын аль алинд нь загасны мах, сүү 2 үл зохилдоно гэж бичсэн байгаа ч “Идээ ундааны жинхэнэ товч”-д гүүний сүү гэж тодотгон бичжээ.

Идээ ундааны жинхэнэ товч”-ийн харшлах идээ ундааны тухай бичигдсэн зүйл нь АУДҮ-н “Цээрлэх идээ ундаа” бүлэгт бичигдснээс их агуулгыг багтаасан байна. Мөн харшлах идээ ундааг мэдээгүйгээс, санамсаргүйгээр идээд хордсон тохиолдолд идээний хорыг тайлах аргын талаар <<Хэмхийг хэтэртэл идээд гэдэс хөөвөөс давс идмэгц даруй арилна. Мөөг далдуугийн зүйлийг идээд хордогдсон үед хөрсийн сүмсээр тайлтугай>> гэм мэтчилэн 18 аргыг бичсэн бөгөөд эмэнд харшлах идээ ундааны зүйлийг ч оруулж өгсөн. Мөн эм уух цээрлэлийг зурхайн ухаантай холбон бичсэн нь онцлог юм.

Хүсэхүй эмч нь Юань гүрний үед амьдарч байсан ордны хоол хариуцсан сайд хүн ба “Идээ ундааны жинхэнэ товч” номоо 1330 онд бичжээ. “Идээ ундааны жинхэнэ товч” нь монгол ахуйд илүү ойр бичигдсэн бөгөөд үүнийг одоо үед нарийвчлан судалж үзэх нь олон талын ач холбогдолтой юм.

Дүгнэлт

1. Хүсэхүй “Идээ ундааны жинхэнэ товч”-д 94 төрлийн хоол зууш, 56 төрлийн тан ширгээмэл, өвчнийг засах 67 зүйл идээ ундаа болон 7 төрөлд хамаарагдах 215 зүйлийн түүхий эдийн талаар бичигджээ.
2. “Идээ ундааны жинхэнэ товч”-д 33 төрөлд хамаарагдах 86 зүйлийн идээ ундааг харшлах идээ ундаа бичигдсэнээс ангилж үзвэл гэрийн тэжээвэр амьтаны зүйл 7, зэрлэг амьтан 2, усны амьтан 7, жимсний зүйл 6, ногоо11, шувуу3, цагаан идээ 2, амуу будаа 4 зүйлийг бичиж тэмдэглэсэн байна. Харшлах идээний зүйлээс хамт идэж үл болох3 8 зүйл, идвээс өвчин үүсэх 20 зүйлийг тодруулж бичжээ..
3. Эм уухад цээрлэх 13 төрлийн эмийн зүйлтэй харшлах 21 зүйлийн идээг бичсэн байна.

Ном зүй:

1. Хүсэхүй “Идээ ундааны жинхэнэ товч” УБ 2005 он Х 1-170
2. “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” Улсын хэвлэлийн газар Х 83
3. Ш.Болд ‘Монгол туургатны анагаах ухааны алдарт эмч, мааранба, мэргэдийн намтар, бүтээлийн тойм’ УБ 1999.Х 151

Сод ухаантан тэнгэрт халивч Үйл нь газарт мөнхөрнө

АУ-ны доктор Я.Ганбаяр агсны 50 насны ойд зориулсан тусгай дугаар

Дурсамж



1982 онд намайг Архангай аймгийн төвийн 1-р 10 жилийн сургуульд 9-р ангид сурахаар ирэхэд 9в ангид Ядамсүрэнгийн Ганбаяр гэдэг жижигхэн биетэй хүү сурч байлаа. Удалгүй 9-р ангийн төмс хураах, ажлаар “Тунгалагтамир хоршоолол”-д явж бид хоорондоо танилцаж үерхэцгээсэн. Я.Ганбаяр маань онц сурдаг бүх хичээлдээ жигд сайн хүүхэд байлаа.

Я.Ганбаярынх аймгийн төвийн зүүн дэнжид байсан учир хичээл тараад явахдаа дотуур байрны хажуугаар заавал дайрч өнгөрдөг, бид хоёр уулзаж хичээл номоо ярилцдаг байв. Бид хоёрын хувьд ахлах ангид орсон, тэгээд ч сурлагааар сайн байсан, цаашдын зорилгоо нэлээд тодорхой мэдэж байсан учир голдуу л хичээлээ ярьдаг байсан санагдаж байна. 10-р ангид байхад Я.Ганбаяр маань ер нь л сурлагаар биднээс илүүрхэж ялангуяа хими, физикийн хичээлд толгой цохиж байсандаа. Тэгээд ч 10-р ангийн конкурсын шалгалтаар химийн хичээлдээ суурилан орж “Анагаах ухааны дээд сургууль”-ийн хуваарийг торолгүй авч байлаа. Сургуульд Я.Ганбаяр биеэр их жижигхэн байсан. Спортын тэмцээнд нэг их оролцоод байдаггүй байв.

Би эдийн засгийн сургуульд орсон учир дөрвөн жил сураад л төгсөж өөр аймагт хуваарилагдан явсан. Я.Ганбаяр маань “Анагаах ухааны дээд сургууль”-аа төгсөөд харин нутагтаа ирж Цэцэрлэг сумандаа их эмчээр ажилласан. Я.Ганбаяр маань Анагаахын дээдээ багшилсан. Харин 1995 билүү 96 оны зун “Мухар хужирт”-ын рашаанд амарч байтал Я.Ганбаяртайгаа тааралдаж түүнээс хойш бид хоёр түүнийхээ амьдралын эцсийн мөч хүртэл нөхөрлөсөн.

Анд маань надад эрүүл мэндийн талаар зөвлөгөө өгч тусалж байсан. Миний охиныг Анагаахын дээд сургуульд суралцаж байхад нь зөвлөгөө өгөх, ном сурах бичиг олж өгөх зэргээр надад тусалдаг байв.

Миний хувьд эмнэлэгт хэвтэх боллоо, рашаан уух боллоо болох уу гээд л тэр болгонд Я.Ганбаярын маань Анагаахын сургуульд нэр хүндтэй эрдмийн багш байсныг тэнд сурч байсан миний охин илүү сайн мэддэг.

Я.Ганбаяр маань даруу төлөв зантай, хүнд тусархаг, нийт ч хүн байсан даа. Найзын маань хийж бүтээж байсан ариун үйл хүн ардад буян тусаа өгснийг бурхны орноос мэдэрч байгаа биз ээ.

Ангийн найз

Архангай аймгийн татварын Хэлтсийн дарга Р.Цэрэннадмид

Я.Ганбаярын тухай П.Батхуягийн дурсамж

Бид 1984 онд АУДС-д элсэж тэр үеийн жаягаар намрын ургац хураах ажилд явж билээ. Бидний 20-иод хүүхэд(Хуатхан: одоо Баян-Өлгий аймгийн хүүхдийн зөвлөх эмч, Гантөмөр: одоо Говь-Алтай аймгийн мэс засалын эмч, Бат-Очир: одоо Баянхонгор аймгийн мэс засалын эмч, Баттөр: одоо Дорнод аймгийн сүрьеэгийн эмч, Хоролсүрэн: одоо Шинэ Анагаах Ухаан Дээд Сургуулийн багш, Бүжинлхам: УБ, Оюунчимэг: одоо Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмнэлзүйн эм судлаач, Энэбиш: Баянхонгор, Цэрэнлхам: Баянхонгор, Бямбасүрэн: УБ, Алтанцэцэг: Өвөрхангай, Цэхэнханд: Баянхонгор, Цогтоо: Өвөрхангай, Шүрэнцэцэг: Говь-алтай, зэрэг олон нөхөдийн хамт) Сэлэнгэ аймгийн Орхон САА-н улсын аварга тариаланч Машков даргатай хадлангийн бригадад хуваарилагдан очив.

Тэдний дунд Архангай аймгаас элссэн бяцхан хүү байсан нь хожмын АУ-ны доктор Ганбаяр багш байсан юм. Миний бие багаа ахлаж явсан тул Ганбаярыг 2 охин 1 эрэгтэй оюутны хамт нэг баг болгон хуваарилав. Хийх ажил нь пресслэсэн өвсийг нуруулдах болон машинд ачих явдал байлаа. Энэ амаргүй ажил байлаа. Давхар байшингийн дайтай нуруулдаж буй өвсөнд 25кг орчим жинтэй пресслэсэн өвсийг сэрээгээр өргөн шидэж өгөх, эсвэл өндөр өвс ачсан машин дээр мөн дээрх ажлыг гүйцэтгэх г.м. Ганбаяр ажилсаг, бас тэвчээртэй гүргэр гэхээр хүүхэд байлаа. Биеэр бидний дундаа хамгийн хамгийн жижиг, өөрөө өвс шиг турьхан хүүхэд боловч дээрх эрийн хүч биеийн тэвчээр шалгасан ажлыг давгүй гүйцэтгээд ядарсан шинжгүй гүйж явдаг байсан. Багуудыг 5 хоног тутамд ажлын гүйцэтгэлээр нь байр эзлүүлэн урамшуулдаг байв. Ганбаярын баг хэд хэдэн ч удаа түрүүлж байсан юмдаг.

Ганбаяр ажлын бус амралтын цагаар ном уншиж суудаг л хүүхэд байсан даа. Хожмын номын хүн болох дүр нь харагдаж л байсан байгаа юм. Их сониуч гэмээр, ажиллаж байгаад элссэн ах эгч нараасаа элдэв зүйл асууж шалгаадаг, бас ч үгүй үүх түүх сонирхож байгаа нь мэдэгддэг байсан шүү. Харин бүжиг хийж чаддаггүй байсан. Хааяа чөлөөт цагаараа дуу хөгжим болон наадахад Цэрэнлхам, Бүжинлхам зэрэг эгч нар нь Ганбаярыг чирч гулдран бүжиг зааж хөгжилддөг байв. Бидний дунд Говь-Алтайн АУДуС төгсөөд ажиллаж байгаад ирсэн одоогийн Баян-Өлгий аймгийн хүүхдийн зөвлөх эмч Хуатхан байсан. Хоёулаа хүүхдийн ангид орох байсан болоод ч тэгсэн үү хоорондоо нилээд дотно байсан. Хуатхан ер нь Ганбаярт их юм заасан байх.

Ганбаяр оюутан болуутаа л шууд онц сурч эхэлсэн билээ. Ажиллаж байгаад ирсэн, аж ахуйд хамт явж байсан нөхөддөө хичээлийг нь ярьж өгдөг албатай болсон байсан. Тэрч эрчээ алдалгүй явсаар төгсөөд удалгүй багш болж улмаар доктор хамгаалсан даа.

Ахлах курсээсээ уламжлалт анагаах ухааныг ихэд сонирхох болсон. Миний бие бас уламжлалтыг нилээд сонирхдог, ном судар нилээд цуглуулсан байлаа. Манайд ирж ном судар их үзнэ, түвэдийг өөрөө идэвхээрээ сурсан байх аа. Нэг л мэдэхэд уншдаг болчихсон манайд ирж хуучны ном судар онгичиж суудаг болсон. Сүүлдээ санскрит ч уншдаг болсон байсан. Тэгж байгаад Дарма маарамбын Манаг-гаржамыг надаас номоор сольж авсан юм даг. Харин Манаг-Гаржамыг хамаагүй ашиглаж болохгүй байна, авшиг авч лүн хүртээх хүн олдохгүй байна хэмээн ярьж байсан санагдана. Ганбаярыг уламжлалт анагаах ухаан сонирхдог болоход аав нь их нөлөөлсөн байх. Ядамсүрэн гэдэг бас ч үгүй ардын анагаах ухааны дөртэй хүн гэж сонсогддог байсан.

Хуучны дэг жаяагийг яг номоор нь сурах гэж хичээж байгаа нь мэдрэгддэг байв. Нэгэн удаа мөнгөн ус номхотгох гээд ширмэн тогоонд хийн будгаар шавж ном ёсоор нь хийх гэж байгаад хордсон тухайгаагаа хожим нь надад хуучилж байсан.

Орчин үеийн анагаах ухааны оношлох эмчлэх арга зүйгээ ч бас номонд бичсэнээр нь ягштал гүйцэтгэдэг эмч болсон билээ. Нэгэн удаа Архангай аймагт ажиллаж байтал мухар олгойн үрэвсэлтэй өвчтөн ирж үзүүлж л дээ. Симптом Шёткин-Блюмберга, Ситковский гээд бүгдийг нь үзэж дуусаад сүүлд нь ялгах оношийн зорилгоор шулуун гэдсээр нь үзэх болж л дээ. Тэгээд бээлийгээ хийгээд шулуун гэдсээр нь үзтэл нөгөө хүн нь бие засах дөхөж байсан юм уу, ямар ч байсан Ганбаяр хуруундаа бөөн том баас өлгөөд ирсэн, нөгөө өвчтөн нь их л гайхаж байсан гэж өөрөө ярьж байсан билээ. Энэ мэтээр үлдээлгүй үзэж оношлодог эмч байв.

Ганбаяр багш болсноосоо хойш ид судалгааны ажлын үедээ Улсын Төв Номын санд ихэд суудаг байв. Монгол Данжуур болон 1981 онд “Dharma Publishing”-d Tarthang Tulku хэмээх хүний удирдан хэвлүүлсэн “The Nyangma Edition of sDe-dge bKa’-gyur\bsTangyur” хэмээх Ганжуур, Данжуурын судраас татаж хэвлэсэн хэвлэлийг уншиж суухад нь олонтоо таарсан.

Тэрээр гүн ухаан ихэд сонирхдог эрдэмтэн байлаа. Нагаржунайн “Хоосон чанарын далан шүлэгт”-г байнга уншдагаа ярьж, гүн ухааны утга агуулгыг биширдэгээ нэг бус удаа ярьж байсан хийгээд Алтангэрэлийн доторх 24-р бүлэг болох анагаах ухааны бүлгийн агуулгыг ихэд үнэлэн ярьж байсан нь тодхон байна.

Ганбаяр анагаах ухааны зэрэгцээ гүн ухаан, Буддын шашны түүх, сургаалын учир утгыг олох гэж ихээхэн хөдөлмөр зарцуулж байлаа. Миний бие дээрх чиглэлээр ихээхэн мохоо тул найман гишүүнтийн зүрхэн хураангуйд гардаг Эсэруа тэнгэр, Төрөлхтөний эзэн тэнгэр, Асвин тэнгэр, Үргэлж мэдэгчийн хөвгүүн, Галчлан орогч зэрэг сургаал айлдсан хэмээгчдийн тухай Ганбаяраас тодруулан асуухад их л тодорхой

хариу хэлдэг болсон байсан. Ерөнхийдөө анагаах ухааны сургаалын өв уламжлалын учир начирьг олчихсон хүн байсан гэж хэлж болно доо.

Уугуул нутаг нэгтийн хувьд ч юм уу, ер нь судалгааны хүрээнд нь ч тэгж таарсан байх, Далай Чойнхор вангийн Лүнрэг Дандарын түүх болон зохиолуудыг нь ихэд нарийвчлан судалсан шинжтэй байсан. Түүний тухайд олонтоо ярьдаг, түүнийг өсөн дэвжих, сургалтын дэг жаягаа шинэчлэн тогтооход түүний багш Идэр голд мэндэлсэн хэмээгддэг Жамбачүлтэмийг ихэд үнэлэн ярьдаг байж билээ. Миний бие Идэр голын хүн болохоор Жамбачүлтэмийн тухай сонирдог, бага сага мэдээтэй байсан. Харин Ганбаяр бол илүү тодорхой нарийн зүйлийг мэдчихсэн сууж байсан шүү.

Ер нь нэгэн үеийн оюутан агсан, номын нөхөр, эрхэм дүү Ганбаяр маань дорно дахины анагаах ухааны сургаалын язгуур уламжлалаас орчин үе хүртэл, түүний гүн ухааны учир начирьг тайлсан нэгэн үеийн бахдал болсон эрдэмтэн байлаа. Номын цагаан буян нь улам арвижин дэлгэрэх болтугай.

АУ-ны доктор, профессор

Нэг курсийн оюутан П.Батхуяг, 2015 он.

Анхны сангийн аж ахуйн дурсамж



Бид 1984 оны намар тэр үеийн нэршлээр АУДэС-ийн Хүүхдийн эмчилгээний факультэтэд элсэн орж сургуульд бүртгүүлсний дараа вагонаар Сэлэнгэ аймгийн Мандалын сангийн аж ахуйд тариа хураахаар очив. Тэр үед ажиллагчдаас тусгай элсэлт авдаг байсан юм. Ажиллаж байгаад орсон оюутануудаас П.Батхуяг (одоо АШУҮИС-ийн эмийн тэнхимийн багш) бид хоёр байв.

Шинэ орсон оюутанууд бие биеэнтэйгээ танилцаж суутал гаднаас ачаагаа өргөсөн жижиг биетэй туранхай шар банди орж ирж мэндлэв. Танилцахад Архангай аймгаас дөнгөж 10-р анги төгсөж элсэтээр ирсэн Я.Ганбаяр гэгч оюутан байв. Тэр үеээс хойш бид дотны байж үргэлж уулзаж яралцдаг ах дүү шиг болсон юм.

Ганбаяр нь гэнэн цайлган сэтгэлтэй, ажилч хичээнгүй, үргэлж инээж явдаг, хурдан шаламгай, цовоо сэргэлэн оюутан байсан билээ.

Тэр чанараараа ч хичээлдээ сайн байж онц дүнтэй суралцаж, улаан дипломтой сургуулиа төгсөж тус сургуульд багшаар үлдсэн юм. Багш болсон хойно ч бид үргэлж утсаар ярьж хаяа хот очихоор уулзалдаж, сэтгэл санаагаа хуваалцаж байдаг байсан юм. Хайрт дүүгийнхээ гэгээн дүрийг үргэлж санаж явдаг юм.

**Дурсамж бичсэн Баян-Өлгий аймгийн Нэгдсэн Эмнэлгийн Хүүхдийн зөвлөх эмч,
тэргүүлэх зэргийн эмч, клиникийн профессор, 1990 онд АУДэС-ийн ХЭФ-ийг
төгсөгч Ш.Хуатхан**

2015.10.12

Я.Ганбаяр эмчээ бид дурссаар явдаг

Монголд ардчилал эд өрнөж байх үед 1990 оны зун манай Цэцэрлэг сумын Хүн Эмнэлэгийн Их эмчийн Салбарын эрхлэгчээр АУДэС-ийг Хүүхдийн эмчээр төгссөн Я.Ганбаяр Эрүүлийг Хамгаалах Яамны сайдын тушаалаар ирж бидэнтэй нэг жил ажилласан юм. Их эмчийн салбар нь эх баригч, дүн бүтээгч, дөрвөн бригад тус бүр нэг бүгд 5 бага эмчтэй, дөрвөн ээлжийн сувилагч, жолооч галч гээд 23 орон тоотой 15 ортой ажиллаж байсан билээ.

Ганбаяр эмч хүүхдэрхүү зантай, намуун зөөлөн дуутай, биднийг эгчээ ахаа та гэж харьцдаг, та нараас сурах юм надад их бий гээд биднээс асууж лавлахын хамт бидэнд эмчилгээний арга, оношийн тухайд зааж зөвлөдөг байв. Эмнэлэгийн нэг жижиг өрөөнд ганц төмөр ортой, гэр орны ойр зуурхан хэрэглэл, сольж өмсөх хэдэн хувцастай, баахан номтой л цомхон амьдардаг байв. Найз нь гэж Зөвлөлтөд сурдаг оюутан гээд мах иддэггүй охин амралтаараа ирж хамт байдаг байв.

Зав чөлөөгөөр тун бага, больницын үзлэг, амбулаторийн үзлэг, алсын болон ойрын дуудлага, бас албан газруудын хурал цуглаан, зөвлөлгөөн гээд суух зав чөлөөгүй ажилладаг байсан. Одоогийнх шиг сумын эмнэлэг төхөөрөмж ховор учир чагнуур, судас барьж оношилдог байв. Өвчнийг судсаар оношлоно гэдгийг огт мэддэггүй байж билээ. Я.Ганбаяр эмч хөдөөний малчдад үйлчлэх “Нүүдлийн ам бултори”-ийг анх суманд ажиллуулж, биднийг ээлжээр багуудад эмийн сантай ажиллуулж малчдад зөвлөлгөө өгүүлж сайшаал, талархал хүлээж урамтай ажилацгаадаг байв.

Бас ХААН нэгдэлтэй ярилцан тохирч “Хүүхдийн сүүний газар”-ыг байгуулж сүү, тараг, ээдэм, төмс луувангийн нухаш бэлтгэх, хэрэглэх аргыг зааж, сумын төвийн болон ойролцоох хүүхдүүдэд өгдөг байлаа. Бас нэрс, аньс, хад нохойн хошуу зэргийг түүлгэж, хоол тэжээлийн хажуугаар цэцэрлэг яслийн хүүхдүүдэд хэрэглүүлдэг болсон юм.

Бидэнд уламжлалт эмчилгээний аргыг хэрэглэж сургахаар зааж зөвлөж, нөхөн сэргээх эмчилгээний анхны суурийг тавьсан эмч юм. Я.Ганбаяр эмч чих зөөлөнтэй, хол ойрын дуудлага ирүүт л шуудхан мотоциклээрээ ч хамаагүй явчихдаг, зан ааш харилцаагаар ард түмнийхээ хүлээл, хүндэтгэлийг хүлээсэн, нэр хүндтэй байсан. Хотод шилжсэн ч манай сумынхан сураглаж очоод үзүүлж зөвлөгөө авч, ямар эмчилгээг хаана хийлгэхээ заалгадаг байсан даа.

Я.Ганбаяр эмч сумын нам, захиргааны дарга нарт эмнэлгийнхээ ажил, ажиллагсдыгаа амьдрал ахуйг сайн ойлгуулж чаддаг байсан нь бидний амьдрал ахуйд

мал мах олгуулах, нэгдлийн хувьчлалаас мал хөрөнгө олгуулж байсныг бид мартдаггүй юм. Мухар Хужиртын рашаанд ирэхээрээ бидэнтэй уулзаж хуучилна, бид ч эргэж очигдож дотно харилцаатай байсан. Я.Ганбаяр эмч минь ид залуугаараа Бурханы оронд заларсан ч түүний ачийг санаж эмчээ бид дурссаар явдаг юм.

Архангай аймгийн Цэцэрлэг сумын Хүн эмнэлэгийн ахмадууд эх баригч Г.Должинсүрэн, дүн бүртгэгч Д.Түвшинжаргал, сувилагч А.Даваасүрэн, Г.Одгэрэл, угаагч С.Тэгшжаргал, жолооч А.Цэрэндэндэв, галч А.Мягмардорж нар. Больницыаа байранд дурсамжаа бичиж, зургаа авахуулж илгээв. 2015.10.05.



баруун гар талаас: Дүн бүртгэгч бага эмч
Д.Түвшинжаргал, Сувилагч Г.Одгэрэл,
Жолооч А.Цэрэндэндэв, Галч

Эгэл мөртлөө шантрашгүй залуу байлаа

Миний бие Архангай аймгийн Цэцэрлэг суманд сум нэгдлийн даргаар 1986-1992 он хүртэл ажиллаж байлаа.

1990 оны зун, сумын хүний их эмчийн салбарын эрхлэгч их эмчээр туранхай цагаан залуу томилогдон ирж өөрийн хүсэл зорилго танилцуулж байсан тэр залуу бол өнөөгийн анагаах ухааны доктор, уламжлалт монгол эмнэлэгийн нэрт оточ-эмч Ядамсүрэнгийн Ганбаяр байлаа.

Тэр өөрийнхөө аж амьдралын тухай ер ярихгүй, дандаа эмнэлэг, эмчлүүлэгчид, ажиллагсад, малчдын тухай санаа авсан, шийдвэрлэвэл зохих асуудлуудыг сэдэж ярьдаг байснаар бид дотно ажиллаж билээ.

Тухайлбал түүний хүсэлт болгосноор эмнэлэгийн дэргэд эхчүүдийн амрах байрыг, хүүхдийн сүүний газрын хамт байгуулж билээ. Амаржих эхчүүдийг 14 хоногийн өмнө авчирч тус байранд \гэртээ байдаг нөхцөлтэй\ байлган эмчилгээ сувилгаа хийдэг болсноор гэрийн төрөлт гардаггүй болсон. Амаржисан эхийг 7 хоног асарч сувилан уул эхэд шөлний хонь, хүү төрсөн бол унага, охин бол тугал өгч нэгдлээс хүргэдэг болж билээ. Эмнэлэгт эмчлүүлэгчдэд зориулан нэгдлийн зүгээс 1-р зэргийн үхэр, хонины мах, эрлийз үнээний сууриас өдөр бүр шинэ сүү нийлүүлж байсан нь Я.Ганбаярын сэтгэл өндөр ажиллахад тус болж байсан байх.

Ажиллагсдын хүнсний захиалгыг 1-р багийн дарга Ч.Дамдинтай гэрээ байгуулан төмс, ногоо, мах, малаа авдаг байснаар эмнэлэгийн хамт олон тэнд төл бойжуулах, ургац хураахад тусалдаг болсон нь цоо шинэ ажил болж билээ.

1991 оны хавар мал хувьчлахад Я.Ганбаяр эмч нэгдэлчдийн хуралд санал оруулж эмнэлэгээ 300 бог, 10 үнээ авч малчин олж маллуулан эмнэлэгийн өөрийн аж ахуйтай болох эхлэлийг тавьсан юм.

Мөн 1990 оны 12-р сард Цэцэрлэг сумыг барилгажуулах зураг төслийн ажил эрхлэхэд 30 ортой иж бүрэн эмнэлэг бариулахаар болж 1991-оны 4-р сард тус эмнэлэгийн шавийг тавихад Я.Ганбаяр эмч идэвхтэй ажиллаж билээ.

Уул барилгын суурийг тавиад орхигдсон ч 2010 онд түүний мөрөөдсөн эмнэлэг ашиглалтад орсноор тус сумын эмнэлэг тохижсон орчин цагийн эмнэлэг болж ард иргэд Я.Ганбаяр эмчийг дурдсаар явна. Тэрээр эмчлүүлэгчдэд маш уян зөөлнөөр хандаж эмчилгээ сувилгаа явуулж, зарим архаг хүнд өвчтөнд монгол тан уулгаж бариа засал хануур төөнүүр ч хийж эдгэрүүлдэг байснаар “Алтан гартай эмч гэж ганцхан жилийн дотор алдаршиж байлаа.

Надтай хамт хэдэн удаа малчдын хот-айлаар явсан юмдаг. Я.Ганбаяр эмч машинаас буугаад л ахмад настан, өвчтэй хүнтэй айл руу орж тэдэнд үйлчилгээ үзүүлж, маш сайн дотно зөвөлгөө өгч, эдгэрэх урам хайрладаг сэтгэл зүйч эмч байсан юм. Тэр үед амьдарч байсан Жаргалант сумын нэрт оточ Дэмчиг, Дүгэр, Пүрэвдорж болон Цэцэрлэг сумын Дорждан тэргүүтэй лам хуваргуудтай Я.Ганбаяр дотно танилцан тэдний шавь болж ном судрыг авч ажлын чөлөөгөөр, шөнө дөл болтол хуулан бичиж, сурсан номоо шалгуулж байхыг би олонтаа харсан. Жаргалант, Цэцэрлэг сумын нутагт ургадаг эмийн

ургамал, эрдэс \хужир\ -ийг түүж Хануй, Хужиртын рашааны дээжийг шинжлүүлэн ард олны аман яриа, дом бор арга эмчилгээг чухалчлан тэмдэглэдэг байсан юм. Эрдэм номонд дуралж, хүн олондоо тусалж явсан Я.Ганбаяр эмч шиг тийм хичээнгүй, зүтгэлтэй бурханлаг энэрэнгүй эмч хүнийг өнөө хүртэл олж хараагүй явна.

Түүний тусч, энэрэнгүй хийгээд хүний оюун ухааныг ер бусаар эзэмдэх ид шидийг ба өнөөдрийг хүртэл биширч явдаг. Би түүнээс Төвд бичиг сурахад хэцүү юу гэж дотгочлон асуухад сурая гэвэл сурч болно шүү дээ гэсэн юм. Тэгээд удалгүй шилжээд явчихсан. Миний бие 1995 оны намар өвдөж Улаанбаатар хот ороод Я.Ганбаяртай утсаар холбогдоход тэр намайг УБ сувилал дээр маргааш ирэхийг урив.

Я.Ганбаяр намайг 21 хоног уламжлалт эмнэлгээр эмчилж эрүүл саруул болгосноос хойш 20 жил өнгөрч буй. Би 70 гарч эрүүл энх явна. Я.Ганбаяр эмч маань 2003 оны 3-р сард надад “Төвд хэл бичигт суралцах дэвтэр” номоо шуудангаар явуулсан нь миний ярьсныг мартаагүй байсных биз. Би төвд бичгийг өнөөдөрч сурахыг хичээж явна.

Ийм сайхан эрдэм төгс хүүг төрүүлж өсгөж, уламжлалт эмчилгээ, Төвд бичигт хөтөлсөн түүний аав өндөр настан, АИХ-ын депутат Т.Ядамсүрэн гуайдаа урт насалж бүтээл туурвил арвин байхыг ерөөе. Мөн эрдэмтэн Я.Ганбаяр агсны үйл хэргийг үргэлжлүүлж, түүний бүтээлүүдийг хэвлэн ашиглаж буй АШУИС-ын Уламжлалт эмнэлэгийн сургуулийн эрдэмтэн багш нарт баярласнаа илэрхийлье.

**Архангай аймгийн Цэцэрлэг сумын нэгдлийн дарга асан АИХ-депутат
Ё.Давааням**

Нэгэн үеийн эмчийнхээ тухай бид дурсахуй.....

Монгол улсад 1980 оны сүүлчээс эхлэн Уламжлалт анагаах ухааны тухай ойлголт ил болж олон хүн, эмч нар сонирхож эхэлсэн байлаа. Анагаах ухааны их сургууль 1993 онд уламжлалтын анагаахын ангийн анхны төгсөлтөө хийж байлаа. Мөн богино хугацааны дамжаанууд хичээллэж уламжлалт анагаах ухаанд сонирхолтой эмч нар орж суралцаж байсан үе.

Миний бие 1993 оны уламжлалт анагаахын анхны төгсөлтийг төгсөөд шууд Монгол Эмнэлэг Сувилалын Төвд эмчээр орж ажиллаж билээ. Тэр үед уламжлалтын тусламж үйлчилгээг орчин үеийн анагаах ухааны үзлэг оношлогоо, эмчилгээг хослуулах зорилготойгоор нарийн мэргэжлийн эмч нарыг бэлтгэж байлаа. Иймээс намайг зүрх судасны эмчээр, Ч.Мөнхчимэгийг эмэгтэйчүүдийн эмчээр бэлтгээд ажиллуулсан юм. Тэр үед Я.Ганбаяр эмч 1994 оны 1 сард рентгений эмчээр ажилд орж билээ. Ажилд орсон цагаасаа Я.Ганбаяр маань манай эмнэлгийн эм сайн барьдаг элэгсэг, эмчлүүлэгчдэд чин сэтгэлээсээ ханддаг эмч байлаа.

Д.Энхжаргал эмч Я. Ганбаяр эмчтэй Монгол эмнэлэг сувилалын төвд анх нэг тасагт ажиллаж, сүүлд багш болоод ч хамтарч ажиллаж байсан. Монголын уламжлалт анагаахын эмч гэдэг утгаар судас сайн барьдаг, эм нь оновчтой таардаг, чадварлаг эмч байсан. Аливаа ажилд сэтгэл зүрхээ зориулж хийдэг нь бидний сэтгэлд үлгэр дууриалал болон үлджээ.

Ганцхан дурсамжийг эргэж санахад Я.Ганбаяр багш 5 рашаанд өвчтөнг оруулах дуртай. Ялангуяа унадаг өвчтөнг оруул гэж зөвлөдөг байв, тэгээд 5 рашааны найрлагын задалж номноос уншихад Өргөст арц (*Efedrum nigrum et sibiricum*) нь таталтын эсрэг үйлчилгээ үзүүлдэг болохыг оросын эрдэмтэд нохойн дээр судалжээ. Төв мэдрэлийн тогтолцоог номойруулж, нугасны рефлексийн сэрлийг, гөлгөр булчинг сулруулах үйлчилгээ үзүүлдэг тухай бичжээ.

Я.Ганбаяр аливаа юманд их хянуур, эмчийн уран торгон мэдрэмжтэй, тухайн цаг үедээ сайн эмнэлзүйч байжээ. Тухайлбал анх удаа туйплан эмчилгээг хийж байлаа, эрдэнийн эмийг ч зааврын дагуу сайн өгдөг байсан.

Я.Ганбаяр маань туйплан эмчилгээний анхны өрөөг 1997 онд байгуулж туйплан эмчилгээг хатуу дэглэмээр уулгаж эмчилсэн манай анхны эмч. Энэ эмчилгээний дүнд тухайн үед системний өвчнөөр хэвтэрт байсан өвчтөн Д.Мөнхтуяа “өвчин дахин сэдэрлгүй хөл дээрээ босоод одоог хүрч байна” гэж дурсаж байдгийм.


Мөн үүнтэй ижил манай Я.Ганбаярын эмчилсэн олон хүмүүс байдаг. Бас нэг ойрын жишээ бол манай ажилтан Х.Оюунгэрэлийн ээж 81 настай байхдаа анх элэгний

хорт хавдартай гэж оношлогдоод 3 сарын л настай гэж ХСҮТ-с гарсныг тухайн үед Я.Ганбаяр эмч эм уулгаж 2 жилийн турш эмчилж нэг удаа ч ёо гэж өвдөөгүй өвчингүй байж байгаад бурхан болсон шүү гэж одоо дурсаж байна. Бид заримдаа өөр хоорондоо яриад сууж байхад зарим нэг дурсамжууд мартагддаггүй юм. Тухайлбал Ганбаярын маань мөрөөдөл биелэлээ олсон гэж Д.Шинэтуяа эмчийн ярьсаныг бичихэд

Д.Шинээ эмч 1994 оны хавар 4 сард манай эмнэлэг сувилалын төвд тасгийн эрхлэгч Д.Энхжаргал эмчтэй 2-р тасагт эмчээр орж ирэхэд 3 давхарын одоогийн 1 палат тэр үед эмч нарын өрөө байлаа. Бидний өрөө дамждаг, цаад өрөөнд нь Я.Ганбаяр, Ц.Нарантөгс эмч нар, наад өрөөнд нь Д.Шинэтуяа, Ч.Сэлэнгэ эмчтэй хамт суудаг байсан. Эмч нар эмээ өөрсдөө хийдэг, эмчлүүлэгчдээ эмээ өгдөг ийм үе байлаа.

Я.Ганбаяр маань дуу цөөтэй, эмчлүүлэгч нар өрөөнөөс нь салдаггүй эмч байлаа. Бид нэг удаа өдрийн цайгаа уугаад сууж байхдаа мөрөөдлөө ярьцгаалаа, үүнээс Я.Ганбаяр эмчийн мөрөөдөл тод үлджээ. Манай эмнэлэг хотоос зайдуу тухайн үед нийтийн тээвэр ховор, тэр дундаа манайх руу автобус явдаггүй, зайсангийн автобуснаас буугаад ажил руугаа явахад байшин, хороолол баригдаагүй зэлүүд байлаа.

Энэ үед Я.Ганбаяр бид бүгдээрээ машинтай, хамгийн урд талын машин маяктай бас болоогүй ээ Монгол эмнэлгийнхэн гэсэн дарцаг хийсгээд л зүүн тийшээ гараад явнаа тэгээд машины зогсоолоо одоо байгаа амьтны байрны урд байгуулаад эгнүүлээд тавина гэж ярьдаг байсан юм.



Одоо энэ зураг шиг манай эмч ажилчдын машин гаднаа эгнээд , хамт олон маань өдрөөс өдөрт өсөж өргөжин залуу халаа маань биднээс эрч хүчтэй уламжлалт анагаах ухаанаа хөгжүүлэхийн төлөө зүтгэж байна.

Дурсамж бичсэн. Д.Баярмаа, Д.Шинэтуяа, Д.Энхжаргал

Зорилгоо биелүүлэх гэж чин сэтгэлээсээ мэрийдэг байсан

Я.Ганбаярыг хүүхдийн ангийн оюутан байхаас нь мэддэг байлаа. Тэр дуугуйхан, хичээлдээ сайн, нямбай оюутан байсан. Хүүхдийн эмчийн ангийг амжилттай сайн төгссөн түүнийг тэнхимдээ багш болохоор бэлтгэгдэн Архангай аймагт 1 жил ажиллахаар явсан гэх сурагтай байсан боловч эргэн ирэхдээ өөр тэнхимд багшилахаар болсон байсан бөгөөд тэр тухай хожим асуухадби уламжлалт анагаах ухааны чиглэлээр цаашдаа ажиллах сонирхолтой байсан болоод... гэж хариулж байсан. Үнэндээ ч хэдэн жилийн дараа уламжлалтын эмнэлэг нээгдэхэд эмчээр орж улмаар манай тэнхимд багшаар ирж билээ. Я.Ганбаяр багш бид хоёр 2000 оны эхээр Энэтхэг улсад мэргэжил эзэмших сургалтанд хамт явсан юм.

Энэтхэгийн Дерадуна хэмээх хотод Сажаринбүүчийгийн харьяалалын газарт 2 тусдаа 6 сар байхдаа өдөр бүр утсаар ярьж, 7 хоног бүр түүнийг дуудан хоол хийж өгч яг л эгч дүү нар шиг байсан. Энэ үед л Я.Ганбаярыг өөрийн гэсэн бодолдоо их үнэнч түүнийгээ хамгаалахын төлөө хэнд ч бууж өгөхгүй бас түүндээ хүрэхийн төлөө ямар их чармайлт гаргадаг байсныг мэдсэн. Би энд ирсэн цаг хугацааг дэмий өнгөрөөхгүй ямарч болсон эргээд харахад харамсахгүй юм хийнэ гэж ярьдаг байсаны нэг нь англи, санскрит хэл дээрхи уламжлалт анагаах ухааны номуудаас орчуулж унших ажил байсан.

Я. Ганбаяр ...Өөрийнхөө байрладаг байрны дээрхи талбай дээр байгаа усны том савны сүүдрийг дагаад өдөржин сууж ном уншаад өдрийн хоолоо ч идэхээ мартаад нэг мэдэхэд л наргүй болчихсон байдаг юм гэж ярьдагсан. Энэтхэг орны их халуунд гадаа суугаад ном унших нь бүү хэл дотор байгаад өдөр өнгөрөөх ч хэцүү байхад яаж тийм их тэвчээр гаргадаг байсаныг одоо ч гэсэн би гайхдаг юм. Их зүйлийг мэдэх гэсэн их зүйлийг амжуулах гэсэн хүсэл нь л тэгж хөтөлсөн байхдаа.

Тэр монгол хүн гэдгээрээ дандаа бахархдаг байсан. Өөртэйгөө хамт ойролцоо амьдардаг төвд, энэтхэг хүмүүстэй элдэв сэдвээр ихээхэн маргалдана. Мэдээж хүн болгон л өөрийн улс үндэс яс угсаагаа магтана. Тэр болгонд монгол хүн сайн, монгол улс сайхан гэдгийг тэдэнд мэдрүүлэх гэж янз бүрээр үзнэ. Нэг удаа төвд ламтай хамт өндөр ууланд гарч Гималайн сүрлэг уулсын барааг харна гээд хамт явсан боловч элдэв сармагчин дүүрэн гүйлдсэн бас ч зэрлэг амьтан их байдаг гэх тэр уулны бэлд очоод нөгөө төвд нь зориг хүрэлгүй буцацгаая гэхэд нь монгол хүн зорисондоо заавал хүрдэг юм. Харин чи намайг бууж иртэл хүлээгээрэй гээд ганцаараа дээшээ мацжээ.

Хэдэн цаг зүтгэж байж уулын орой дээр гараад Гимлайн уулсын сүрлэг барааг холоос харж, хийморийн дарцаг уячихаад эргээд бууж явахдаа би жаахан айсан шүү. Гэхдээ ямарч болсон төвдийн дэргэд би монгол хүн гэдгээ харуулсан гэж ярихад ньзоригтой хүн болох гэж байж хүний нутагт үхвэл яана гээд зэмлэж билээ. Дараа нь энэ тухайгаа надтай хамт байсан багш нарт ярихад ...тэр ууланд чинь элдэв зэрлэг

амьтан байдаг гэж айгаад нутгийн хүмүүс гардаггүй юм гэхэд ... монгол нутгийн тэнгэр өршөөж байхгүй юу гээд инээж байж билээ.

Аливаад сэтгэлээсээ ханддаг байсан намуун зөөлөн ааштай эрхэм сайн шавь минь энэ хорвоод наслах тэр цөөн жилүүдэд ихийг бүтээх гэсэндээ тэгж их яардаг байсан юм боловуу даа

Доктор профессор С. Сэдэдулам

Багш тандаа мөргөмү

Я.Ганбаяр багш маань бидэнд Төвд хэл, Эмийн ургамлын дадлагын хичээлүүдийг чанартай явуулдаг байсан. Оюутнуудтайгаа дотно, өөриймсөг харьцдаг байсан бөгөөд эмийн ургамал болон хэлний мэдлэг (төвд, санскрит орос англи гэх мэт) өндөр хүн байсан. Гаанжуур, Данжуур сударын орчуулгын ажлыг эхлүүлсэн билээ. Бид Я.Ганбаяр багшийн хөдөлмөрч хичээнгүй сайхан зан чанарыг дурсан санасаар явна.

ЭМШҮИС- ийн Уламжлалт анагаах ухааны сургуулийн 2008 оны төгсөлт 601-р группийн шавь нараас нь

Багш тандаа мөргөмү

Хайрт багшийнхаа 50 насны ойд зориулав

Жил бүрийн багш нарын баяр дөхөөд ирэхэд хэдэн сайхан багш нарыгаа дурсахын сацуу орь залуу, ид хийж бүтээх үедээ хорвоог орхисон багшийгаа санаж сэтгэл хөндүүрлэдэг билээ.

Багшийнхаа 50 насны ой болох гэж байгаатай холбогдуулан сэтгэлийн хөндүүрээ бага ч гэсэн намдаахаар шийдэн хэдэн өгүүлбэрийг арай ядан холбон тэрлэлээ. Сэтгэлээс уяатай олон дурсамжууд байдгаас орхигдуулан дулимаг бичсэн бол ангийн нөхдүүд өршөөнө бизээ.

Сурагчын ширээнээс Анагаахын сургуулийн том босгыг алхаж оюутны амьдралын хөгжилтэй хөөртэй, баяртай гунигтай “сунайсан” урт 6 жилийг хамт суралцаж байсан найзууд, ангийн багшгүйгээр төсөөлөхийн аргагүй.

Анх багштайгаа танилцсан түүх сонин. Манай ангийнхан гэж холимог нөхдүүд ёстойл Монгол улсын 21 аймгаас ирээд бүрдчихвүү гэмээр хөдөөний голдуу, ихэнхи нь оюутны байранд амьдардаг хүүхдүүд байж билээ. Дөнгөж оюутан болж ирээд учраа олохгүй төөрч будилах, хичээлийнхээ учрыг ойлгохгүй бидэнд манай ангийн “Даасан” багш хэн гээч нь юм болоо гэсэн асуулт хүн бүрт байв. Нэг өдөр Уламжлалтын сургууль дээр багш, оюутнуудын танилцах үдэшлэг товлогдон удаан хүлээсэн ангийн багштайгаа уулзах завшаан тохиолдлоо хэмээн манай ангийнхан ч уухайн тас, мэдэхгүй зүйлээ асууна, барина гэсээр “комоороо” яваад очиход 5,6 дугаар курсын оюутан боловуу гэмээр залуухан шар залуу угтсанд бид хэрэндээ голж билээ.

Гэвч бидний багш анх харсан, сэтгэлд бууснаас шал өөр хүн байсан юмдаг. Багш минь шалмаг хурдан хөдөлгөөнтэй ч дуу цөөтэй, зарчимч, хаяа нэг дуугарахаараа жинтэй, нэгийг бодогдуулсан үг хэлнэ, арвин их мэдлэгтэйн дээр бурхны ном, төвөд хэлэнд нэвтэрсэн хамгийн гол нь хэзээ ч өөрөөсөө урваагүй бидний хэлдгээр “төгсөрцөн” хүн байжээ.

Бидэнд “Монгол эмнэлгийн онол” гэдэг хичээл ордог байсан үе.. Хичээл маань Улаанбаатар сувилалын салбар дээр ордог байсан ба багш биднээс цаг баримтлахыг ямагт шаардана. Өвлийн ес ид тачигнасан хүйтэн үед Туул голын жаврыг сөрөөд гүйхээрээ ороход багш 8 цаг болсон гээд хаалгаа түгжээд оруулахгүй шүүдээ. Цөөхөн хүүхэдтэй байсан ч хичээлээ эхлэнэ. Багшийн хичээл заах нь гайхамшигтай. Учир үл ойлгогдох үг өгүүлбэр, төвөд үсэг бүрийг жишээ аван үлгэр домог мэт ярин тайлбарлана. Юм их цээжлүүлнэ. Эрүүл бие”- гээс авахуулаад “Үзэх шинжлэх” хүртэл

9 мод навч цэцэг, үр жимстэйгээ одоо ч цээжинд тод үлдсэн хэдий ч түүнээс илүүтэй тэр хичээлээс зөв амьдрах, зөв төлөвшлийг бид олж авсан гэж боддог.

Дараа жил нь багштайгаа хамт эмийн ургамлын дадлагад хамт гарч билээ. Өглөө нь гарахдаа энэ харагдаж байгаа уул руу гарна гээд явна. Багш алхахдаа гарамгай, хээр талд гарахаараа сэтгэл нь баясаад алхаад л байнадаа, тэнд тийм ургамал байна энд чиг л ийм цэцэг байна гээд л баланд дуртай зөгий адил улам цаашлан алхана хэдэн уул дамнан явжаад оройнь ирээд жишим ч үгүй сууж л байна. Бид битүүхэндээ ялархаж, уурлаад багштай дуугарах ч үгүй.

Эцэг эхдээ эрхэлж байгаа мэт тунирхан гомдоно. Багштайгаа нэг удаа айхтар муудалцаж билээ. Бүх хэрэг галын наадам хийнэ, хийхгүй гэснээс болж мандаж ангийнхан маань бүгд нэг тал, харин багш ганцаараа. Байшиндаа орж унтахгүй ээ, гадаа суугаагаараа унтана гээд би зөрүүдлэнэ. Багш: - Ор чи, яасан муухай зөрүүд хүүхэд вэ гээд аашилна. Зарим нэг нь эсэргүүцэл зарлаад юу ч дуугарахгүй нэг хөөтэй тогоог дахин дахин өнгөлөөд л суусан нь марзан. Хэрийн юманд дуугардаггүй багшийн дотогшоо ертөнцийг манай ангийнхны санасандаа хүрч байж санаа нь амардаг, зөрүүд зан үе үе нээдэг байжээ.

Гэвч дадлагын төгсгөлд бид бүх эмийн ургамлуудаа мэдээд зогсохгүй бие биенийгээ хэдэн ургамлуудын нэрээр хочлоод харьсан юмдаг. Хөдөлгөөн муутай нэгнээ “Үлд өвс”, туранхай тунай муутай нэгнээ “Нүцгэн намуу” гэхчлэн шоолно. Багш маань инээд муутай, хочнуудыг сонсоод инээдээ нуух мэт тэрүүхэндээ хихихи гээд амаа мушилзуулан, шар нүүр нь улайж ирээд л инээдэг байж билээ.

За тэгээд багш маань бидний амьдралд бишгүйдээ “хутгалдсандаа”... Бидний хичээлийн төдийгүй амьдралын асуудлыг ойлгоно. Нэг удаа бид нэгэн “ууртай” багшийн хичээлийн шалгалтыг ангиараа таслаад яах ч аргагүй байдалд орж билээ. Багш минь мөн л шар нүүрээ улалзуулан хөөцөлдөн гүйж, биднээс хэдийг нь Гандан явж ном уншуулаад ир гээд даалгавар өгөн явуулж билээ. Түүнээс хойш бид жоохон асуудал гарахын төдийд Ганданд байдаг Гаваагынхаа лам ахыг зүглэнэ, бидний ажил ч сайхан бүтэж үр дүн нь сайн нөлөөлж байгаа мэт санагддаг байсымдаг.

Одоо бодохнээ багш минь дэндүү зөөлөн, дотроо шударга бус зүйлтэй хэзээ ч эвлэрэхгүй гэж боддог ч, ямагт өөртөө багтаан өршөөн нигүүлсэж чаддаг хүн байжээ. Залуучуудыг хөдөлгөж чаддаг, урамшуулан магтана, болохгүй зүйл гэж байхгүй, өөрийгөө ялан дийл гэх мэт үгнүүдийг харамлахгүй хэлнэ.

Бид анги дэвшихийн хэрээр улам дотно болж баяр тэмдэглэх болохоор багшийгаа ятгасаар, бараг чирсээр дагуулаад явна. Манай багш бүжиглэнэ гэхийг харин

үзүүлээд өгнө дөө. Бид багшийнхаар очих дуртай, ороход нэг л тайван ертөнц. Олон зүйлийн эмийн ургамлын тансаг үнэр арц хүжийн үнэртэй холилдон үнэртэж багш минь хөглөрсөн их номын дунд суугаад Архангайн сүүн хуруудаар биднийг дайлна.

Багшийгаа номоо хэвлүүлэх гэж байгаа гэхэд нь бөөнөөрөө очоод шөнөжингөө туслана, багш нь зун гэртээ засвар хийнэ гэхэд нь бөөнөөрөө очоод шохойдоод өгнө. Нэгэн бодлын багш минь биднийг их ойр дотно найзлуулахад их үүрэг гүйцэтгэжээ. Хэдэн шавь нь одоо ч амьдрал дээр маш сайн найзууд бөгөөд өөр өөр чиглэлийн ч гэлээ салбар бүртээ амжилттай ажиллаж, амьдралын сайхныг амталсаар явна. Багшийгаа “явсны” дараа нөгөө хожигдохоосоо айгаад яаран гүйхээрээ ордог ачит сургууль минь очиход нэг л хоосон санагдаж байсан гэдгийг нуухгүй ээ.

Багш бидний сүүлийн уулзалт түүний “Анагаах Ухааны Доктор” цол авсан өдөр нь байсан. Угийн дуу цөөтэй багш минь бидэнд эргээд уулзахгүй гэсэн мэт ямар их зүйлийг ярьж ойлгуулан, үнэтэй зөвлөгөөнүүдээ өгсөн юм бэ ... Ангийнхан маань ихэнхи нь амьдрал зохиочихсон багш бидний ярьж байгаа сэдэв ч амьдрал руу илүү хандаж байсан ба тэр өдөр бид салж ядан, удаан хүүрнэн ярилцаж суусан. Сүүлийн сар багш нь нойр муутай, их ядарлаа гээд нэг л гундуухан, нүүрэнд нь зөндөө үрчлээс тодорсон харагдсансан. Одоо харьж амрана биздээ гэхэд Гандан орчоод харьж сайхан унтнаа хэмээн бидэн рүү харан инээгээд автобусанд суугаад явсандаа. Бид дахин уулзалдаагүй...

Дэлхийн өндөрлөгт Ази эрдэмтэн Уламжлалт Анагаах Ухаанаар Нобелийн шагнал авч чадаж байгаа өнөө цаг үед “Оройн Дээд Шүтээн Багш” та минь байсан бол их зүйлийг хийх байсандаа гэдэгт шавь бид огт эргэлздэггүй ээ.

Багшийгаа 30 хэдэн нас руу дөхөх тусам багш минь хар залуугаараа олон эрдэмд нэвтэрсэн жинхэнэ гэгээрсэн, өөрийгөө ялсан “Онцгой” хүн байжээ гэдгийг мэдрэн биширнэм...

Бурхны оронд заларсан ч гэлээ таньдаа Багш нарын баярын мэндийг хүргье!

2005 оны төгсөгч, Шавь М.Энхжаргал

2015.09.30, Тайпэй хот